

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр, Лхагва гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

|                                          |      |
|------------------------------------------|------|
| <b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>        | 1-5  |
| <b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b> | 6-72 |

---

|                                                                                                                                                                                                                                                                                                                    |       |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------|
| <b>1.Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төсөл</b> /Засгийн газар 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./                            | 6-42  |
| <b>2.Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл</b> /Засгийн газар 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./ | 42-55 |
| <b>3.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан</b>                                                                                                                                                                                                                                      | 55-67 |
| <b>4.Үндэсний аудитын газрын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан</b>                                                                                                                                                                         | 67-72 |

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны 04 дүгээр сарын 16-ны өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 16 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Баясгалан;

Чөлөөтэй: З.Мэндсайхан;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Б.Заяабал, Ж.Түвшин.

**Нэг.Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төсөл** /Засгийн газар 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газрын Худалдааны бодлогын хэлтсийн дарга Э.Нямбаяр, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Баттуяа, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг гүйцэтгэгч Ж.Соёлмаа, мөн яамны Олон улсын худалдаа, эдийн засгийн газрын захирал Г.Өлзийсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Төр-Од, мөн танхимын Гадаад худалдаа, экспортыг дэмжих төвийн ахлах шинжээч Д.Адъяасүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр танилцуулав.

Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Батжаргал, О.Номинчимэг, Н.Алтанхуяг, Д.Батлут, Да.Цогтбаатар, Х.Булгантуяа, Д.Батбаяр, Г.Дамдинням, Т.Аубакир нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Төр-Од нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийг хаалттай горимоор хэлэлцэх горимын санал гаргав.

**Ц.Даваасүрэн:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 13

Бүгд: 19

31.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийг хууль санаачлагчид буцаах горимын санал гаргасан боловч санал хураалт явуулаагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, О.Номинчимэг, Х.Булгантуяа, Г.Дамдинням, П.Ганзориг, Ж.Батжаргал, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийг хэлэлцэхийг хойшлуулах горимын санал гаргав.

**Ц.Даваасүрэн:** Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 9

Бүгд: 19

52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул дээрх асуудлыг хойшлуулав.

Уг асуудлыг 12 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харьцааны сайд Б.Батцэцэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Г.Өлзийбүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай, мөн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан танилцуулав.

Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Н.Алтанхуяг, Г.Дамдинням, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Н.Алтанхуяг, Г.Ганбаатар, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

**Ц.Даваасүрэн:** Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 10 |
| Татгалзсан: | 9  |
| Бүгд:       | 19 |

52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Г.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Б.Чойжилсүрэн нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 19 гишүүнээс 14 гишүүн дэмжиж, 73.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 09 минутад дуусав.

**Гурав.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, ахлах референт Б.Одмандах нар байлцав.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Н.Алтанхуяг, Б.Мөнхсоёл нарын тавьсан асуултад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэв.

Уг асуудлыг 13 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

**Дөрөв.Үндэсний аудитын газрын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Эрсдэлийн удирдлагын газрын захирал Д.Отгонбаяр, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа, менежер Д.Нэргүйбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Ү.Амарбат, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Үндэсний аудитын газрын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Үндэсний аудитын газрын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэв.

*Уг асуудлыг 14 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 3 цаг 44 минут үргэлжилж, 25 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 00 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
10 цаг 16 минут.

### **ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

---

**Ц.Даваасүрэн:** Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье. Хуралдаанд ирэх ёстой 25 гишүүнээс 13 гишүүн ирсэн, ирц 52 хувьтай байгаа учраас Төсвийн байнгын хорооны 2025 оны 4 сарын 16-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Ирсэн гишүүдийг би та бүхэнд танилцуулна. Чойжилсүрэн гишүүн ирсэн байна. Алтанхуяг гишүүн ирсэн байна. Ганзориг гишүүн ирсэн байна. Цогтбаатар гишүүн ирсэн байна. Батцэцэг гишүүн ирсэн байна. Батжаргал гишүүн ирсэн байна. Батлут гишүүн ирсэн байна. Болормаа гишүүн ирсэн байна. Булгантуяа гишүүн ирсэн байна. Мөнхсоёл гишүүн ирсэн байна. Батболд гишүүн ирсэн байна. Ганхуяг гишүүн ирсэн байна. Миний бие ирсэн байна. Ингээд ирц 52 хувьтай байна. Өнөөдрийн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэхээр та бүхэнд танилцуулж байна.

Эхний асуудал Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төсөл. Энийг хэлэлцээд Аюулгүй байдал, гадаад, бодлогын байнгын хороонд саналаа хүргүүлнэ.

2.Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл.

3.Тогтвортой байдлын зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан сонсоно.

4-д, Үндэсний аудитын газрын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг сонсоно.

Ийм 4 асуудал байна. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу, хэлэлцэж байгаа асуудлаар?

Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

**Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо түүний гишүүн орнуудын хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийг хэлэлцэж эхэлье.**

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг би та бүхэнд танилцуулаадахъя. Гантөмөр сайд, Тэргүүн шадар сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд, Эдийн засгийн хөгжлийн

яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү, Эдийн засгийн хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга Анар, Эдийн засгийн хөгжлийн яамны Макро эдийн Засгийн газрын дарга Л.Энх-Амгалан, Эдийн засгийн хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газрын Худалдааны бодлогын хэлтсийн зөвлөх Э.Нямбаяр, Гадаад харилцааны яамны Гэрээ эрх зүйн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч Ж.Соёлмаа, Гадаад харилцааны Олон улсын худалдаа, эдийн Засгийн газрын дэд захирал Д.Золзаяа, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын дарга Ж.Нарантуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн. Хөдөө аж ахуйн яамныхан байна уу? За, урагшаа суучих Болорчулуун энэ тэр. Монгол Улсын, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч л Төр-Од. Төр-Од байгаа юм уу? Төр-Од байна уу танхимын дарга? Танхимын даргыг дуудчих. Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын гүйцэтгэх захирал түр орлон гүйцэтгэгч Л.Батсайхан. Эдийн засгийн хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газрын Худалдааны бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Баттуяа, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Гадаад худалдаа, экспортыг дэмжих төвийн ахлах мэргэжилтэн тэгээд Адьяасүрэн гэсэн ийм хүмүүс оролцож байна.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо түүний гишүүн орнуудын хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр танилцуулна. Гантөмөр сайдын микрофоныг өгье. 6 номер.

**Л.Гантөмөр:** Эрхэм Төсвийн байнгын хорооны дарга гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Манай Улс 2024 онд 162 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 27.4 тэрбум ам.доллар-т хүрч түүхэн амжилт үзүүлсэн.

Үүнээс экспорт 15.8 тэрбум ам.доллар-т, импорт 11.6 тэрбум ам.доллар-т хүрсэн, гадаад худалдааны тэнцэл 4.2 тэрбум долларын нэмэхтэй гарсан байна. Монгол Улсын нийт экспортын орлогын 93 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн дангаараа бүрдүүлж, эдийн засгийн төрөлжилт сул байгаа нь манай улсын эдийн засгийн хамгийн эмзэг цэг болж байна.

Эдийн засгийн төрөлжилтийг бий болгох уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл, төрөлжилтийг нэмэгдүүлж, экспортын зах зээлийг тэлж худалдааг хөнгөвчлөх чиглэлээр бодит ажлуудыг хийх хэрэгцээ, шаардлага маш өндөр байгаа гэдгийг дээрх тоо харуулж байгаа. 93, 7.

Түүнчлэн нийт экспортын 91.2 хувь, үүнээс уул уурхайн бүтээгдэхүүний 94.7 хувийг мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний 82.7 хувийг зөвхөн урд хөрш буюу БНХАУ-д экспортолж байгаа нь гадаад худалдааны хамаарал хэтэрхий нэг туйлтай болсон, эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй түвшинд хүрсэн байна гэдгийг илтгэж байна.

Өөрөөр хэлбэл, нэг улсын болон цөөн нэр төрлийн бүтээгдэхүүнээс хамааралтай байгаа эдийн засгийн бүтцийг өөрчилж, олон худалдан авагчид өргөн

хүрээний бараа нийлүүлэх тогтолцоог бий болгох гарцаагүй, зайлшгүй шаардлага манай улсын хувьд бий болсон.

Тиймээс гол түнш орнуудтай хийх худалдааны тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулж, өөрсдийн харьцангуй давуу талтай бүтээгдэхүүнүүдээ саадгүй экспортлох, мөн дотоодын үйлдвэрлэлд шаардлагатай импортын орц, түүхий эд, техник хэрэгслийг хямд үнээр оруулж ирэх замаар үйлдвэрлэлийн зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг шинээр байгуулах шаардлага тулгарсан учраас энэ удаагийн хэлэлцээрийг хийж байгаа.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд худалдааны түр хэлэлцээр байгуулах тухай албан ёсны яриа хэлэлцээг 2023 оны 9 дүгээр сараас эхлүүлж өнгөрсөн хугацаанд талууд нийт 2 удаагийн зөвлөлдөх уулзалт 3 удаагийн 3 шатын хэлэлцээг өнөөдөр хүртэл зохион байгуулаад байна. Мөн тус хэлэлцээрийг байгуулах асуудал болон хэлэлцээрийн явцыг нийт 6 удаа Засгийн газрын хуралдаанд танилцуулсан байна. Гадаад худалдаа эрхлэгч, бизнес эрхлэгчдийн дунд 4 удаагийн нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан байна.

Тус хэлэлцээрийг хийх ажлын хэсгийг анх Эдийн засаг, хөгжлийн дэд сайд ахлан хариуцаж байсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 44 дүгээр тэмдэглэлийн дагуу тус хэлэлцээр хийх ажлын хэсгийг шинэчлэн байгуулах үүргийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад даалгасан байна.

Засгийн газрын шийдвэрийн дагуу хэлэлцээр хийх ажлын хэсгийг 2025 оны 1 дүгээр сард шинэчлэн зохион байгуулсан. Тус ажлын хэсэг нь 2 хэсгээс бүрдэх бөгөөд хэлэлцээрийн төслийн бичвэрийг эцэслэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ахалж, гишүүний бүрэлдэхүүнд холбогдох яамдын газрын дарга нарыг оролцуулан байгуулсан.

Харин барааны жагсаалтад санал зөвлөмж боловсруулах чиг үүрэг бүхий дэд ажлын хэсгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ахалж, салбарын мэргэжлийн холбоод аж ахуйн нэгж, холбогдох яамдын оролцоо бүхий 25 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Барааны жагсаалтад санал боловсруулах дэд ажлын хэсгээс 2025 оны 1 сарын 23-ны өдөр нийт 23 барааг тус хэлэлцээрийн Монголын тарифын үүрэг амлалтын жагсаалтаас хасуулах саналыг ирүүлсэн байдаг. Энэ хүрээнд нийт 3 удаа албан бичгээр санал солилцож, 1 удаа биечлэн хэлэлцээр хийлээ.

Үүний үр дүнд талууд хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцсон бөгөөд Монгол Улсын талаас импортын нөлөөлөлд эмзэг тодорхой бараануудад айлын талд буулт хийлгэж, айлын талд буулт хийж харилцан ашигтай тохиролцоонд өнөөдөр хүрээд байгаа.

Хэлэлцээрийн хүрээнд 2 талаас ижил тооны буюу бараа тодорхойлох кодчиллын уялдуулсан системийн 6 оронтой кодоор 367 нэр төрлийн бараа нь тарифыг нь шууд тэглэх, тариф бууруулах, тохирсон квотын хэмжээ нь тарифыг тэглэх, тохирсон квотын хэмжээ нь тарифын хөнгөлөлт эдлэх гэсэн үндсэн 4 төрлөөр тарифын саад тотгорыг бууруулахаар тохиролцсон.

Манай улсын стратегийн болон хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний импортын нөлөөллийг бага байлгахад онцгойлон анхаарсан бөгөөд тоон хэмжээний хязгаарлалт тогтоох, зарим барааг хасуулах замаар дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зохицуулалтыг хэлэлцээрийн төсөлд тусгууллаа.

Тухайлбал, өндөгний хувьд манай улсын сүүлийн 3 жилийн дотоодын хэрэглээ жилд дунджаар 448.6 сая ширхэг байсан бөгөөд үүнээс 165 сая ширхэг буюу 36.8 хувийг импортоор нийлүүлсэн байна. Дотоодын өндөгний үйлдвэрлэлийн зах зээлийг хамгаалах зорилгоор өндөгний зах зээлийн 20 хувийг импортын орон зайд үлдээж, 90 сая ширхэг хүртэлх импортын өндөгт гаалийн татварыг 7.5 хувь байхаар тохиролцсон.

Харин 90 сая ширхгээс илүү өндөг импортлогдсон тохиолдолд гаалийн татвар 15 хувь байхаар тохиролцлоо. Харин улаан буудайн хувьд манай улс жил бүр ургац хураалтын нөхцөл байдал гурил үйлдвэрлэлийн технологийн шаардлагаас шалтгаалаад 30-аас 70 мянган тонн улаан буудайг импортлох шаардлага үүсдэг юм байна.

Айлын талаас хатуу болон зөөлөн улаан буудайд нийтэд нь 180 мянган тонн квотыг санал болгосон. Үүнийг 50 мянган тонн хүртэлх хэмжээнд одоогийн татварын хэмжээг 1.25 нэгж хувиар бууруулж, 3.75 хувийн татвар ноогдуулах бөгөөд 50 мянган тонноос дээш импортлогдсон хэмжээнд 5 хувийн татвар хэвээр хадгалагдахаар тохиролцлоо. Импортлох улаан буудайн хэмжээг квотоор олгоно гэдгийг энд дахин дурдъя.

Олон улсын чөлөөт худалдааны хэлэлцээр хийхэд түгээмэл ашиглагддаг ерөнхий тэнцвэрийн загварыг ашиглан тооцоолол хийж үзэхэд манай улсын ДНБ 0.02 хувь, хөрөнгө оруулалт 2.75 хувь, Еврази руу хийх нийт экспортын хэмжээ 24.1 хувь буюу 28.4 сая ам.доллараар тус тус нэмэгдэх үр дүн гарч байна. Эхний ээлжид.

Тухайлбал, Евроазийн зах зээлд нийлүүлэх мах махан бүтээгдэхүүний экспорт 125-аас 140 хувь, хувцас 84 хувь, ноос, ноолуур 64 хувь, нэхмэл, сүлжмэл хувцас 55 хувь, арьс ширэн эдлэл 46 хувь тус тус нэмэгдэх боломжтой байна. Эдгээр зах зээлд Монголын бараа, бүтээгдэхүүн ийнхүү гаалийн татваргүй нэвтэрч чадсанаар зах зээлд эзлэх байр суурь, өрсөлдөх чадвараа цаашид нэмэгдүүлэх өргөн боломж бүрдэнэ. Үүнийг тодотговол Евроазийн улсуудын нийт хэрэглээ бус зөвхөн импортын хэмжээ нь 2023 оны байдлаар мах, махан бүтээгдэхүүн 706 сая доллар, арьс ширэн бүтээгдэхүүн 5.9 тэрбум ам.доллар, ноос, ноолууран эдлэл 7.5 тэрбум ам.доллар байна.

Монгол Улсад хэрэгжүүлж байгаа Цагаан алт, Хүнсний хувьсгал, Шинэ хоршоо зэрэг хөтөлбөрүүдээр дамжуулан хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээнүүд өнөөдөр идэвхтэй хэрэгжиж байгаа.

Өнөөдөр хэлэлцэж байгаа энэхүү хэлэлцээр нь дээр дурдсан төрөөс хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдээр бий болох суурь тогтолцоог бүрэн утгаар нь цааш хөгжүүлж, дотооддоо боловсруулах, экспортлох, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалт, бизнесийн орлогыг нэмэгдүүлэх нь гарцаагүй. Улмаар хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэ цэн

нэмэгдэж Монголын 250 мянган малчин өрхийн хаалгаар бодитой орлого, ашиг олж очих юм.

Энэхүү худалдааны түр хэлэлцээрийг байгуулснаар аж ахуйн нэгжүүдийн экспортын зардал буурахаас гадна худалдааны үйл ажиллагаа илүү нээлттэй болж, гадаад худалдаа эрхлэгчдэд нийтлэг тулгамддаг асуудлыг хөнгөвчилж хялбаршуулах юм.

Хэлэлцээрт туссан худалдааг хөнгөвчлөх онцлох зохицуулалтуудаас дурдъя.

Зайлшгүй ашиглагддаг боловч дотооддоо бэлтгэн нийлүүлж чадахгүй байгаа гадаадын, гадаад улсын гаралтай орц, материалыг экспортлох, барааны өртгийн 50 хүртэл хувьд тооцуулах боломж бүрдүүлснээр илүү хялбараар экспортлох бараандаа тарифын чөлөөлөлт авах боломж бүрдэх юм.

Гаалийн байгууллагууд 4 цагийн дотор худалдаа эрхлэгчдэд барааг олгож, худалдаа эрхлэгчдэд тулгардаг бодит саад бэрхшээл буурна. Барааны гарал, үүслийн гэрчилгээг хатуу шаардахгүйгээр 12 сарын дотор нөхөн гаргаж, тарифын хөнгөлөлт эдлэх боломж бүрдэнэ.

Бүх бараанд тавьдаг гаалийн шалгалтыг багасгаж эрсдэлийн менежментийг хэрэгжүүлнэ.

5 мянган еврогоос бага үнэтэй бараанд гарал үүслийн гэрчилгээ шаардахгүй болж, жижиг дунд бизнес, цахим худалдаа эрхлэгчдэд хялбар экспортын боломж бүрдүүлнэ.

Хэрэв Монголын талын дотоод процедураар тус хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгогдсон тохиолдолд 2025 оны 6 сарын 26-наас 27-ны өдрүүдэд Бүгд найрамдах Беларусь Улсын Минск хотноо Евразийн эдийн засгийн холбооны дээд зөвлөлийн уулзалтын үеэр хэлэлцээрт гарын үсэг зурах боломжтой талаар айлын талаас мэдэгдээд байгаа юм.

Иймд Монгол Улсын олон улсын гэрээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу тус хэлэлцээрийг Улсын Их Хурлын Байнгын хороотой зөвшилцөн шийдвэрлэх тул тус асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Гантөмөр сайдад баярлалаа.

Хэлэлцээрийн төсөлтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Нэрээ өгье.

Пүрэвдаваа гишүүнээр тасаллаа. Дамдинням гишүүн. Энэ ирцийн дараалалд орж байгаа юм байна. Ганхуяг гишүүн асуултаа асууя.

**Х.Ганхуяг:** Евразийн хэлэлцээрт бид нар энэ бэлэн эсэх дээр би эргэлзээд байгаа юм. Яг сүүлийн 1 жил бид нар чинь бас гурилын импортын татварыг

байхгүй болгоод үндсэндээ 11 гурилын үйлдвэрээс 7 л, 7 дампуурсан 4 л үлдсэн байна. Киргизстан бас яг Евроазийн энэ хэлэлцээрт нэгдэн орсон орнуудын нэг.

Киргизид ямар нөхцөл байдал үүссэн байна гэхээр нийт гадаад худалдааных нь 60 хувь нь ганзагаар явдаг. 60 хувь нь. Тэгэхээрээ нөгөө татвар татвар хураах боломж байхгүй. Томоохон бизнесүүд нь бүгдээрээ Орос эзэнтэй. Ер нь худалдаа гэдэг маань тэгээд л хоорондоо мөнгөний зодоон л болдог, мөнгөний өрсөлдөөн болдог гэсэн үг. Манай аж ахуйн нэгжүүд тийм хэмжээний мөнгөтэй өрсөлдөх ямар ч боломж байхгүй. Зүгээр бид нар соёлтойгоор энэ асуудлыг дахиад жоохон судлаад эрсдэлтэй, үр нөлөөллийн судалгаагаа хийгээд хойшлуулсан нь зөв. Өөр гарц байхгүй. Оросоос импортолж байгаа хэмжээ чинь 5-аас, 2-оос 3 дахин ихэснэ, манай экспортлох хэмжээ үсрээд л 10, 20 хувиар л нэмэгдэнэ. Та нар махыг экспортолно гээд байх юм. Одоо Хятад руу бид нар махаа экспортолж дийлэхгүй л байна шүү дээ. Дотоодын үнэ нэмэгдлээ гээд л тэгээд л экспортоо хаачихдаг. Манайх бэлэн биш байгаад байна. Тэгээд бүгдээрээ ганзагын наймаагаар хийгдэх юм уу? Казахстаныг хар, Казакстан, тэр Киргизстаныг хар бүгдээрээ яаж энэ хэлэлцээрээс гарах вэ гэдэг л асуудал явж байна шүү дээ энд. Тэгэхээр энэ дээр арай жоохон болгоомжтой хандсан нь дээр байх.

**Ц.Даваасүрэн:** 6 номерын микрофон Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Ганхуяг гишүүний болгоомжлолыг бол их олон хүн хэлж байгаа. Тэгэхдээ энэ болгоомжлолыг ярихаасаа өмнө түр хэлэлцээр хийе гэдэг саналыг гаргаад их удаж байгаа юм байна лээ. Манай Их Хурлын гишүүд энийг бас анхаарна биз. Яагаад бид нар хойд талдаа түр хэлэлцээр хийдэг, санал гаргасан бэ гэхлээр хэтэрхий худалдаа 90 хэдэн хувь нь урд талтайгаа байна, тэнцвэрээ хангая л гэдэг ийм санал гарсан юм билээ. Тэгээд энэ хэлэлцээрийг бол Евроази өөрөө хүлээн зөвшөөрөхгүй их удсан. Ер нь бол Энхтүвшин сайдын хэлж байгаагаар бол бараг их олон орны ард байсан.

Тэгээд хоёр улсын төрийн тэргүүний дээд хэмжээний уулзалтын үеэр яриа хэлэлцээр эхлүүлье гэдэг ийм шийдэлд хүрсэн гэдэг ийм мэдээлэлтэй байгаа юм. Үр өгөөжийн хувьд бол бид нар үйлдвэрлэлээ ялангуяа хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг босгож ирье гэх юм бол энэ хэлэлцээр маш их ашигтай. Одоо бид нар сая хангайн бүсэд очлоо. Хангайн бүс бол хөдөө аж ахуйн салбар нь ДНБ-ийх нь 50 хувь байна. Энэ хүмүүсийн орлого нэмэгдэх, энэ хүмүүсийн худалдаа эрхлэх боломж гарах, тэр дундаа арьс шир, ноос, ноолуур гэсэн бүтээгдэхүүнүүд чинь уначихаар малчдын орлого байхгүй болчихоод байна. Тэгэхээр энийг тодорхой хэмжээнд үйлдвэрлээд гаргадаг тэр боломжийг л Евразийн эдийн засгийн холбоо энэ зах зээл байна уу гэж хараад хэлэлцээрийг эхлүүлсэн. Бид Евразийн холбоонд элсэхгүй. Хэлэлцээр түр хийгдэнэ. Бид ажиглагч орноор ч элсэхгүй.

Тийм учраас бол Евразийн холбоонд элсэх гээд байна гээд. Ингээд санаа зовж байгаа гишүүд энэ дээр ямар ч санаа зовох зүйл байхгүй. Бид зах зээлээ олж авахгүй бол энэ худалдааны дайн бол Монгол Улсад ямар их хор хөнөөл учруулахыг бид нар өнөөдөр тааварлах боломжгүй байна. Бид нараас хол хөндий юм шиг харж байгаад маш том хохирол амсана шүү гэдэг ийм дохио бол хаа сайгүй ирж байна. Тийм учраас бол энэ худалдааны дайны үед бид нар өөрийн гэсэн зах зээл олж авах нь бол улс орны хувьд амин чухал байгаа шүү гэдгийг та бүхэндээ хэлье.

Ер нь хүнсний төрлийн буюу Монголд үйлдвэрлэж байгаа бараанууд дээр бэлэн бараа бүтээгдэхүүн манайх тарифын хөнгөлөлтөд оруулаагүй. Гурил бол энэ хэлэлцээрт байхгүй. Гурилыг өнгөрсөн жил тарифыг нь тэглэдэг нь манай өөрийн санаачилга. Тэгэхээр буцаагаад гурилынхаа тарифыг тавих л асуудал байгаа. Гурилыг энэ хэлэлцээрт оруулаагүй, эцсийн бүтээгдэхүүний түвшинд бол орохгүй байгаа. Улаан буудайгаа бүрэн хамгаалсан, хүнсний ногоогоо хамгаалсан, архи, пивоо хамгаалсан, сүү, сүүн бүтээгдэхүүнээ хамгаалсан. Ер нь бол бид өөрийнхөө хийж чадаж байгаа зүйлийг бол хам.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Ганхуяг гишүүн тодруулъя.

**Ц.Даваасүрэн:** Энэ салбар үндсэндээ 600 мянган хүний амь, амьдралтай холбоотой салбар шүү. 3 жилийнхэн хугацаатай хийх юм гээд ямар ч эрсдэлгүй гэж тэгж ярьж болохгүй шүү Гантөмөр сайдаа. Та өөрийнхөө гараа эдийн засгийнхаа гол салбарыг нухчин дарах гэж байна шүү дээ. Манай эдийн засгийн өсөлт яг хэдэн хувиар нэмэгдэх юм, экспорт хэдэн хувиар нэмэгдэх юм? Тийм судалгаанууд чинь хангалтгүй байна. Хийсэн байгаа судалгаануудыг бүгдийг нь харсан. Тэнд зөвхөн тарифын асуудлаасаа гадна тарифын бус саад тотгор нь тэрнээсээ хамаагүй их байна. Манайх руу л чөлөөтэй орж байна бид нар зөрүүлээд юу ч гаргах боломжгүй ийм л нөхцөл байдалтай тийм л хэлэлцээр байна. Хүнсний хувьсгал гээд бид нар чинь хийгээд л явж байна. Тэр хүнсний хувьсгал чинь дуусчихсан юм уу, ямар үр дүнтэй гарсан юм? Тэрийгээ ингээд бүгдийг нь үрэн таран хийх гэж байгаа юм уу? Нэг гараараа.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Гантөмөр сайдаа экспортод хэр нэмэгдэх вэ гэдэг талаас нь бодитой яг тоо баримтаар хэлбэл зүгээр. Ер нь манай гишүүд нэг зүйлийг бас анхаараарай. Бид 90 хувь 1 орноос хамааралтай эдийн засагтай байгаа шүү. Тэд нарын нөлөө ороод байж болохгүй шүү. Тэд тийм л байхыг бодно. Биднийг хавсарга байлгахыг л бодно. Энэ талаасаа бас сайн бодоцгоогоорой.

Та хариулъя 6 номерын микрофон.

**Л.Гантөмөр:** Ер нь бол их хурлын гишүүдийн хэлж байгаа, бодож байгааг бол ойлгож байгаа. Ер нь би гишүүддээ нэг зүйлийг хэлмээр байгаа юм. Ялангуяа өнгөрсөн парламентад байсан хүмүүс өнөөдөр айхтар ухаантай дуугараад байх хэр зохистой вэ? Хэлэлцээр эхлэхэд та бүхэн дуу хоолойгоо өргөж байх ёстой. Хэлэлцээрийг эхлүүлээд, бүүр тэглээд байж байхад тодорхой бараануудаа бид нар хамгаалж үлдэж байгаа. Одоо бид нар энэ 2 орны харилцаан дээр айхтар улс төржөөд байх шаардлага ерөөсөө байхгүй. Бид нар 2 хөршийнхөө аль нэг талыг барьж амьдардаг хүмүүстэй. Тэр хүмүүсийн нөлөөг төрийн бодлогод оруулж ирж болохгүй. Хамгийн ойрхон, хамгийн бололцоотой зах зээл бол хойд талд байна. Энэ зах зээл рүү бид нар дайрах хэрэгтэй. Ийшээ бид нар нэхмэл бүтээгдэхүүн, ноос, ноолуур өнөөд.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Дутуу хариулсан 1 минутаа тодруулах дэгтэй. Ганхуяг гишүүн дараа нь Гантөмөр гишүүн хариулаад явъя.

**Х.Ганхуяг:** Тийм Оросын Холбооны Улсад ерөөсөө эргэлзэж байгаа юм надад алга. Би зүгээр танд эргэлзээд байгаа юм. Өмнөх парламентад суусан ухаантай царайлсан ч гэнэ үү. Танд эргэлзэж байна. Та энэ тоо тооцоо, судалгаагаа сайн харуулаадах. Тэгээд тэрний дараа цөмөөрөө шийдье.

**Ц.Даваасүрэн:** Гантөмөр гишүүн хариулъя.

**Л.Гантөмөр:** Тийм энэ бол цэвэр улс төрийн өнгөөр л бид нар юманд хандаад байна л даа. Тооцоо, судалгааг чинь энэ яам Хөдөө аж ахуйн яам, холбоод нь бүгдээрээ хийчихсэн. Зүгээр нэг итгэлгүй юм байгаад байна. Бид нар үйлдвэрлэсэн бараагаа тэр зах зээлд зарж чадахгүй юм биш үү гэдэг ийм айдастай. Тэр айдас нь өөрөө маш их баталгаа, нотолгоо шаарддаг.

Ер нь энэ зах зээл дээр бараа, бүтээгдэхүүнийг чинь авъя гэж ямар ч хүн баталгаа гаргаж өгөхгүй шүү дээ. Бизнес эрхэлдэг хүн, эрхэлж үзсэн, түц ажиллуулж үзсэн хүмүүс тэрийг мэднэ шүү дээ. Хэр зэрэг сайн бараа үйлдвэрлэнэ тэр хэмжээнд л бараагаа зарна. Хэр зэрэг худалдааны суу заль гаргана тэр хэмжээнд л юмаа зарна. Түүнээс биш бэлэн зах зээл байна, энэ зах зээл дээр лангуун дээр бараа тавиад шууд авдаг юм байна.

**Ц.Даваасүрэн:** Ер нь яах вэ экспорт яаж нэмэгдэж, экспортын боломж талаас тайлбарлавал зүгээр. Бид нар чинь ерөөсөө 90 хувь 1 орноос хамааралтай гэдгээ л ер нь бодмоор байгаа юм даа.

Мөнхсоёл гишүүн. Мөнхсоёл гишүүний микрофоныг өгье.

**Б.Мөнхсоёл:** Асаж унтраад байх шиг байна. Өглөөний мэнд хүргэе. Энэ чухал асуудал хэлэлцэж байна. Эдийн засгийн байнгын хороо бас давхар хуралдаад байгаа ирцийнхээ дарааллаар гэнэт нэр ороод ирэх шиг боллоо.

Энэ асуудал угаасаа бас Монголд ажиллаж байгаа үйлдвэрлэгчид, тэр салбарынхныг бас анхаарлыг нь татсан ийм чухал асуудал байгаа. Сая Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх байсан энэ асуудал хойшилчихсон. Яагаад вэ гэхээр яг нөгөө ол олон нийтийн хэлэлцүүлгийг маш сайн хийх ёстой. Тэр ажил дутуу хийгдсэн гэж үзэж байгаа юм байна. Мөн хэд хэдэн гишүүдэд Хүнсчдийн холбооноос бичиг ирсэн. Тэр бас зарим Эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд ирсэн байна. Надад бас ирсэн.

Тэгээд хийсэн судалгааны үр дүнгүүд зөрчилтэй байгаад байгаа. Хүнсчдийн холбоо нь МУИС-ийн яг эдийн засгийн шинжилгээ хийдэг хүрээлэнд захиалсан судалгааны үр дүнд энэ хэлэлцээр нь үр ашиг тун тааруу байна гэж гарсан юм байна. Яг энэ Эдийн засгийн хөгжлийн яамнаас хийсэн судалгаа болгон тэр Жи Си И-ийн загвар ашиглаад гарсан дээр үндэслээд хэлэлцээр хийхэд боломжгүй биш юм гэж хэлээд байгаа. Тэгээд бид нарын хөндөөд байгаа асуудал ялангуяа сүү, сүүн бүтээгдэхүүн, хуурай сүү, тэгээд шатахуун тос, бусад эдгээртэй орлуулах маягаар бүтээгддэг энэ бүтээгдэхүүн үйлдвэрлэл дээр хамгийн гол нь анхаараач. Бид нар олохоосоо илүү алдах вий гэдэг энэ эрсдэлийг хүмүүс анхааруулаад байгаа юм.

Мэдээж Монгол Улсын зах зээл дээр үйлдвэрлэхээсээ илүү худалдаа наймаанд оролцдог хүмүүс аж ахуйн нэгжүүд их шүү дээ. Тэгэхээр эдгээрийн хоорондох зөрчил мэдээж байна. Бид нар энд өнөөдөр бодлого боловсруулах гээд сууж байгаа хүмүүсийн хувьд яг Монгол Улсынхаа эдийн засагтаа ямар ач холбогдолтой юу, дотоодынхоо үйлдвэрлэгчдийг сүйрүүлэхгүйгээр, тэд нарынхаа эрсдэлийг нэмэхгүйгээр, мотивацыг нь унагаахгүйгээр яаж энэ хэлэлцээрийг зөв зүйтэй авч явах юм бэ гэдэг дээр зайлшгүй анхаарах хэрэгтэй. Тэр төлбөрийн тэнцэл ч бай, худалдааны тэнцэл ч бай тэдгээрийг харахаар ялт ч үгүй олж

байгаагаасаа илүү алдаж байгаа нь өндөр болчихоод байгаа бид нар бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ энэ танилцуулга дээр, график тооцоонууд байна. Тэгээд мэдээж гол хүчин зүйл бол хөрш оронтойгоо дийл/deal/ хийж байгаа энэ хэлэлцээр ногиашэйшн/negotiation/, тохиролцоо явж байна гэдгийг ойлгоод байгаа.

Тэгэхээр аль талд нь аль бүтээгдэхүүн үйлчилгээ дээр яаж бүгдээрээ зөв маш ийм ийм нюанстай явах вэ гэдэг дээрээ анхаарахаас өөр аргагүй гээд. Давхар хуралтай байгаа учраас ерөнхийдөө санал хэлчихье. Асуулт бас өмнө нь дотоо дотооддоо уулзахад асуучихсан учраас ингээд дуусгая. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Санал гэж ойлголоо. Батжаргал гишүүн асуултаа асууя.

**Ж.Батжаргал:** Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Хэдэн бие рүүгээ үг шидээд юу гэх вэ л дээ. Төр байгаа бол бас төрийн бодлого тогтвортой байх, уламжлалтай байх энэ юмаа л бодох ёстой. Евразийн эдийн засгийн холбоотой худалдааны хэлэлцээр хийх талаар олон жил ярьцгаасан. Тэгээд хийе гэхээр зэрэг юм ярьцгаагаад байгаа. Гэхдээ хийхэд учир байгаа үндэсний эрх ашиг гэж юм байгаад байгаа. Бид хэдэд үүнийгээ илүүтэй бодож, харах ёстой.

Энэ худалдааны түр хэлэлцээрт ороход бид бэлэн үү гэдэг л асуудал байгаа. 367 бараа бид яг бэлэн байна уу? Энэ 5 орны стандартыг хангаад авч чадах уу? Энэ хамгийн гол зүйл байхгүй юу. Бэлтгэл гэдэг энийг л хэлээд байгаа. Энэ талаасаа юмаа нэлээн хармаар санагдаад байх юм.

Хоёрдугаарт үндэсний бид хэд нэлээн томоохон аянууд, бодлого хөтөлбөрүүд гаргаад ажиллаж яваа. Хүнсний хувьсгал 19 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дотоодоосоо хангана гээд хэлчихсэн. Тэр нь 26 онд дуусах билүү дээ би тэгж ойлгож байна. Тэр дотор чинь өндгөө 100 хувь хангана гээд орчихсон шүү дээ.

Тэгээд одоо бид хэд чинь гаднаас нэлээн ахиухан өндөг тодорхой квотын түвшинд тарифыг нь тэглэж байгаад оруулж ирье, тэрнээс давсныг нь тарифтай байлгая гэж хэлэлцээртээ оруулж байгаа юм байна шүү дээ. Яг энэ мэтчилнээр эндээ босгох гээд хөрөнгө мөнгө чиглүүлээд, үйлдвэрлэгч гэд гэдэг юм уу баялаг бүтээгчид бас ийм нөхцөл байх юм байна гээд зүтгэчихсэн юман дээр нь юм оруулж ирээд хэдүүлээ дэвсчхэв дээ. Цемент яг энэ, гурил яг энэ. Одоо хийж чаддаг 2 юмаа л унагалаа шүү дээ бид хэд 2 жил, 3 жилийн хугацаанд. Үгүй цаашид явах юм уу үгүй юм уу? Одоо тэгээд л нэг муу сайдыг балбаад л, тэр муу малаас болоод ийм болж байна гээд л. Тийм биш шүү дээ. Энэ үндэсний эрх ашиг гэж байдаг бол энийгээ бид харах ёстой.

Дараа нь би юм асуумаар байгаа юм. Бараа эргэлт чинь 3 тэрбум доллар юм билээ. Манайх 0.1, нөгөөдүүл 2.9-өө тэгээд манай гарч байгаа юм юу байна гэсэн жонш 44, биологийн идэвх бүхий хүнсний нэмэлт 13 хувь, ноос, ноолуур, хивс 5 хувь. Нөгөө талаас орж ирж байгаа юм юу байна гэсэн нефть 72 хувь, эрчим хүч 2.4, азотын бордоо 2.4 ийм л юм байгаад байгаа шүү дээ. Үнэндээ тэнцвэргүй. 2.8 тэрбумын бараа эргэлтийн алдагдалтай явж байгаа улс шүү дээ. Тэгэхээр үүнийг аль бол.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Тэр ч яах вэ нефтийн үйлдвэр. 1 минут нэмж өгье Батжаргал гишүүнд. Нефтийн үйлдвэр.

**Ж.Батжаргал:** Үүнийгээ ойртуулах тал руугаа бид бодож энэ хэлцлийг хийх ёстой юм. Уул нь хэлцлийн 8 дээр үг байгаад байгаа юм. Тусгайлан энэ хэлцэл дотор заачхаагүй асуудлыг хориг, тарифын зарчмаар зохицуулж болно гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр аль болохоор эндээ хийж эхэлж байгаа хийнэ гэж, зорьж байгаа юмнуудаа энэ хэлцэлд оруулмааргүй байгаа юм яг үнэнийг хэлэхэд. Үр тариа гэхэд та нар 50 мянган тонныг авах тухай л дурдсан л байна лээ шүү дээ. Яах аргагүй хэлцэл дотор. Тэгээд энэ чинь газар тариаландаа яаж нөлөөлөх юм гээд олон зүйл байна. Энэ дээр би тодорхой мэдээлэл авъя дээ. Дээр нь энэний дараа орж ирэх гэж байгаа тэр Засгийн газар хоорондын хэлэлцээр байна. Хамтарсан компани байгуулж байгаад агаарын хөлгийн түлшийг хангая, 20 жил тэр нийлүүлэх юм гэнэ.

Гэтэл бид хэд 28 онд үйлдвэрээ барина гээд байгаа шүү дээ. Тэгээд яах гэж байгаа юм? Тэрний чинь гол бүтээгдэхүүн агаарын хөлгийн түлш байгаад байгаа шүү дээ. Энэ.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** 6 номер Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Ер нь ийм юм байна лээ. Одоо бол нефтийн тоо их өндөр байгааг бүгдээрээ мэдэж байгаа. Манай бараа, бүтээгдэхүүнүүд Оросын Холбооны Улс буюу Евроазийн энэ улсуудад зарагддаггүй үндсэн шалтгаан татвар нь асар өндөр юм билээ. 10-аас 20 хувь, зарим нь 40 хувь, зарим нь 50 хувь. Тэгээд ийм өндөр татвартай тохиолдолд манай бүтээгдэхүүн тэнд зарагдахгүй байх нь их тодорхой юм байна лээ. Тэгээд тэр татваруудыг л тэглэж байгаа юм нэг талаасаа.

Нөгөө талаасаа хүнснийхээ импортыг бид нар хамгаалсан. Жишээлбэл 90 сая өндөг дээр манайхан нөгөө хийсэн хэлэлцээрийг бүгдээрээ сайхан чамбай уншихмаар байна. 90 сая дээр 7.5 хувийн татвартай. Ер нь өндгийг 15 хувийн татвар тавиад удаан бид нар бас барьж чадахгүй. Дэлхийн худалдаан байгууллагынхаа дүрэм журмаар ч гэсэн тийм.

Нөгөө талдаа дотоодын хүнсийг хамгаалах бид нарт механизм байгаа гишүүд ээ. Бид нар дотоодод үйлдвэрлэгдэж байгаа энэ хүнс, хүнсний бараан дээрээ НӨАТ-аа бид нар хэдэн ч хувь болгож болно. НӨАТ өнөөдөр 10 хувь байгаа бүх талд. Тэгэхээр энэ хүнсний бүтээгдэхүүнийхээ НӨАТ-ыг бид нар бууруулаад дотоодынхыг 2 хувь болгоод, импортынхыг 10 хувьд нь үлдээхэд л энэ зөрүү дээр манай бараануудтай өрсөлдөх бараа гарч ирэхгүй байхгүй юу даа. Тэгэхээр асуудал юу вэ гэвэл чанарын л асуудал байгаа.

Тийм учраас бол бид нар энэ хүнсний Батжаргал гишүүний ярьж байгаа тэр 10 хэдэн төрлийн бүтээгдэхүүнийг дотоодоосоо 100 хувь хангах боломж бидэнд байна. Энэ зогсохгүй. Манайхан жоохон буруу мэдээлэл олон нийтэд өгөөд, тэгээд олон нийт болохоор зэрэг тийм бүх бараа татваргүй ороод ирэх юм байна гэдэг ийм айдаст автуулаад байна. Яг манайд үйлдвэрлэж байгаа 10 хэдэн бараан дээрээ бид нар татвараа авч байгаа. Авна. Тэгээд өрсөлдөх чадвар дээрээ дахиад ялагдахаар байх юм бол бид нар дотоодын хүнснийхээ НӨАТ-ыг суллагчид л бид ямар ч асуудалгүй гараад явчихна. Гол нь манай нэхмэл эдлэл, арьс үнэгүй болчихоод байна8 ноос үнэгүй болчихоод байна. Энэ юмнуудаа бид нар тодорхой хэмжээнд бөөцийлөөд нэг тодорхой бараа, бүтээгдэхүүн болгоод экспортлоход хамгийн ойрхон зах зээл энэ зах зээл байна л гээд байгаа юм. Тэгээд энэ рүүгээ хэдүүлээ оръё гэдэг санал санаачилгаар л ажил эхэлсэн юм байна лээ л дээ.

Тийм учраас үнэхээр Батжаргал гишүүний хэлж байгаагаар энэ төрийн бодлогын залгамж халааг л би залгуулаад л авч орж ирээд дотоодын зах зээлийг яаж хамгаалах тухай л яриад байгаа болохоос биш гэнэт хүмүүс жоохон дургүй байгаа юм байна, нийгэм хүлээж авахгүй юм байна тийм учраас энийгээ зогсооё гэж болохгүй гэж би хувьдаа бодож байгаа.

Тийм учраас та бүхэн маань асуудлыг олон талаас нь жоохон уужуу ухаанаар харж өгөөч л гэж хүсмээр.

**Ц.Даваасүрэн:** Батжаргал гишүүн тодруулъя.

**Ж.Батжаргал:** Би таны яриад байгааг ойлгоод байна л даа. Зовлон байгаа би мэдэж байна. Гэхдээ хэдүүлээ бас бодмоор юмнууд байна. Мөнхийн хөрштэй. Тэндээ янз бүрийн итгэл төрүүлчхээд дараа нь явц дунд нь болохоо байлаа гээд маргалдаж асуудлыг хүндрүүлж байхаар анхнаасаа болгоомжлох зүйлүүдээ энэнээсээ хасах ёстой. Үүнийгээ илүү нухацтай суумаар байна. Би үүнийг огт байгуулахгүй гэж хэлмээргүй байна. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийг гаргах асуудал бидэнд хэрэгтэй байна. Дээр нь эрчим хүч гэдэг юм уу, нефть гэдэг юм уу, бордоо гэдэг юм уу, техник гэдэг юм уу эднүүсээ оруулж ирэх тухай асуудал бидэнд байна. Ийм юмнуудаа оруулахаас өөр арга байхгүй үнэн.

Гэхдээ боловсруулах чиглэлийн дөнгөж өндийж байгаа үйлдвэртэйгээ ижил түвшин барьчихвал болохгүй. Яагаад эднүүс улаан буудайг хэдэн зуун саяар нь үйлдвэрлээд байна гэхээр зэрэг хөрснийх нь бүтэц, уур амьсгалынх нь нөхцөл манайхаас шал.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** 6, Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Тэгэхээр харин би яг адилхан, Батжаргал гишүүнтэй яг адилхан аргумент хэлж байж улаан буудайн импортыг болиулсан шүү дээ. Яг адилхан аргумент хэлж байгаа юм. Манайд ургахгүй байна, танайд ургаад байна. Бид нар ургуулах гэж 100 жил зүтгэлээ. Хүнд байна, маш их хөрөнгө зарсан. Тийм учраас улаан буудайгаа бид нар дотооддоо хийе. Танай улаан буудайг 50 мянган тонныг л авах юм байна. Тэгэхдээ татвартай авъя.

**Ц.Даваасүрэн:** Энэ чинь угаасаа хэдийг авдаг юм? Энэ чинь хольдог шүү дээ.

**Л.Гантөмөр:** Угаасаа 50 мянгыг авдаг юм байна лээ л дээ. 30-аас 70 мянгыг авдаг ийм уламжлалтай юм байна лээ. Яагаад гэхээр тэндхийн улаан буудайн цавуулаг манай энэ үйлдвэрүүдэд Монголын дотоодын улаан буудайтайгаа холиод хийж байж манай гурил гараад байдаг юм байна. Бид нар бас амьдралаа бодитойгоор хармаар юм байна лээ. Тэгэхээр авдаг хэмжээг нь л үлдээж байгаа юм. Нөгөө талын санал үгүй та нар энийгээ нэм. Ер нь нийт үйлдвэрлэл, хэрэглээний.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Номинчимэг гишүүн асуултаа асууя.

**О.Номинчимэг:** Энэ Евроазийн чөлөөт худалдааны түр хэлэлцээр, эдийн засгийн эргэлт, эдийн засгийн нөлөө гэхээсээ илүү би энэ дээр ганц юм онцолж анхааруулаад хэлэлцээр эцэслэхээс өмнө шийдээсэй гэж хүсэж байгаа юм. Тэр юу

гэхээр энэ Евразийн түр хэлэлцээрээр та бүхэн эдийн засгийн үр нөлөөгөө нэлээн харж байгаа байх. Нийтийн эрүүл мэндийн үр нөлөө энэнээс үүдэж яах вэ гэдэг дээр харж байгаа болов уу гэдэг дээр би үнэндээ эргэлзэж байна.

Юу вэ гэхээр энэ барааны гаалийн татвараас чөлөөлөх листэд чинь тамхин бүтээгдэхүүн орчихсон байгаа. Яах вэ энэ олон улсын худалдааны хэлэлцээр эд нарыг харахаар та бүхэн хэлж байна архины энэ асуудал, тамхины асуудал, нийтийн эрүүл мэндэд хохиролтой байдаг асуудал дээр онцгой өөр бодлого явдаг. Улс орон өөрсдөө нийтийн, залуучуудынхаа, хүн амынхаа эрүүл мэндийг хамгаалахын тулд энэ дээр тодорхой гааль, татвараар энэ бодлогоо явуулдаг.

Гэтэл та бүхэн архин дээрээ ингээд анхаарсан мөртөө яг манай Монгол Улсын хувьд тамхины хувьд бол дандаа импортлогч улс. Дан ялангуяа сүүлийн 3 жилээр ингээд харах юм бол нийт тамхин бүтээгдэхүүний импорт өсөж байгаа. 35 хувь нь яг энэ Евроазийн хэлэлцээрт орж байгаа 5 улсаас улсаас орж ирдэг. Нийтдээ энэ бол 70-аад сая долларын ийм эргэлттэй асуудал. Манай Монгол Улс байна шүү дээ 2003 онд батлагдсан Тамхины хяналтын суурь конвенцод нэгдээд орчихсон юм. Тэгээд энэ суурь конвенцоор олон улсын гэрээ хэлчихсэн шүү дээ тээ. Энэ суурь конвенцоор олон улсууд чөлөөт худалдааны гэрээ хийхдээ тамхин бүтээгдэхүүнийг битгий оруулаач. Энэ бол нийтийн эрүүл мэндийн бодлогоо явуулах ийм завсар байх учраас энэ дээр гааль, татварыг нь чөлөөлдөг, хөрөнгө оруулалт дээр нь илүү үздэг энэ байдлыг болиоч гэсэн ийм заалттай. Монгол Улс энд гэрээтэй.

Тэгэхээр энийгээ бариад та бүхэн маань Гадаад хэргийн яаман дээр ч гэсэн Мөнх-Оргил сайд гишүүн байх үедээ энэ асуудлыг судлаад тамхин бүтээгдэхүүний хувьд манай Монгол Улс үнэндээ лоббинд нь автдаг юм уу, ерөөсөө татвараа нэмж чаддаггүй. Бүүр хүүхдүүдийн хувьд бол энэ 3-аас 4 мянган төгрөгөөр л пажик тамхины үнэ байгаа шүү дээ. Шим тэжээлтэй хоол хүнс авъя гэхээр хамаагүй хямдхан. Тэгээд нийтийн эрүүл мэнд ямар байгаа билээ? Энэ дээрээ бид нар энэ лобби гэдэг асуудлыг нь болиод үнэндээ анхаарахгүй бол тамхи нь байна уу, веб нь байна уу үнэндээ эрүүл мэндийн асуудал байхгүй. Дараа нь энэ эдийн засгийн үр нөлөөгөөс чинь илүү эрүүл мэндээс үүдэн гарах үед сөрөг үр дагавар гарна шүү.

Тэгэхээр энэ дээр та бүхэн энэ олон улсын хэлэлцээрээ бариад энийг гаргах тал дээр ямар нэгэн хүчин чармайлт хийв үү? Нэгдүгээрт. Би Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас асуусан. Батхүү Төрийн нарийн бичгийн даргатай бас асуусан. Тэгээд эд нар болохоор хоор хоорондоо шидэлцээд байгаа яг үнэндээ. Хэн нь яг ямар санал өгсөн юм, энэ дээрээ үнэхээр бодлогоо цаашаа дамжуулсан юм уу гэдэг дээр та бүхэн надад ерөөсөө хариу өгч чадаагүй. Энд Сангийн яам нь энэ асуудлаа орхичихсон. Онцгой татвар нэмэх, гаалиа нэмэх. Эрүүл мэндийн яам нь орхичихсон. Аргаа ядаад Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа. Энэ асуудлаа цэгцлэхгүй бол болохгүй нь.

Тэгээд ингээд явж байхад хажуугаар нь импортынх нь 35 хувь. Электрон тамхи хэд гэдэг мэдэхгүй шүү дээ. Бид нар ямар зохицуу.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Номинчимэг гишүүн 1 минут.

**О.Номинчимэг:** Тэгээд татварын тооцоолол, эрүүл мэнд, тамхидалтаа бууруулах энэ тооцооллуудыг хийгээд явж байтал 35 хувийнх нь зах зээл дээр нь

бүх гаалийн 30 хувийн татварыг та бүхэн байхгүй болгох гээд байна. Энэ өөрөө маш сөрөг үр дагавартай. Бид нар онцгой албан татвар нэмээд нэмээд энэ чинь өөрөө дахиад тэгш бус байдлыг үүсгэнэ гээд зөндөө асуудлууд болно. Тэгээд энэ дээрээ анхаараач. Энэ дээр тэгээд та бүхэн яг хэлэлцээрийн шатанд дурдсан зүйл байна уу? Казахстан улсаас ялангуяа энэ бүтээгдэхүүнүүд их орж ирж байгаа. Энийгээ та бүхэн хэлээч. Архи дээрээ ярьж болж байгаа, тамхин дээрээ ч гэсэн сөргүүлээд ярьж болно шүү дээ. Тэгээд энэ дээр мэдээлэл авъя.

**Ц.Даваасүрэн:** 6 номер. Та хэд итгэл үнэмшил төртөл сайхан хариулт өгөхгүй бол наадах чинь нэг л. Та нар ч өөрсдөө за даа явуулахаас өөр аргагүй дээ гэсэн юм шиг л хариулт өгөөд байх юм.

6, Гантөмөр сайд.

**Л.Гантөмөр:** Үгүй л дээ би бол явуулах хэрэгтэй гэсэн ийм хатуу байр суурьтай л байгаа. Тийм учраас энд авч орж ирж байгаа. Ер нь хэлэлцээрээ би түрүүн танилцуулга дээр хэлсэн ажлын хэсэг гаргаад 2 хуваасан юм. Ерөнхий хэлэлцээр дээр Батхүүг, бараа, бүтээгдэхүүний асуудал дээрээ би Хөдөө аж ахуйн яамыг саналаа өгөөд, саналаа гаргаад яв гэсэн. Зүгээр энэ дээр бодит байдал дээр бол 23 бараа манайд үйлдвэрлэгдэж байна. Энэ бараануудаа хамгаалъя гэдэг санал ирсэн. Энэ хэлэлцээрийг сүүлийн 3 сарын хугацаанд бид нар хийлээ шүү дээ.

Тамхины тухайд бол үнэхээр онцгой албан татварыг маш их хэмжээгээр нэмэгдүүлнэ. Нэмэгдүүлнэ. Бид Эдийн засаг, хөгжлийн яам бол яг ийм бодитой саналыг ирэх оны төсөв ярих үед оруулж ирнэ. Наана нь ч магадгүй оруулж ирэх байх. Ер нь таны хэлж байгаа тамхиа бид нар хориглох алхам руугаа хүчтэй алхахгүй бол болохгүй гэдэгтэй санал нэг байна.

23 барааны жагсаалт ирэхэд энэ тамхи орхигдсон байна. Зүгээр яах вэ Даваасүрэн дарга чи жоохон итгэл үнэмшил муутай байна гээд байгаа нэг зүйл байгаа юм. Нөгөө өөрөө хэлэлцээр эхлүүлээгүй хүнд дутагдал гарч байна. Анхнаасаа бариад яах ёстой вэ гэдгээ яриад явсан бол би өнөөдөр яг энэ нь ингэсэн юм, тэр нь тэгсэн юм гээд 100 хувь хариулах байх л даа. Явчихсан юмыг эцэслээд 7 сарын 3-нд зурчихсан, 24 оны 7 сарын 3-нд 2 тал бараагаа эцэслээд зурчихсан ийм нөхцөл байдал дээр бид, би жишээлбэл оролцож эхэлж байгаа юм.

Тэгэхээр бол зүгээр парламент дээр ер нь энэ чинь яг энэ янзаараа гарахгүй шүү. Дотоодын зах зээлийг хамгаал гэдэг ийм дуу хоолой олон талаас сонсогдсон учраас бид нар хэлэлцээрээ үргэлжлүүлъя гэдэг саналыг тавьж, ингээд Хөдөө аж ахуйн яамнаасаа ямар бараан дээр бид нар тариф тавих вэ гэдэг саналыг аваад тэр түвшинд хэлэлцээр хийгээд ингээд үр дүнгээ би та бүхэнд оруулж ирж байгаа нь энэ юм.

Өнөөдрийн байдлаар бол тамхины, нийт тамхины 50 хувь нь Солонгос улсаас авч байгаа бид нар. 23 хувийг нь түрүүн хэлдэг Казахстанас авч байгаа юм байна лээ.

**Ц.Даваасүрэн:** Номинчимэг гишүүн 1 минут тодруулъя. Түрүүн 1 минутаа авчихсан шүү.

**О.Номинчимэг:** . яах вэ тэгээд та бүхэн Солонгостой ч чөлөөт худалдааны гэрээ хийнэ гээд явж байгаа энэ дээр чинь тулгуурлаад л ингээд л тамхины асуудал чинь хяналтгүй л болох гээд байна шүү дээ. Тэрийг л хэлээд байгаа юм.

Одоо хэрвээ хэлэлцээр хийх бас боломж энэ чинь зөвшилцөхөөр орж ирж байгаа, гишүүдийн, парламентын саналыг та бүхэн тусгах ёстой. Гадаад хэргийн яам энэ Эф Си Ти Си буюу Тамхины хяналт суурь конвенцын 5.6-гаа бариад чөлөөт худалдааны гэрээ, хэлцэл дээр тамхин бүтээгдэхүүний асуудал дээр бодлого дээр ийм байна, манай улсын нэгдэж орсон гэрээ байна гэдгийг дахиж хэлэлцээр хийгээд үзээч. Та бүхэн мэдээж Засгийн газрын түвшинд ажиллаж байгаа. Зөвхөн хүнс Хөдөө аж ахуйн яамнаас гадна Эрүүл мэндийн яам ч байдаг юм уу бусад салбарын яамдаасаа энэ саналуудыг ер нь авсан юм уу? Ийм цогцоор нь та бүхэн бас авахгүй зөвхөн бараа үйлчилгээний гэхээсээ энэ чинь дараа нь улс орны бүхий л төрлийн бодлогод үйлчлэх учраас энэ дээр анхаараад дахин хэлэлцээрээ хийгээд энэ тамхи гэдэг бүтээгдэхүүнийг энэ гаалийн татвараас чөлөөлөх асуудал дээр энийг алдуулах асуудал дээр анхаарч өгөөч л гэж хэлмээр байна.

**Ц.Даваасүрэн:** Тийм санал юм байна шүү дээ. Тэгээд анхаарна биз. Ер нь бас хөдөө аж ахуйн дараагийн энэ гишүүдийн асуултад хариулахдаа Хөдөө аж ахуйн яам тэр гурил талаасаа бас жоохон ярих нь зүгээр юм байна даа.

Алтанхуяг гишүүн асуултаа асууя.

**Н.Алтанхуяг:** Энэ сайн судлах л хэрэгтэй л дээ Гантөмөр сайд. Одоо бид нар энэ асуудал шийдэхдээ ингээд хэний эрх ашиг Монголд хөндөгдөөд байгаа юм бэ? Бүх хүний эрх ашиг биш л дээ. Ялангуяа жоохон юм үйлдвэрлэдэг хүмүүсийн эрх ашиг хөндөгдчихөв үү, аж ахуйн нэгжүүдийн салбарын. Тэгээд тэд нартайгаа жаахан суугаад яриад энэ Засгийн газар чинь ингээд салбар салбар руу шидчихээд сууж болохгүй л дээ. Эдийн засгийн хөгжлийн асуудал учраас зангидаад шийдчихвэл шийдчихмээр л харагдаад байгаа юм. Манай гишүүдийн болгоомжлоод байгаа чинь зөв шүү дээ. Ер нь энэ хүн хүмүүсийн ч болгоомжлоод байгаа юм. Юмны үнэ өсөөд юмныхаа үнийн өсөлтийг дийлэхгүй ядарч зүдэрч явахад нь дахиад нөгөө талаас тэр сая Батжаргал гишүүний хэлж байгаа тоо хэрвээ үнэн бол маш өртөг багатай маш их объём, волюм ихтэй тийм юмтай л наймаацах гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр тэдний жоохон юм ороод ирэхэд л манай энд цохигдчих магадлал нь асар өндөр юм. Тэгээд энийгээ манай хэдэн хүнтэй суугаад шийдчихэж болдоггүй юм уу? Би түрүүн Даваасүрэн даргад хэлсэн юм тэр аж ахуй эрхлэгчдийнх нь төлөөлөгч юм уу, салбарынх нь хүмүүс нь орж ирээд энэ Их Хурал дээр үг хэлмээр байх юм.

Тэгэхгүй Засгийн газрын гишүүдтэй Их Хурлын гишүүд маргаж байгаа аястай ийм дүр зураг харагдаад байх юм. Буруу байна. Дээр яагаад наад чинь ерөөсөө болохгүй шүү. Өндөгөөр цохиж унагаадаг шиг ороод л зодоон цохион хийгээ биз дээ. Тэр чинь яаж шийдэгдсэн юм? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт одоо ингээд Оросын Холбооны Улс руу баахан юм гарна, бусад улс руу гарна. Тэд нарынх намхан болчихсон, бараг 0 болчихсон гээд байх юм. Тэгээд юу гарах гэж байгаа юм яг манайхаас? Би Орос, Монголын Засгийн газрын хорооны комиссын даргаар 4 жил ажилласан. Яг л энэ тэднийхийг өндөр байдаг учраас манай юм гардаггүй гээд л олон жил ярьсан. Одоо тэгээд яг юу гарах юм? Хэдэн сая доллар манайх тийшээ гаргах, олж ирэх боломж байгаа

юм? Энэ их тийм олон үл мэдэгдэхтэй дифференциал тэгшитгэлийн систем биш шүү дээ. Маш энгийн ийм хөөрхөн эвтэйхэн бодлого байхгүй юу. Энэ яагаад энийг ингээд гардаж аваад хийгээд нэг тийшээ болгочхож болдоггүй юм. Хоёр дахь нь тэр асуулт.

Гурав дахь нь бол экспорт 1 улстай 90 хувь болчихоод байгаа юм. Манайх тэгээд хэд болох юм эд нартайгаа ингээд наймаацаад, юм хумаа хийгээд бараа таваараа гаргаж бариад овоо ингээд тэдний юм орж ирнэ, манайх бас гаргана гээд байна шүү дээ. Тэгэхээр манай экспорт энэ тал нөгөө 90-өөс чинь багасаад энэ тал руугаа хэд болох юм? Хүүш ийм тоо ярина шүү дээ, салбар ярина шүү дээ. Түүнээс биш онол ярих юм байхгүй. Тэгэхээр Дэлхийн худалдааны байгууллага бараг бид нарт падлийгүй. Энэ чинь локалный маягийн ийм худалдааны сүлжээний юм ярьж байна шүү дээ. Ийм асуултуудыг хэлээд өгье. Тэгээд экспорт.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Тийм Алтанхуяг гишүүний хэлээд байгаа шиг би нөгөө та нарыг итгэл үнэмшилгүй байна гээд байгаа юм. Эд нарт итгэл үнэмшил төрүүлээч гээд байгаа байхгүй юу. Тэгэхийн тулд экспорт жишээлбэл бид нар хэчнээн хэмжээгээр хэдэн сая доллароор нэмэгдэх боломж, ер нь 90-ээд оны эхэн үед энэ 2 орны тохирсон юм бол тэр шүү дээ. Та нар нефть, эрчим хүчээрээ, бид нар өргөн хэрэглээний бараагаараа гээд Оросууд өргөн хэрэглээний бараан дээр өндөр татвар тавьсан. Манай савхин эдлэл, ноосон бүтээгдэхүүн, ноолуур бүгд дээр нь татвар тавьсан. Одоо энийгээ өөрчлөх боломж гарч байгаа бол тэрийгээ л сайн та нар яримаар байгаа юм л даа.

Тэгэхдээ бид нар нэг юмыг ойлгох хэрэгтэй. Нэг оронд хараат болчихсоныгоо ерөөсөө тоохгүй юм. Үгүй тэгээд бусадтай найзалъя гэхээр л болгоомжлуулаад хэвтчих юм. Тэр талаас нь сайн яримаар байна.

6 номер.

**Л.Гантөмөр:** Ерөнхийдөө бид нар бол өөрийнхөө дотооддоо хийж байгаа, дотооддоо хэрэглэдэг гэж яригдаж байгаа бараануудаа хамгаалчихсан. Уламжлалт хамгаалалтаа хадгалсан гэж ойлгох хэрэгтэй. Түүнээс энэ дээр хаалга нээчихсэн юм бол байхгүй. Гол үйлдвэрлэл эрхэлдэг хүмүүсийн түүхий эд дээр хаалга нээгдэж байгаа. Өртөг нь бууна, өртөг нь бууна.

Жишээлбэл, элсэн чихэр. Элсэн чихэр дээр жигнэмэг хийдэг хүмүүсийн хувьд авч байгаа элсэн чихрийнх нь хувь, үнэ бол бууж орж ирнэ гэж ойлгох хэрэгтэй. Гэх мэтчилэн. Ер нь махаа заръя л гэж байгаа юм. Ноолуураа заръя, ноосон бүтээгдэхүүнээ заръя, хивсээ заръя. Эд нар чинь өөрөө жишээлбэл үхрийн мах 40 хувийн татвартай. Ерөөсөө энэ Евразийн зах зээл дээр манай үхрийн мах ороод өрсөлдөх ямар ч боломжгүй юм байна лээ. Яг одоо энэ 40 хувийн татвараараа бол . Энэ нь тэг болчих юм бол манайхан гаргаад эхлэх юм байна лээ л дээ.

Дээр нь хонь, ямааны мах бас татвар нь тэг болж байгаа юм гээд. Зүгээр энэ эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлье гэж үнэхээр тэмүүлж байгаа үед бол гарцаагүй ийм зах зээл олоод авчих нь бол Монгол Улсын хувьд үнэхээр уул уурхайгаас бусад салбараа хөгжүүлье гэвэл сонгох цорын ганц алхам гэдгийг бүгдээрээ л ойлгочихмоор байна л даа. Алтанхуяг гишүүний асуулт яг тодорхой

хэдийг гаргах юм бэ л гэж байгаа юм. 15 тэрбум долларын импорт байна. Яг бид нарын хийж чаддаг бараан дээр тэр улсуудад.

Тэгэхээр 15 тэрбум доллароос бид нар хэдийг нь авч чадах вэ гэдэг бид нарын үйл ажиллагаанаас л хамаарна. Бид нар л тэнд маркетинг сурталчилгаа, зохион байгуулалт, хэлэлцээр. Би энийг Евразийн сайдтай нь яриад ямар ч байсан зохион байгуулалттайгаар бид нар 1 тэрбум долларын бараа гаргана шүү гэж байгаа юм. Зохион байгуулалт гэдэг нь 2 талтай ойлголцоод ямар нэгэн байдлаар аль газрынх нь хүнсийг хангах, эсвэл аль газарт нь худалдааны төв байгуулах, эсвэл худалдааны сүлжээнд нь манай бүтээгдэхүүнүүд байрших гээд бид нарын хийх ажил их л юм байна лээ. Тэрийг Евроазийн комисс бол өөрөө бид энэ дээр туслаад явахгүй бол эцсийн дүндээ яг яриа хаанаас эхэлсэн бэ гэхлээр 97, 3-аас эхэлсэн юм байна лээ. Хэтэрхий худалдааны алдагдалтай байна. Та нар татвараа тэг л гэдэг ярианаас эхэлсэн яриа учраас нөгөө тал тэнцвэрийг бий болгохын тулд бид нар хичээж зүтгээ. Энэ зах зээлийг олж өгөх, барихад нь бид тусалъя. Тэгэхдээ мэдээж юмаа зарж ашиг олох гэж байгаа хүмүүс нь л илүү их хөдлөх юм байна лээ л дээ.

**Ц.Даваасүрэн:** Алтанхуяг гишүүн тодруулъя.

**Н.Алтанхуяг:** Би ойлгомжгүй л асуугаад байгаа юм байлгүй. Ингээд л энэнд чинь итгэл үнэмшил төрөхөө больчихоод байгаа байхгүй юу. Та болохоор тэгж ойлгох хэрэгтэй гэнэ. Бид ойлгох яах вэ. Амьдрал дээрээ яг наадах чинь яг яах юм бэ? Тэр аж ахуй эрхлэгч чинь энд байгаа юм уу? Тэр Худалдаа аж үйлдвэрийн танхим ч гэнэ үү тэд нараас чинь хүн байгаа юм уу? Тэд нараас чинь хариулах амьтан байгаа юм уу? Одоо манай салбар дээр асуудал байхгүй. Эсвэл бүх салбар асуудалгүй болсон уу? Ийм тодорхой юм надад хэлээд өгөөч. Би тэгээд ингээ Гантөмөр сайдаа та Оросын Холбооны Улсын тариф жишээлбэл манай гаргах гэж байгаа юун дээр хэд байж байгаад хэд болчихоод байгаа юм? Тэр чинь л үнэхээр багассан, зарим нь 0 болсон бол хөшүүрэг болж магадгүй л дээ. Яг тодорхой юм хэлээд өгөөч. Бензин дээр та амьдралын жишээ аваад тайлбарлаад өгөөч. Одоо би тэр Увсаар 1 удаа цаашаа гарсан. Цаад талд бол бензин гарангуут нам унадаг юм байна лээ.

**Ц.Даваасүрэн:** Ингээ. Одоо байна шүү дээ Хөдөө аж ахуйн яам Болорчулуун дарга, Худалдаа аж үйлдвэрийн яамнаас хэн байна? Ерөнхийлөгч нь. Ингээд та 2 ямар ч гэсэн хариулаадах. Сая тэр махных жишээлбэл тэг болж байна гэдэг шиг хөдөө аж ахуй дээр тэр гурилаа яаж хамгаалж байгаа юм хөдөө аж ахуйн. Хөөш 10 тэдээс 1 тэрбум олох гэж биш ер нь яг ингээд та нар тооцоо хийж үзсэн байгаа бол ийм хэмжээгээр бол бид нар арьс, ноос, ноолуур, мах зах нэмэгдээд тэдэн тэрбум орчим доллар нээгдэж байгаа гэж тиймэрхүү хариултуудыг өгчихвөл их сайн байна. 3 номерын микрофон Болорчулуун. Дараа нь хариулна.

Болорчулуун, гурилаа хамгаалах, тэгээд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт.

**Ц.Болорчулуун:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун.

Ер нь энэ чөлөөт худалдааны түр хэлэлцээртэй холбоотойгоор асуудал яваад сая 2025 оны 1 сарын 7-нд Эдийн засаг, хөгжлийн сайдын тушаалаар дэд

ажлын хэсэг байгуулах ийм тушаал ирсэн. Үүнтэй холбоотойгоор мэргэжлийн 18 холбоо оролцсон ийм дэд ажлын хэсгийг байгуулсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ахлаад. Энэ 18 холбоог оролцуулсан дэд ажлын хэсгийг байгуулж, 3 удаа хуралдсан байгаа.

3 удаа хуралдаад 375 бүтээгдэхүүн дээр санал авсан. Эцсийн байдлаар 23 бүтээгдэхүүнийг дахиж судалж үзээч энэ бол бид нарын дотоодын үйлдвэрлэлтэй харшилж байна гэдэг энэ саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд 3 удаа энэ саналыг тавьсан. 3 дахь, сүүлийн саналаар бол.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** номерын микрофоныг сунгая.

**Ц.Болорчулуун:** Оросын Холбооны Улс улсын энэ ажлын хэсгийнхэнтэй хуралдахад бас миний бие бас хамт оролцсон. Ингээд энэ дээр хамгийн сүүлд энэ бүтээгдэхүүнүүдийн саналыг хүлээж авсан. Дээрээс нь өндөг, улаан буудай, хуурай сүүтэй холбоотой асуудлыг эргэж харж үзээч гэдэг саналыг бас энэ ажлын хэсгийн хурал дээр тавьсан. Ингээд сүүлийн хэлэлцээрээр бол эцэслэж ирснээр гурил, улаан будаан гурилыг, юу буудайг бол 50 мянган тонныг 3.75 хувийн татвартайгаар гээд,

**Ц.Даваасүрэн:** Одоо хэдийг авдаг юм?

**Ц.Болорчулуун:** 5 хувийн татвар авч байгаа.

Ер нь улаан буудайн байдлаар бид нар Атрын-4 дүгээр аян хэрэгжүүлээд сүүлийн арваад жилийн хугацаанд энэ газар тариалангийн салбарт нэлээдгүй хэмжээний хөрөнгө оруулалт хийснээр улаан буудайгаа бас яг дотоодын үйлдвэрлэлээр хангах ийм нөхцөл боломж бүрдсэн. Тоног төхөөрөмжийн хувьд, газрын газрын хувьд, технологийн хувьд. Бид нар бол жилдээ яг 20 оны КОВИД-ын жилээс хойшоо.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Дахиад 1 минут сунгая. Чи тодорхой хариул. Жишээлбэл та нар гурил холихын тулд авдаг нь үнэн юм уу, худлаа юм уу?

**Ц.Болорчулуун:** Манайд үүсэж байгаа энэ гангийн нөхцөл байдалтай холбоотойгоор бид нар сүүлийн жилүүдэд бас 80 хүртэл мянган тонноор энэ импортын гурилыг авч байсан. Тэр нь бол мэдээж чанар сайжруулагч гээд дотоодын ургацтайгаа холиод гаргадаг ийм асуудал байгаа. Тэгэхдээ 50 мянгыг одоо яг хэлэлцээрийн сүүлийн байдал ирж байгааг 50 мянгыг дотооддоо бас энийг бид нар ийм хэмжээнд байхад их эрсдэл үүсээд байх нь харьцангуй гайгүй гэж тооцоолж байна.

**Ц.Даваасүрэн:** Экспорт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн дээр яах вэ?

**Ц.Болорчулуун:** Экспортын хувьд бол мэдээж мэдээж тодорхой хэмжээний нэг талын зах зээл биш, бас 5 орны зах зээл гарч байгаа учраас боломжууд үүс үүсэж байна гэж харж байгаа. Тэгээд мэдээж манай бүтээгдэхүүний чанар, бусад худалдааны яриа хэлэлцээр гэдэг бусад зүйл хүчин зүйлүүдээс хамаарч экспорт ямар хэмжээнд явах нь харагдах байх л гэж бодож байна.

**Ц.Даваасүрэн:** Тооцоогүй л байна гэсэн үг. 8 Худалдаа аж үйлдвэрийн танхим.

**Л.Төр-Од:** Та бүгдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Төр-Од Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим Ерөнхийлөгч бөгөөд Удирдах зөвлөлийн дарга.

Бид нарын танхимын хувьд бол зарчмын хувьд бол бид нар 23 оны, 2023 оны 11 дүгээр сараас бол энэ асуудал дээр анхаарал тавьж ажиллаж байгаа. Зарчмын хувьд дэмжиж байгаа. Түрүүн бас Гантөмөр Тэргүүн Шадар сайд дурдсан 4, 5 нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан. Эргээд салбарынхантайгаа түрүүн дурдаж байна тэр Хүнсчдийн холбоо, Ноос, ноолуур эд нар гээд бүгдтэй нь уулзаад, ярилцаад асуудлыг нь аль болох 2 талдаа ашигтай байдлаар шийдэл гаргаад явж байгаа. Танхимаас гол манай бизнес эрхлэгчдийн экспортлогчид, импортлогчид бол бүгдээрээ дэмжиж байгаа. Яагаад ингэвэл Евразийн эдийн засгийн холбооны улсуудтай тухайлбал ОХУ-уудтай манай гаалийн тариф нь 5 хувь байдаг. Оросын холбооных нь болохоор 5-аас 50 хүртэл байдаг. Тийм учраас.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** 8-ыг 1 минут нэмье.

**Л.Төр-Од:** Тэгэхээрээ бид нар бол гол нь арьс шир, ноос ноолуур, мах, махан бүтээгдэхүүн, нэмээд бид нар зарим улстай нь бол махыг нь дайвар бүтээгдэхүүн гаргахаар бол хэлэлцэн тохиролцож байгаа. Би өөрөө эдгээр улс орнуудын танхимын дарга нартай бол 12 дугаар сард уулзсан. Одоо 5 дугаар сард уулзах гэж байна. Улаанбаатарт би бас Төв Азийн танхимын дарга нарын Ерөнхийлөгч нарыг бас Улаанбаатар хотод хуралдуулахаар бол тохирчихсон байгаа. Тийм учраас олон тал талаасаа ч тэр, хоёр тал талаасаа ч тэр Засгийн газрын комиссын бүрэлдэхүүнд орж байгаагийн хувьд бол бид нар өөрсдийнхөө үндэсний үйлдвэрлэгч болон экспортлогчдын эрх ашгийг бол хамгаалаад явж байгаа. Тийм учраас зарчмын хувьд дэмжиж байгаа.

Тоо баримт хэрэгтэй гэвэл бид нар, би өөрөө 2019 оны Европын холбоогоос хийсэн судалгаан дээр экспертээр оролцож байсан. Ер нь бол манай дотоод нийт бүтээгдэхүүн бол дунд хуга.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** 1 минут 8 номерын микрофон дээр нэмээд өгчих.

**Л.Төр-Од:** ДНБ бүр доод тал нь одоогийн боломжоороо бол 1 хувиас дээш өсөхөөр байгаа. Оросын Холбооны Улс руу мах, махан бүтээгдэхүүний бүтээгдэхүүн 140 хувийн өсөлттэй байхаар, Казахстан руу бол 125 хувь, нэхмэл эдлэл 55-аас 55 хувь, савхин эдлэл 50 хувиас дээшээ. Ер нь бол дунд болон урт хугацаандаа 159 хувь. Бусад уул уурхай олборлолтын гаргаж байгаа бүтээгдэхүүн 17, Беларус т гарах экспорт бол 20 хувь хүртэл нэмэгдэхээр ийм судалгаа бол гарсан байгаа. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Савхижуулбал Орос чинь өөрөө савхин эдлэлийн үйлдвэрлэлээрээ дэлхийд эхний 5-д орчихсон юм байна лээ шүү дээ.

Гантөмөр сайд, 6.

**Л.Гантөмөр:** Алтанхуяг даргын асуултад тодорхой хариулъя. Үхрийн мах Алтанхуяг даргаа 50 хувийн татвартай байгаа. Энэ тэглэгдэнэ. Хонь, ямааны мах 15 хувийн татвартай байгаа. Энэ тэглэгдэнэ. Малын дайвар бүтээгдэхүүн 15

хувийн татвартай байна. Энэ тэглэгдэнэ. Хиа, зайдас, нухаш 20 хувь хүртэл татвартай байгаа. Энэ тэглэгдэнэ. Нөөшилсөн махан бүтээгдэхүүн 20 хувийн татвартай байгаа. Консерв гэсэн үг. Энэ тэглэгдэнэ. Сүү, сүүн бүтээгдэхүүн 15 хувийн татвартай байгаа. Энэ тэглэгдэнэ. Зөгийн бал 15 хувийн татвартай байгаа. Энэ тэглэгдэнэ. Малын яс 10 хувийн татвартай байгаа. Пүрэвдаваа гишүүн ээ Алтанхуяг дарга нөгөө бодитой тоо сонсьё гээд байгаа. Малын өөх тос 15 хувийн татвартай байгаа. Энэ тэглэгдэнэ. Ургамлын тос 15 хувийн татвартай байгаа. Энэ тэглэгдэнэ. Гоймон 15 хувийн татвартай байгаа. Энэ тэглэгдэнэ. Ясны шөл 12.5 хувийн татвартай байгаа. Энэ тэглэгдэнэ. Хүнсний бараа 12 хувь хүртэл татвартай байгаа. Энэ тэглэгдэнэ. Чихэрлэг ундаа, шүүс 8-аас 9 хувийн татвартай байгаа. Энэ тэглэгдэнэ.

**Ц.Даваасүрэн:** 6 номерыг 1 минут нэмчих.

**Л.Гантөмөр:** Арьс шир нь арьсан цүнх, гар үүргэвч энэ тэр 13-аас 15 хувийн татвартай байгаа. Энэ тэглэгдэнэ. Нэхий хүрэм, хантааз 10 хувийн татвартай байгаа. Энэ тэглэгдэнэ. Ноолууран, даавуу, ээрмэл, ноос 10 хувийн татвартай байгаа. Энэ тэглэгдэнэ. Ноос, ноолууран хувцас 15-аас 18 хувийн татвартай байгаа. Энэ тэглэгдэнэ гэх мэтчилэн сүлжмэл ороолт, алчуур одоо манай ноолуур хийгээд байгаа хүмүүс алчуур хийдэг. Тэр 18 хувийн татвартай байгаа. Энэ тэглэгдэнэ. Оёмол хувцас 18 хувийн татвартай байгаа. Энэ тэглэгдэнэ. Хивс хаана хаана байна? Хивс 15 хувийн татвар, сүлжмэл хэд гэнэ? 22 дээр эсгий дэвсгэр, хивс 10 хувийн татвартай юм байна. Энэ тэглэгдэнэ гэх мэтчилэн бид нар бол хийж чадах бараануудаа хараад тэгээд энийгээ бол.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Батлут гишүүн асуултаа асууя. Одоо харин та нарын хариулт болж байна. Батлут гишүүн.

**Д.Батлут:** Өдрийн мэнд хүргэе. Ер нь их ойлгомжгүй асуудлыг л хэлэлцээд байна л даа өнөөдөр бид нар. Эдийн засгийн яам болохоор, хөгжлийн яам болохоор энэ хэлэлцээрт орсноор ашигтай гэдэг, Гадаад харилцааны яам ашиггүй, МУИС-ийн Бодлогын судалгааны лаборатори бол ашиггүй гээд гаргачихсан. Алинд нь итгэж итгэл үнэмшлээр хандах вэ гэдэг нь асуудалтай болчихоод байгаа гэсэн үг. Тэгээд эндээс би тодруулж хэд хэдэн асуулт асууя.

Мэдээж энэ гэрээ хэлэлцээрт орсноор харилцан ашигтай л байх ёстой юм. Тэгээд өнөөдөр бид нар энэ гэрээ хэлэлцээрт ороход манай Монгол Улсаас экспортолж байгаа барааны 90 орчим хувь нь ОХУ-тай хамааралтай байгаа. Махан бүтээгдэхүүн дээр жишээ аваад үзье л дээ. Экспорт нь 140 хувь нэмэгдэх юм байна. Ингээд татвараас чөлөөлөгдөнө гээд үзэх юм бол ойролцоогоор 2 сая төгрөгийн л, 2 сая долларын л нэмэлт боломжууд гарч байгаа юм. 2 сая долларынх шүү. Одоогийн яг тоо хэмжээгээрээ. Энэ тэгээд хангалттай үзүүлэлт юм уу? Нэг.

Хоёрдугаарт нь Оросын Холбооны Улс Зөвхөн гаалийн татварт, энэ хэлэлцээрт орсноор зөвхөн гаалийн татвараа тэглэх юм уу? НӨАТ, онцгой албан татваруудаа яах юм? Энэ чинь цаашлаад зах зээлд өрсөлдөх боломжууд дээр бас эерэг, сөрөг нөлөөллүүдийг үзүүлнэ шүү дээ. Энэ дээр та бүхэн юу гэж хандаж байгаа юм бэ? Оросын Холбооны Улс дэлхийн топ 5 мах экспортолдог орны нэг гээд бод доо. Беларус улс үхрийн мах экспортолдоогоороо алдартай. Монгол Улс энэтэй өрсөлдөх ямар ч боломж байхгүй. Эндээс бид юуг нь ашигтай гэж хараад байгаа юм бэ? Тэр дээр нь хариулт өгөөдхөөч.

9 жилийн өмнө Японтой бас манай улс иймэрхүү гэрээ хэлцэлд орж ирсэн. Тэгээд бид нар яах вэ гэхээр нөгөө тарифын бус шаардлагуудыг нь хангаж чадахгүйгээс болоод манай экспорт буурчихсан. Эсрэгээрээ нөгөө хуучин автомашинууд л манайд маш ихээр орж ирсэн шүү дээ. Одоо бид нар энэ гэрээ, хэлцэлд орсноороо тарифын бус шаардлагуудыг нь хангаж чадах юм уу? Яг эцэстээ 1 жилийн дараа, 2 жилийн дараа тарифын бус шаардлага хангаагүй гээд бид нар экспортод бараг байхгүй болчихсон. Нөгөө талаасаа асар том гаднын зах зээлийг Монгол Улсдаа бий болгосон байж байх вий дээ.

Үүнтэй холбоотой 2 дахь асуулт. Монгол Улс Хүнсний хувьсгал, Атрын 4 дүгээр аян, хүнсний үйлдвэрлэлээ хөгжүүлье гээд асар их мөнгийг зарцуулж байгаа. 8.9 их наяд байна уу даа тийм ээ. Тэгээд энэ мөнгөө ингээд хүнсний үйлдвэрлэлээ хөгжүүлье гэж явсан мөртөө буцаагаад ийм боломж олгохоор манайд ямар асуудлууд үүсэж байгаа вэ гэхээр архи, архины төрлийн бүтээгдэхүүн 94.6 хувь нэмэгдэнэ. Сүү, сүүн бүтээгдэхүүн 70.3 хувиар нэмэгдэнэ гэхчхэн байна. Бид нар чинь энэ малчдынхаа сүүг боловсруулаад сургууль, цэцэрлэгийнхээ, тэгээд нийтийн хэрэгцээгээ хангая л даа хөөе. Бид дотоод дахь эх үүсвэрээр дотоод дахь хэрэгцээгээ хангадаг болъё л доо. Ингээд гаднаас аваа.../минут дуусав./

#### **Ц.Даваасүрэн: 6 хариулъя.**

**Л.Гантөмөр:** Нөгөө сүүлд 23 бараан дээр бид нар квот болоод тарифаа сэргээснээс хойших биш өмнөх судалгааг та нар яриад ингээд төөрөөд байна Батлут гишүүн ээ. Одоо таны гар дээр байгаа архи 94 хувь нэмэгдэнэ энэ тэр гэдэг судалгаа бол архины татварыг тэглэсэн үеийн яриа. Одоо бол татвар 30 хувьтай үлдэж байгаа. Сүү бол хасагдсан. Нэг үгээр хэлбэл Гадаад яамны сайд харин азаар байж байна. Гадаад хэргийн яам эсрэг байна гэдэг ийм мэдээллийг Гадаад хэргийн сайд өөрөө байр сууриа илэрхийлэх байх. Энэ сая Аж үйлдвэрийн танхим өөрийнхөө байр суурийг илэрхийлчихлээ. Аж үйлдвэрийн танхим гэдэг бол та бүхэн надад итгэхгүй байна гээд ингээд байгаа юм. Аж үйлдвэрийн танхим бол бүх компаниудаасаа саналаа авчихсан байгаа.

Тэгэхээр таны санаа зовоогоод байгаа бараа, бүтээгдэхүүнүүд дээр бид нар уламжлалт хамгаалалт хэвээрээ байгаа. Хэвээрээ байгаа. Бид өөрт оногдоод байсан тарифуудыг л хөнгөлсөн. Бид зах зээл олох гэж энэ санаачилгыг гаргасан байх. Нөгөө талын хэлдэг ганцхан үг байдаг. Та нар эхэлсэн шүү дээ. Та нар ирж санал тавиагүй бол бид танайд огт санал тавихгүй ээ, тавиагүй. танай зах зээлийг бид нар ингэж тоож харьцахгүй гэж хэлж байгаа шүү. Та нар л махаа заръя, ноосоо заръя, ноолуураа заръя, хивсээ заръя, жимсээ заръя гээд ийм асуудал яриад байгаа учраас та нарт боломж гаргаж өгч байна гээд. Одоо уг нь энийг ингээд хэдүүлээ хаалттай яримаар байхгүй юу.

Тэгэхгүй ингээд Монголчууд гуйж оччихоод одоо сэрэмжилнэ гэхээр ингээд мэдээллийн зөрүү дээр л манай гишүүд жоохон яагаад байна, эргэлзээд байна л даа. Яг үнэндээ саяын энэ Эдийн засгийн байнгын хороон дээр тараах гээд байгаа тооцоо судалгаа бол бүгд 1 сараас өмнөх судалгаа. Хэлэлцээр явж байх үеийн. 1 сараас хойш бол 2 ажлын хэсэг гараад хэлэлцээр хийгээд одоо бол шал эсрэгээрээ асуудал яригдана гэдгийг бүгдээрээ ойлгооч. Гадаад хэргийн сайд Гадаад яамны байр сууриа илэрхийлээч.

**Ц.Даваасүрэн:** Хөөш Гадаад хэргийн сайд энэ тэр хариулах гэж байна. Тийм учраас хэдүүлээ ингэх үү? Энийг ер нь хаалттай горимд шилжүүлчих үү? Ингэе хөөе. Хэдүүлээ ингэе. Одоо ингээд Гадаад харилцааны сайд маань бас хариулах гэж байна тиймээ. Тэгээд тодорхой хариулт сонсьё. Тийм учраас хэдүүлээ ингэе хаалттай горимд шилжүүлчихье. Тэгээд нэлээн тодорхой ярья.

Энийг хаалттай горимд шилжүүлчих манайх.

Ингэе хаалттай горимд шилжүүлэе гэдэг санал хураалт хийх юм байна. Хаалттай горимд шилжүүлээд дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү.

Батцэцэг сайд хариулъя.

**Б.Батцэцэг:** Товчхон мэдээлэл өгье. Батлут гишүүний хувьд бас Гантөмөр сайд хэллээ хольж ойлгоод байх шиг байна гээ. Энэ манайх бараа, бүтээгдэхүүнээ экспортолъё, харилцаагаа худалдаа худалдааных нь чиглэлээр жоохон тэнцвэртэй байлгаж гэдэг саналыг манай Монгол Улсын зүгээс Оросын Холбооны Улсад тавьж байсаар ирсэн. Тэгээд энэ Евразийн эдийн засгийн холбоо бол 2015 онд байгуулагдсан шүү дээ. Тэгээд энэнээс хойш манайх Оросын Холбооны Улсын зүгээс бол манайхыг гишүүнээр элс гэж ерөөсөө шахаагүй, хэзээ ч тэгж хэлж байгаагүй. Танайд ажиглагч байж болох юм, эсвэл чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулъя гэдэг ийм саналыг хэлж байсан. Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах ажлын хэсэг 2 талдаа байгуулагдаад 2016-2018 оны хооронд ажилласан.

Ингээд тэн дээр бол яах вэ манайд ашиггүй юм байна гэдэг тооцоог ажлын хэсэг дээр гаргасан. Энэ Чөлөөт худалдааны хэлэлцээрийн тухайд шүү. Ингээд Монголд Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдсанаас хойш Хүрэлбаатар сайд Оросуудтай нэлээн олон удаа хэлэлцээр хийгээд энэ Батлут гишүүнээ чөлөөт худалдааны хэлэлцээрээс манайх гарлаа гэдгээ 2022 онд илэрхийлсэн юм. Батлут гишүүнээ би таны асуултад хариулж байна шүү. Тэгээд энэ чөлөөт худалдааны хэлэлцээр хийх асуудлаас манайх гараад тэгээд энэ түр хэлэлцээр гэдгийг бол энэ Евразийн эдийн засгийн холбоо манайд комисс санал болгосон Ираны загвар дээр. Иран улстай энэ түр хэлэлцээрийг 3 жилийн хугацаатай байгуулаад яг манайх шиг ийм хэлцлүүд хийгээд 3 жил нь дуусаад одоо үндсэн гишүүнээр элсэх хэлэлцээрээ Иран улс эхэлчихсэн байгаа юм.

Энэ чөлөөт худалдааны хэлэлцээрийг бол Сингапур, Серби, Вьетнам, Иран хийж байгаа. БНХАУ гээд энэ 4 улс байгуулчихсан чөлөөт худалдааны хэлэлцээрийг. Энэ түр хэлэлцээр бол 3 жилийн хугацаанд бид нар хэрэгжүүлээд энэ хугацаанд манай аж ахуйн нэгжүүдийн бараа, бүтээгдэхүүнээ экспортлох төрөл зүйл нэмэгдэх, сонирхол нэмэгдэх, зах зээл нь нээгдэх л ийм боломж манай улсын хувьд нээгдэж байгаа юм. Бид нар өөрөө ч ийм зорилготой анх саналаа тавьсан юм байна лээ. Тэгэхээр энэ тодорхой хэмжээнд бараа, бүтээгдэхүүн Орос руу гардаггүй ганцхан Хятад гэдэг зах зээлтэй учраас магадгүй манай үндэсний үйлдвэрлэл ч бас сайн хөгжихгүй байгаа байх. Яг хөдөө аж ахуй дээрээ суурилсан.

Тэгэхээр энэ чөлөөт энэ түр хэлэлцээрийг байгуулаад 3 жилийн дараагаар бид нар эндээс гарч болно. Эсвэл бид нар цаашаа хэлэлцээгээ үргэлжлүүлж болно. Энэ дээр энэ түр хэлэлцээрийг байгуулчихаад дараа нь энийг заавал элсэх ёстой ч юм уу, гарна гэсэн гарж орж болно гэсэн ийм хатуу заалтууд байхгүй.

Энийг Оросууд бас бид нартай нэлээн ийм Евразийн эдийн засгийн комисс нэлээн ийм уян хатан байдлаар хийж байгаа шүү гэдгийг хэлэх байна.

**Ц.Даваасүрэн:** Баярлалаа. Энэ чинь түр 3 жилийн дараа бол татгалзаад гарчхаж болох л юм байна шүү дээ уг нь бол.

Цогтбаатар гишүүн асуултаа асууя. Тодруулах юм уу? Батлут, Батлут гишүүн тодруулъя.

**Д.Батлут:** Би баахан хэд хэдэн асуулт асуусан чинь ерөөсөө дорвитой хариулт авсангүй сайдаас. Би танд бас энэ судалгаануудыг худлаа ч хэлээгүй юм л даа МУИС-ийн Бодлогын судалгааны лабораториос 2025 оны 3 сард хийсэн судалгааны дүнгээр ярьж байгаа юм. Тэгээд та юуг нь сонсчихоод аль эртний юм энэ тэр гээд яриад байгааг ойлгохгүй байна.

Би юу гэсэн бэ гэхээр махан дээр жишээ авъя гэж байгаад ярьсан шүү дээ. Энэ НӨАТ-ыг нь тэр бусад татваруудаа яах юм?

Хоёрдугаарт нь бид нар энэ тарифын бус шаардлагуудаа хангаж чадах уу? Ийм зүйл Японтой бид нар гэрээ хийгдэж байсан. Энэний эсрэг бид нарт юу бий болсон бэ гэхлээр дандаа л хуучин машины хаягдал болж хувирлаа шүү дээ манай Монгол Улс. Иймэрхүү нөхцөл байдлууд бий болчих вий л гэж яриад байгаа юм. Дээрээс нь тэр.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Хариулъя. Гантөмөр сайдын микрофон 6.

**Л.Гантөмөр:** Одоо яг үнэндээ миний ярьж байгааг ерөөсөө сонсохыг та нар хүсэхгүй байна. Би бол бүтэн хариулсан. Наад МУИС-ийн багш нар чинь 375 барааг бүгдийг нь тэглэнэ гэдэг дээр судалгаа хийсэн юм байна лээ шүү. Бид нар бол 375 бараанаас 23 бараан дээр нь эргэж хэлэлцээр хийсэн шүү. Хийгээд 375-аас 8 барааг бүрэн хассан шүү хэлэлцээрээс. Энийг нэгдүгээрт би яг шулуухан ийм болсон гэдгийг хэлье. 3 сар судалгаа хийж байхад тэрнээс хойш би хэлэлцээр хийсэн юм. Эцсийн байдлаар тохирсон нь бол чуулган эхэлсний дараа юм.

Тэгэхээр эцсийн судалгааг манайхаас аваарай гэдгийг хэлмээр байна. Өгчихсөн байгаа. Нэг.

Хоёрдугаарт, Оросын Холбооны Улсын дотоод татвар руу бид нар орохгүй, орж болдоггүй юм. Манай дотоод татвар руу Оросын Холбооны Улс орохгүй. Манай онцгой, НӨАТ руу аль гаднын улс орж ирдэггүй. Тэр улсын онцгой НӨАТ руу бид ордоггүй. Тэгэхээр бидэнд байгаа боломж өөрийнхөө дотоодын хүнсний НӨАТ-ыг бууруулах боломж бидэнд байна. Бид тэр рүү алхах байх. Гаднаас импортолж байгаа хүнс дээрээ бид нар НӨАТ-аа хэвээр нь хадгалах хэрэгтэй гэх мэтчилэн бид нарт өөрсдөд нь дотоод зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах өөрийн гэсэн хэрэглэх хэрэгслүүд зөндөө байна гишүүнээ. Энэ болгоноо бид нар ашиглана. Үндэсний үйлдвэрлэл хамгаалагдана.

**Ц.Даваасүрэн:** Дутуу тодруулсан гээд 1 минут Батлут. Батлут гишүүний микрофон. Дутуу тодруулсан.

**Д.Батлут:** Хэлэлцээр хийгээд судалгаа хийгээд бэлэн болчихсон гээд өгчхөөч наад судалгаануудаа. Тэгээд та нар мэдээллүүдээ өгөөгүй байж байж

дараа нь тэгээд янз янзын зүйл яриад байх шаардлагагүй гэж бодож байна. МУИС-ийн энэ судалгааны баг чинь бас танаас дутахааргүй судалгаа хийсэн хүмүүс шүү. Би бүгдтэй нь бас танилцсан өөрөө. Тэгээд ийм хоёрдмол утгатай аль аль тал нь ойлгогдоход бэрхтэй маргаантай асуудлууд оруулж ирж байгаа. Яг үнэндээ түрүүч гишүүд хэлж байна лээ. Бид нар хэлэлцээрт нэгдэх гэж байгаад дотоод дахь үйлдвэрлэлээ татаж унагачхаад байх вий дээ. Уул нь дэмжих гээд ч байгаа юм шиг.

Тэгэхдээ нөгөө талдаа бас татаж унагах гээд байгаа нөхцөл байдлууд үүсчих вий л гэж болгоомжилж бид нар ярьж байгаа юм. Цемент яалаа, гурил яалаа. Олон асуудлууд үүнээс урган үүн шиг ингэж бий болсон зүйлүүд байгаа шүү дээ. 9 жилийн өмнө Японтой хийсэн гэрээ, хэлэлцээрүүдийг хараарай бас. Бид нар болохгүй гэж хэлээгүй. Эрсдэлүүдийг нь яаж хаах ёстой юм бид нар, яаж яавал зөв байх вэ гэдэг талаасаа л асуу.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Санал хэлчихлээ. Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

**Да.Цогтбаатар:** Байнгын хорооны дарга болон гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ асуудал дээр өмнөх дарга нарын санал гэдгийг бол ойлгож байна. Энийг Гантөмөр сайд шинээр гаргаж ирээд явуулаад байгаа ажил биш гэдгийг маш сайн ойлголоо. Гэхдээ бид нар хэт нэг талдаа гадаад худалдаа хийгээд нэг талаасаа хамааралтай байгааг болиулах гээд байна гэдгийг бас ойлгож байна.

Гэхдээ дотоодын үйлдвэрлэл эрхлээд байгаа аж ахуйн нэгжүүдээ бас үгүй хийчих вий гэж бас болгоомжлол байгаа юм. Тэгээд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нь сая сонслоо. Дандаа дарга нар байна. Дандаа дарга нар. Уг нь бол наадах чинь дарга нар биш яг нөгөө дотоодын аж ахуйн нэгжүүд нь орж ирж суугаад бид нарт ийм ач холбогдолтой, ийм үр дүнтэй, ийм ажлын байр нэмэгдэж, ийм валютын орлого олох гээд байгаа учраас бид нарыг, та бүхэн энийг хэлэлцээд дэмжээд өгөөч гэсэн бол илүү үр дүнтэй байх болов уу гэж бас бодож байгаа юм.

Гурил дээр жишээлэхэд энэ чинь улаан буудайн татварыг тэглэлээ гэдэгтэй холбоотойгоор баахан хэрүүл үүсээд л тэгээд баахан ойлгомжгүй байдал дотоодын аж ахуйн нэгжүүд нь хохирчихсон юм шиг ойлголттой болоод л хоцорсон. Бас 1 жишээ нь энэ өндгөн дээр. Өндөгний бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд маш их хэмжээний зээл аваад, хөрөнгө оруулалт хийгээд, тоног төхөөрөмжөө сайжруулаад, дотоодын энэ хэрэгцээгээ хангая гэдэг энэ үйл ажиллагаа руу чиглээд явж байгаа гэдгийг бас дарга нар бас хараарай гэж бодож байгаа.

Тэгээд хөдөө яг малчдын гар дээр бол хавар болж байна. Хавар ноолуурын цагаар хэдэн төгрөг очдог. Намар нядалгааны үеэр мал махны үеэр хэдэн төгрөг очдог байсан. Одоо аль аль нь очихоо байчихлаа. Тэгэхээр малчдын гар дээр яг эцсийн дүндээ хэзээ, яаж мөнгө очих вэ гэдэг дээр бас тодорхой хариулт байна уу? Уг нь энэ чинь арьс ширтэй холбоотой бүтээгдэхүүнийг гаргана гээд байгаа арьс ширээр яг юу хийгээд хэдий хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлээд хэдэн төгрөгийн орлого олоод байгаа юм бэ, хэдээс хэд болж өсөх гээд байгаа юм бэ гэдэг дээр бас яг тоочны хариулт хэрэгтэй байна.

Бид нар энд экспорт, импорт, гадаад, дотоод худалдаа гэж яриад байхаар малчдад ойлгомжтой асуудал очихгүй байгаа. Энэ хэдэн нэр томьёо чинь малчдын

чихэнд очиж наалдахгүй, яг хэдэн төгрөгийн орлоготой болох вэ гэдэг дээр л асуулт хариулт хэрэгтэй байгаад байна. Тэгээд энэ дотоодын аж ахуйн нэгжүүдээ дотоодод үйлдвэрлэж чадаад байгаа энэ үйлдвэрлэл эрхлэгч нарт ямар үр дүнд хүрэх вэ гэж. Сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, арьс шир яг хэзээ гарах юм? Одоо жишээлэхэд гарахгүй байгаа. Тэгээд энэ гараад хэзээ малчдын гар дээр мөнгө очих вэ гэдэг дээр тодорхой хариулт өгөөч.

**Ц.Даваасүрэн:** Энхбаяр сайд хариулъя. Тэр улаан буудай, гурил үйлдвэрлэгч нарт хүнд цохилт болох уу гэж байна. Экспорт хөдөө аж ахуй дээр яаж нэмэгдэх юм бэ гэж байна. Тэгээд саяын Цогтбаатар гишүүний асуусан зүйлүүд дээр. Тэр экспорт хөдөө аж ахуйд хэр нэмэгдэх юм бэ гэдэг дээр бүүр тодорхой тоонууд гишүүд нэхээд байгаа юм шүү.

**Ж.Энхбаяр:** Экспортоос эхэлье. Экспорт үндсэндээ 980 сая доллар хүрсэн 24 оны гүйцэтгэл. Ноолууран бүтээгдэхүүн 404 сая доллар давсан. Мах, махан бүтээгдэхүүн 300 сая доллар давсан. Бусад нь арьс шир, дайвар бүтээгдэхүүн, үр тариа, тосны ургамлын экспорт. Тэгэхээр салбарын экспорт тогтвортой өсөж байгаа. Сүүлийн 10 жил тасралтгүй өсөж байгаа нэг. Ямар бодлогоор малчдад мөнгө очих вэ гэж нэгдүгээрт ноолуур, хоёрдугаарт мах, гуравдугаарт бусад түүхий эд үнэ цэнд оруулах. Энэ бодлогын хүрээнд Улсын Их Хурлаас баталсан Цагаан алт, Атрын-4, Хүнсний хувьсгал, Шинэ хоршоо энэ дөрвөн бодлого дөрвүүлээ энд чиглэж байгаа. Түүхий эд бэлтгэн нийлүүлж байгаа малчдаа хөдөлмөрөөр нь хоршиж үйлдвэрүүдтэй нь холбоё. Үйлдвэрүүд нь боловсруулалтынхаа түвшнийг сайжруулж, экспортын чиг баримжаатай чадавхаа нэмэгдүүлье.

Ноолуурын тухайд өнөөдөр Монгол Улсад ноолуураа бид 100 хувь угаах, мөн 100 хувь самнах хүчин чадлыг суурилуулж дууссан. Одоо угаасан ноолуурыг зөвхөн экспортолж байсан бол энэ жилээс эхлээд 100 хувь самнасан ноолуураа экспортолъё гэж байгаа. Энэ угаах, самнахын хооронд багаар бодоход 500-аас 700 тэрбум төгрөгийн нэмүү өртөг Монголд татвар, цалин Монгол Улсын аж ахуйн нэгжүүдэд орлого болж үлдэнэ буюу бид эцсийн бүтээгдэхүүн боловсруулах түвшин рүүгээ л дөхөж байна гэсэн үг. Ноолуураар эцсийн бүтээгдэхүүн хийх түвшин 20 хувьтай байгаа. Утас 20 хувьтай. Эцсийн бүтээгдэхүүн сүлжээ 20 хувьтай. Энийгээ 40-өөс 50 хувьд хүргэх нь дараагийн зорилт.

Ноолуурын 404 сая долларын экспортыг бид нар энэ бодлогоо тууштай хэрэгжүүлж чадвал ойрын хугацаанд 1 тэрбум долларын экспорт хийх чадавх бодитой байгаа. Үйлдвэрлэлийн чадавх суусан. Энэ Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрүүд маань дэмжлэгээ аваад, хөрөнгө оруулалтаа хийгээд, үйлдвэрлэлээ өргөтгөж байна.

Хоёрдугаарт энэ бодлоготой холбоотойгоор ноолуур унаж байгаа гэж яриад байгаа. Үгүй. Яг дэлхийн эдийн засаг өөрөө энэ тарифын том энэ худалдааны өрнөж байгаа дайнтай холбоотойгоор хаана хаанаа амаргүй байна. Харин бид дотооддоо боловсруулах чадавхаа нэмсэнтэй холбоотойгоор ноолуурын үнийг тогтвортой барьж чадаж байгаа. Үндсэндээ зүүн 3 аймгийн ноолуур үндсэндээ 90 хувь худалдан авалт хийгээд дуусаж байна. Одоо төвийн бүс рүү шилжиж байна. Зүүн 3 аймгийн ноолуур 150-аас 160 мянган дээр арай худалдан авалт хийгдээд ард нь гарч байна.

Хоёрдугаарт урд талаас бид нар байнга мэдээ авч байгаа. Монгол Улс дэлхийн ноолуурын 50 хувийг хангаж байгаа. Мөн урд хөрш маань бас тийм хувьтай байгаа. Цагаа нэмж аваадахъя.

**Ц.Даваасүрэн:** Энхбаяр сайдын микрофоныг 1 минутаар сунгая.

**Ж.Энхбаяр:** Урд талд мөн ноолуур гараад ноолуурын үнэ тодорхойгүй байдалд болоод олон үйлдвэрүүд хаалгаа бариад бас хүнд байгаа. Яагаад гэвэл урд хөрш маань өөрөө яг худалдааны дайны гол тарифын зөрчилдөөнд орчихсон. Тодорхойгүй байдал тэнд үүсчихсэн. Тэгэхээр бид энэ бодлогоо өөрчилчихөөр ноолуур өсөөд хуучин болно гэж ийм гэнэнгээр бодож болохгүй шүү. Харин үндэсний үйлдвэр энийг чадавхжуулаад баталгаажуулаад урагшилмаар байна.

Евроазийн эдийн засгийн хэлэлцээртэй холбоотойгоор сайн тал ч бий, муу тал ч бий. Сайн тал нь бид 200 сая хүн амтай томоохон зах зээлд, хойд сэрүүн бүсийн зах зээлд манай уламжлалт мал аж ахуйн гаралтай түүхий эд, хөнгөн хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүн экспортлох орон зай эрс нэмэгдэнэ.

Нөгөө талаар эдгээр орнууд маань хөдөө аж ахуйн хөгжил сайтай орнууд. Өргөн хэрэглээний бараа хүнс дээр нэлээн хангалт хэрэглээний түвшин нэлээн нэмэгдэнэ, хямдарна. Бид харин дотооддоо хийж чадаж байгаа Хүнсний хувьсгал бодлогын хүрээнд хийсэн гол нэрийн 19 нэр төрлийн бараагаа хамгаалах шаардлага байгаа. Тэгээд энэ хамгаалалтын бодлого.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Булгантуяа гишүүн. Тодруулах юм уу? Тодруулъя Цогтбаатар гишүүн.

**Да.Цогтбаатар:** Гол нь одоо малчдад ноолуур үнэгүй байна гэдэг ойлголт байна. Одоо малчдад ноолуур худалдах гэхээр худалдаж авахгүй байгааг та өөрөө сая газар дээр нь Архангайд очихдоо харсан. Харсан. Тэгэхээр малчдад мөнгө очиж байгаа бол бид нар энд цэц булаалдаж гоё ийм онолын ч юм уу, танин мэдэхүйн шинж чанартай асуудлууд ярихгүй. Тэгснээ нөгөө тарифын нөлөөнөөс болоод урд Хятадад ноолуурын аж ахуйн нэгжүүд бол тодорхойгүй үйлдвэрлэлээ зогсоогоод байна гэж яриад байгаа юм. Бид нар ноолуурын зах зээл дээр дэлхийд 50 хувийн тоглогч гэж яриад байгаа юм. Тэгээд байхад яагаад ноолуур тэгвэл яагаад Монголд унаад байгаа юм? Эцсийн байдлаар ноолуур чинь унаад байна. Тэгээд энэ ноолуур жишээлэхэд энэ жил үнэд хүрч чадахгүйгээр малчдад гар дээр нь мөнгө очиж чадахгүй бол та хариуцлага хүлээх үү?

**Ц.Даваасүрэн:** Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Нэгдүгээрт, Засгийн газар Улсын Их Хурлын баталсан төсвийн хүрээнд Улсын Их Хурлын баталсан бодлогыг хэрэгжүүлж байгаа. Цагаан алт хөтөлбөрийн гол зорилго мал аж ахуйн гаралтай түүхий эд, арьс шир, ноос ноолуурынхаа үйлдвэрлэлийн түвшнийг нэмэгдүүл гэдэг даалгавар та бүгд өгсөн. Тэр хүрээнд бид нар ноолуурынхаа боловсруулалтын түвшнийг сайжруулах ажил хийгдэж байна. Энэ ажил хийснээр ноолуурын үнийн уналтыг бид нар харьцангуй бага давж байна. Түрүүн хэллээ Зүүн 3 аймгийн ноолуур 90 хувьтай 150-аас 160 мянгаар борлоод дуусаж байна. Одоо Төвийн бүс эхэлж байна. Хангайн болон Баруун бүсийн ноолуур болоогүй. Ноолуур дээр үндэсний үйлдвэрүүд холбогдох хөнгөлөлттэй зээлээ аваад худалдан авалтаа хийж байна. Энд ярих биш Эмээлт ороод харах хэрэгтэй. Өнөөдөр аймаг аймаг, бүс, бүс малын чанар, ширхэг

микронтой холбоотойгоор өөр өөр үнэтэй байгаа юм. 120-оос 160 мянга дээр үнэ хэлбэлзэж байна.

**Ц.Даваасүрэн:** Энэ чинь нөгөө угаасан ноолуурыг хорих нь уу, үгүй юү гээд л тэгээд л Хөвсгөл энэ тэрд авч эхлээгүй л байна лээ.

Гантөмөр сайд нэмэх юм уу? Нэмэхгүй. Булгантуяа гишүүн асуултаа асууя.

**Х.Булгантуяа:** Бид нар гадаад худалдааг хумих гэсэн зүйл огт яриагүй байх. Зүгээр экспорт хийхэд манай аж ахуйн нэгжүүд өөрснөө бэлэн юм уу? Хавар болгон л миний мэдэж байгаагаар ноолуурыг ямар байдлаар гаргах вэ гэдгийг баахан ярьдаг Засгийн газрын хурал дээр ч, Улсын Их Хурал дээр ч гэсэндээ. Тэгээд л арьс ширний асуудал байнга яригддаг. Тийм үйлдвэрүүд нь өнөөдөр экспортын хэмжээнд гартлаа бэлэн юм уу, үгүй юм уу? Энэ баахан юмыг импортоос чөлөөлнө сайн байгаа гэж яриад байна. Яг үнэнийг хэлэхэд бидэнд ясны шөлний импорт хэрэггүй. Гоймонгийн импорт хэрэггүй. Нэхий, хүрэм үгүй сая та эдгээрийг импортуудын гэж ярьсан шүү дээ.

Дээрээс нь нэмээд өмнөх өмнөх энэ юунуудаа та хараад үзээрэй. Байгуулсан гэрээнүүдээ. Бид нар 2016 онд Японтой эдийн засаг хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. 5700 орчим бараа, бүтээгдэхүүнийг тийшээ нийлүүлнэ гэсэн. Ингээд нийтдээ манай нийт экспортын Японтой хийж байгаа экспорт 0.12 хувь л байна. 0.12 хувь эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээтэй улс шүү дээ.

Тэгээд эсрэгээрээ манайх л дандаа юм импортолдог, маш их алдагдалтай. Бид нар тэднийд юугаа ч зарж чаддаггүй. Манайх баахан юм импортлоод, баахан хуучин машин л голцуу импортолж байх шиг байна. 70 хувь нь Японоос оруулж ирж байгаа бараа, бүтээгдэхүүний 70 хувь нь хуучин машин импортолж байна. Энэ Японы буруу биш байхгүй юу. Бид нар өөрснөө Японы зах зээл дээр гартал бараа, бүтээгдэхүүнүүдээ үйлдвэрлэгчдээ бид нар бэлдэж чадаагүй. Ингээд нийтдээ сүүлийн 10 жилийн хоёр улсын гадаад худалдааны аваад үзэхэд манай нийт экспорт, 1 жилийн экспорт Японоос бид нар авч байгаа бараа, бүтээгдэхүүний 10 жилийн экспорт 1 жилтэй ч тэнцэхгүй байна. Тэгэхээр бид нар манай байгаа царай одоогоор үйлдвэрлэлийн чадал ийм л байна.

Европын холбоотой 7200 бараа, бүтээгдэхүүнийг бас л хөнгөлөлттэй, чөлөөлөлттэй гаргана гэсэн. Гаргаж байгаа юм бараг юу ч байхгүй. Та бүхэн 2024 оны статистикийн экспортын тоо баримтыг аваад үзээрэй. Манайх Швейцар руу Монголбанк алтаа гаргадаг. Өөр Европын Холбоо руу бараг гаргаж байгаа юм байдаггүй.

Тэгэхээр ийм байгаа цагт өмнөх та бүхэн маань энэ олон улсын гэрээ, хэлэлцээрүүдээ аваад үзээрэй. Бид нарын байж байгаа царай ийм байхад ахиад ерөөсөө чөлөөтэй худалдана, үүд хаалгаа нээнэ л гээд байх юм. Яах вэ олон улсын эдийн засгийн зарчим, худалдааны зарчим ийм. Экспорт нь маш сайн нэмэгдэж байгаа бол импорт хамаагүй оруулчхаж болдог. Яагаад гэвэл тэртээ тэргүй тэрийг аваад л өөрөө бүх юмаа үйлдвэрлэдэг улс гэж байдаггүй учраас аваад л нэмүү өртөг шингээгээд л гаргаад л байвал болж байна.

Гэтэл бид нар үйлдвэрлэж чадахгүй өмнөх эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээнүүд маань ийм байхад ахиад бүүр том үйлдвэрлэгч улсуудтай

бид нар гэрээ байгуулна гээд байх юм. Ямар улсууд байгуулдаг вэ гэхээр Хятад хүртэл энэ олон улсын том гэрээнүүд орохдоо маш их болгоомжилж байгаад, дотоодынхоо хүчин чадлуудыг нэмэгдүүлж байгаад тэгээд дэмжлэг үзүүлж үзүүлж байгаад экспортынхоо том том гэрээнүүдийг, энэ худалдааныхаа том том гэрээнүүдийг хийдэг. Манай улсын хувьд бид нарт ийм үйлдвэрлэлийн хүчин чадлууд үнэхээр хүнд харагдаж байна.

**Ц.Даваасүрэн:** 6 номер хариулъя. Гантөмөр сайд.

**Л.Гантөмөр:** Булгантуяа дарга өнөөдөр эсрэг байр суурьтай байгаа нь бол өөрөө улс төр байна л гэж би харж байна. Тийм учраас бол та бүхэн хаалттайгаар асуудлаа яриад шийдвэрээ гаргах хэрэгтэй байна. Яагаад би Булгантуяа гишүүнийг өнөөдөр ингэж байр сууриа 180 градус эргэж байгааг улс төр гэж харахаас өөр арга алга л даа. Засгийн газрын гишүүн байхад тань энэ асуудал эхэлсэн тийм ээ. Тэгээд тэр үед та дэмжсэн байр суурьтай л байсан байх.

Тийм учраас бол та бүхэн, би бол төрийн бодлогын залгамж халааг нэр төртэй авч явахыг л хүсэж байгаа юм. Түүнээс биш өөр сайд эхлүүлчихсэн юм байна лээ би больё гэж би гоншигнохгүй байгаа. Ард нь гаръя л гэж хичээж байгаа юм. Тийм учраас бол та бүхэн улс төржихөөс илүүтэйгээр дотооддоо асуудлаа яриад шийдсэн нь зөв байх.

**Ц.Даваасүрэн:** Булгантуяа гишүүн тодруулъя.

**Х.Булгантуяа:** Гантөмөр сайд та өөрөө энэ асуудалд ингээд аягүй субъектив хандаад байх юм хувь хүний гээд юм юугаар. Бид нар зарчмын асуудлууд яриад байгаа юм. Би уг нь манай Монголын хамгийн олон зах худалдааны төвүүд байдаг Баянзүрх гэдэг дүүргээс сонгогдсон юм. Эдийн засаг, хөгжлийн сайдад аягүй өчүүхэн асуудал байгаа юм. Тэнд жижиг, дунд аягүй олон бизнес эрхлэгчид байдаг юм. Тэр хүмүүс маань жоохон юм үйлдвэрлээд зарим нь Нарантуул дээр, зарим нь Да хүрээ дээр гээд энэ зах худалдааны төвүүдээр зардаг юм. Тэгээд эдгээр хүмүүсийн хувьд ингээд л гаднаас юм орж ирээд л бид нар хэзээ ч юугаа ч зарж чадахгүй ийм асуудалд хүрэх вий гэж айж байгаа юм.

Гэрээ, хэлэлцээр яриа эхлээч гэдэг энэ асуудал ярина. Гэрээ хэлэлцээр байгуулна гэдэг хоёр аягүй өөр асуудал шүү дээ. Өөр асуудал шүү дээ. Дээрээс нь нэмээд та бүхэн энэ дэлхийн эдийн засгийнхаа нөхцөл байдлыг хараад үз дээ ямар байдалд байна?

Дээрээс нь нэмээд манай Монголын аж ахуйн нэгжүүд гол нь бид нар ийм асуулт асуухаар та нар өөрсдөө ерөөсөө тодорхой хариул.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Пүрэвдаваа гишүүн татсан. Батбаяр гишүүн асуулт асууя.

**Д.Батбаяр:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би 1 саяхан тойргоороо яваад тойргийнхоо аж ахуй эрхлэгч хүнтэй уулзсан. Тэгээд яг энэ Евразийн эдийн засгийн хэлэлцээрийн талаар ярьж таарсан. За та юу гэж бодож байна гэсэн би 100 сая байдаг юм уу, 200 сая байдаг юм уу ийм хүнтэй зах зээл дээр би 1 долларын 1 юм хийчих юм бол би дороо саятан болно гэж ярьж л байна. Яах вэ энэнээс ингээд юу гэж харагдаж байна гэхээр энэ бас их том боломж гараад байгаа юм болов уу гэж бодоод байгаа байхгүй юу. 3 сая хүнтэй зах зээл дээр ажиллаж байгаа хажуу талд нь хэд байдаг юм 200 орчим сая хүнтэй зах зээл

онгойх гээд байна гэж би харж байна. Боломж гэж хараад байна л даа. Ялангуяа юм хийж чадах, чаддаг хүнд бол би боломж гарах юм болов уу гэж бодоод байгаа юм.

Гэхдээ нөгөө талд нь бас хамгаалалт хэрэгтэй юм байна. Сая хэлж байна 23 нэр төрлийн бараа Монголчуудыг Монгол Улсын үйлдвэрлэдэг бараан дээр нь тодорхой хэмжээгээр дэмжлэгтэй байя, хамгаалалттай байя, тарифын хамгаалалттай байя гэж ярьж байна. Энэ бас зөв байх. Яагаад ч яаж ямар ч тохиолдолд үндэснийх хөдөө аж ахуй үйлдвэрлэлийг дэмжих нь номер 1 зорилго. Бид нар жоомоо алах гээд гэрээ шатаачхаж болохгүй. Тэгээд энэ хэлэлцээр минь өөрөө зөв юм уу, буруу юм уу гэдгийг бас турших хугацаа байх ёстой гэж бодож байна. Тэр ч утгаараа 3 жилийн хугацаа гэдэг бас би зөв юм болов уу гэж хараад байгаа байхгүй юу.

Тэгээд надад ийм хэдэн асуулт байна нэгдүгээрт нь энэ гэрээнд хамрагдаж байгаа энэ зах зээл маань өөрөө хэдэн хүнтэй зах зээл вэ гэдэг асуулт байна нэгдүгээрт? Хэдэн хүнтэй зах зээл дээр бид нар орох гэж оролдож байгаа вэ?

Хоёрдугаарт нь энэ орнуудаас би оноо авч байгаа гол нэрийн бүтээгдэхүүн бол нефтийн гаралтай бүтээгдэхүүн байгаа, шатахуун байгаа, манай гол түүхий эд. Тэгэхээр энэ зах зээлийн түүхий эд шүү дээ үйлдвэрлэлийн. Тэгэхээр энэ нефтийн гаралтай бүтээгдэхүүн энэ хэлэлцээрт түр хэлэлцээрт хийснээр хэдэн хувиар хямдрах вэ шатахуун гэсэн ийм тоо байна уу гэдэг ийм хоёр дахь асуулт байна.

Гуравдугаарт нь бид нар реэкспорт хийх боломж гарах уу? Одоо энэ Сибирь тэр чигээрээ мод байгаа. Бид нар модоо оруулж ирээд боловсруулаад гаргах ийм боломж гарах уу? Энэ дээр ямар нэгэн бодлого байна уу? Реэкспорт хийх боломж ахиж нэмэгдэх үү гэсэн ийм асуулт байна.

Дөрөвдүгээрт нь үйлчилгээнүүд, тэр дундаа энэ төмөр замын тээвэрлэлт гэдэг энэ зүйл бас хямдрах уу? Бид нар экспорт хийлээ гэж бодъё сайхнаар бодоод экспорт хийгээд Беларусь руу гаргалаа гэж бодъё, Европ руу гаргалаа гэж бодъё. Тэгвэл энэ төмөр замын тээвэр маань өөрөө хямдрах уу гэсэн ийм асуулт байна.

Тав дахь асуулт нь юу вэ гэхээр энэ бизнес Монголын бизнес эрхлэгчидтэй холбоотой тэгэхээр энэ дөнгөж хөл дээрээ босоод явж байгаа энэ бизнес эрхлэгчдийгээ дэмжих тарифын бус ямар дэмжлэг хөтөлбөр байж болох вэ? Энэ дээр бодож санасан зүйл байна уу гэсэн ийм асуултуудад хариулт авъя.

**Ц.Даваасүрэн:** Гантөмөр сайд хариулъя 6 номер.

**Л.Гантөмөр:** Тийм 92 бензин өнөөдөр татваргүй байгаа. Тийм учраас бол 92 дээр ямар нэгэн хэмжээгээр үнийн өөрчлөлт гарахгүй байх. Бусад нөгөө түлш дээр нь бол 5 хувь хямдрах бололцоо байна. Тэгэхдээ нөгөө талдаа рублийн ханш ямар байх вэ гэдгээс бас их хамаарна шүү дээ. Тийм учраас бол энэ дээр бид нар шулуухан тэд буурна гэж хэлэхэд бол эрт байгаа.

Зах зээл бол мэдээж 200 сая хүнтэй зах зээл. Яг өнөөдөр бид нарын зарж чаддаг барааг 16 тэрбум долларт тэр улсууд гаднаас авч байна, гаднаас авч байна. Тэгэхээр бид нар 16 тэрбум доллар гаднаас бараа авч байгаа улс руу л тэр

зах зээл рүү л бараа, бүтээгдэхүүнээ гаргахыг оролдож байгаа юм. Ер нь манай үйлдвэрлэл эрхлэгчид яг бодитойгоор айгаад байгаа юм бол байхгүй байгаа шүү. Мэдээж хэрэг бид нар сүүгээ дотооддоо үйлдвэрлэнэ хамгаалчихсан. Сүү бид нар тарифаа өөрийнхөөрөө тавина гэх мэтчилэн өөрийнхөө хийж чадаж байгаа бараануудаа бид нар бүрэн хамгаалалтдаа авчихсан байгаа.

Нөгөө талдаа зарим нэг үйлдвэрлэлийнхээ түүхий эдийн үнийг бууруулах ийм хэлэлцээр явж байгаа гэдгийг бүгдээрээ ойлгох хэрэгтэй. Зарим нэг орж ирэх бараа бол түүхий эдийн түвшинд манай үйлдвэрлэлийн гол түүхий эдийн түвшинд орж ирэх юм гэдэг ийм зүйл байгаа.

Өөр юу билээ? Ер нь тэнхимийн Ерөнхийлөгчийн үгийг сонсох нь зөв байх. Түрүүн бас Булгантуяа дарга асуугаад байсан тэр манай энэ аж ахуй эрхлэгч нар чинь ер нь бэлэн юм уу гэдэг зүйлийг асуугаад байсан. Ер нь зүгээр хойноос орж ирж байгаа барааны өнөөдрийн бараа, бүтээгдэхүүний төрөл мянга хэдэн зуу шүү. Энэнээс манайх экспортлох боломжтой 375 дээрээ хэлэлцээр хийсэн юм байна лээ шүү. Тэрнээс дахиад манайх хамгаалалт хүсээд дахиад 8-ыг хасчихсан. Тэгэхээр бид нар бол нийт бараанаас 367-г сонгож байгаа. Японы хэлэлцээрээр бол Япон талаас 5700 манайх Япон руу 9000 байхгүй юу. Тэгэхээр энэ 9000, 5700 энэ тэртэй харьцуулахад бид нар маш цомхон компакт ийм гэрээ хийж байгаа. Тэгээд түр 3 жилийн хугацаатай. Тэгээд үнэхээр бэлэн биш байх юм бол бид нар энэ гэрээ ингээд хаагдчихна. Сунгахгүй.

Болж байна, бид мах зарж болж байна, хивсээ зарж болж байна, ноолуураа зарж болж байна, ноолууран цамц маань энэ хүмүүс авч чадаж байна гэдэг юм гараад эхлэх юм бол бид цаашаагаа үргэлжлүүлээд энэ цөөхөн тооны бараан дээрээ тохироогоо хийгээд явах ёстой л гэдэг ийм байр суурь.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Дамдинням гишүүн. Тодруулах юм уу? Тодруулъя.

**Д.Батбаяр:** Энэ нөгөө реэкспорт хийх боломж яаж нэмэгдэх вэ гэдэг асуулт хэлсэн.

Хоёрдугаарт нь,

**Ц.Даваасүрэн:** Мод асуугаад байсан шүү дээ.

**Д.Батбаяр:** Тийм мод асуусан шүү дээ. Бид нар Сибириэс мод оруулж ирээд боловсруулаад гарах боломж үүсэх үү гэдэг асуулт хэлсэн.

Хоёрдугаарт нь энэ бизнесийн байгууллагуудыг дэмжих хөтөлбөр, тарифын бус дэмжлэг ямархуу байх вэ гэдэг.

**Ц.Даваасүрэн:** 6 номер хариулъя.

**Л.Гантөмөр:** Тийм одоо бид нар энэ худалдааны дайны үед энэ худалдааны дайны цаг үеийг хэрхэн давж туулах вэ гээд Засгийн газар дээр тал талаас нь ярьж байна. Энэ дотор хамгийн чухал нь бол энэ дотоодын хүнсийг хангаж байгаа, дотоодын үйлдвэрлэл эрхэлж байгаа, дээр нь технологи шингэсэн үйлдвэрлэл эрхэлж байгаа, мөн экспорт хийж байгаа компаниуд руу Засгийн газар хөрөнгө оруулалт хийж болдог тэр эрх зүйн орчныг бид нар хэрхэн хийх вэ гэдэг энэ зүйлийг ярьж байгаа юм. Нэг үгээр хэлбэл Засгийн газар хөрөнгө оруулалт хийгээд аж ахуйн нэгжээ дэмжээд явдаг нэг ийм зүйл байна.

Нөгөөдөх нь бол яг хүнс дээр бол нэмүү өр НӨАТ-аа дотоодын үйлдвэрлэлийн хүнс дээрээ бид нар бууруулах боломж байна.

Гуравдугаарт дотоодод үйлдвэрлэхдээ бид нар гаднын материалаар үйлдвэрлээд экспорт хийх боломж энэ гэрээгээр орж ирж байгаа. Юу вэ гэвэл 100 хувь Монгол Улсын гаралтай бүтээгдэхүүн байна гэдэг зүйл байхгүй. 50:50. Нэг үгээр хэл.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Дамдинням гишүүн асууя.

**Г.Дамдинням:** Тэгээд л энэ их л улс төртэй л сэдэв шүү дээ. Өмнө нь нуугдаж үсэрч орж ирээд бөөн улс төр болоод буцсан. Тэгж байж дахиж хэлэлцээр нь хийгдэж байж арай өөр жагсаалт орж ирж байгаа юм шиг байна. Тэр өмнөх орж ирсэн жагсаалт дээр нь манай МУИС болон энэ эдийн засгийн судлаачид бүгдээрээ тооцоо хийгээд 6 хувиар эдийн засаг агших юм байна энэ бол их бид нарт ашиггүй байна гэсэн дүгнэлтийг гаргасан. Яах вэ парламент байгаад тэгээд нийт ард иргэд оролцогч талууд нээлттэй ил яриад явж байгаагийн давуу тал нь энэ байхгүй юу.

Тэгээд одоо болохоор Их Хурлын гишүүдийг орж ирээд өмнө нь та нар парламент байсан хүмүүс дуугүй байгаарай яах гээд байгаа юм бэ ч гэдэг юм уу ийм өөрөө улс төржсөн асуудал ярьчихаад тэгээд улс төржиж байна гээд байж бас болохгүй. Авч гарах сонирхол байгаа ч юм уу, үгүй ч юм уу мэдэхгүй энэ Эдийн засгийн сайдад энд гэрээгээ. Зүгээр гол ажлаа л яримаар байгаа байхгүй юу. Шинээр тохирсон гэрээнийхээ нөхцөлүүдийг судлаач дээр судлуулсан юм уу? Би бол гишүүдтэй санал нэг байна. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулиар судалгаа шинжилгээний байгууллагууд Эдийн засгийн хөгжлийн яаманд оччихсон. Бүх судалгааны институт таны доор байгаа. Тэр газар байдаг хүмүүс бол эсрэг санал өгөөд байгаа энэ Монгол Улсад ашиггүй гээд.

Хоёрдугаарт би бас тойргоороо явлаа, барилгын бизнесийнхэнтэй уулзлаа. Манайх чинь хөдөө аж ахуйн тойрог Сэлэнгэ, Дархан, Төв тариаланчидтайгаа уулзлаа дэмжихгүй байна. Бид нар алуулна шүү дээ л гэж байна лээ. Яг энгийн үгээр бол бид нар дийлэхгүй. Тэгээд яах юм байгаа юм мэдэхгүй та нар л шийднэ шүү дээ л гэдэг юм хэлж байна лээ. Тэгээд 2, 3 асуулт байна.

Нэгдүгээрт, Эдийн засгийн хөгжлийн яамнаас та нар энэ Европын холбоотой байгуулсан 7200 орчим нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн, Японтой байгуулсан 5700 нэр төрлийн бүтээгдэхүүний чөлөөт худалдааны хэлэлцээр дээр дүгнэлт хийгээд Их Хуралд танилцуулж болох уу? Дүгнэлт хийгээд. Энэ чөлөөт худалдааны хэлэлцээр ер нь болоод байгаа юм уу, үгүй юм уу, бид нар үйлдвэрлэдэггүй улс учраас ашигтай юу, үгүй юү гэдгийг харуулаад өгөөч.

Хоёрдугаарт, энэ судлаачид дээрээ, олон нийтийн байгууллагуудаараа ингээд дахиад хэлэлцүүлээд наадхаа харуулчихаж болохгүй юу? Тэгэхгүй тэгээд л эцсийн бид нарын тохирсон юмыг тэр судлаачид нь хараагүй юм, Их Хурлын гишүүд хараагүй төөрөөд байгаа юм гээд ингээд гүрийгээд байж болохгүй байхгүй юу. Ярья л даа, харъя л даа. Үнэхээр ашигтай юм бол яарч сандраад бушуу туулай борвиндоо баастай гэдэг шиг шижир давхиад байх хэрэггүй л байхгүй юу даа. Тэгэхээр нийтээрээ дахиад хэлэлцээд яриад харчихмаар байгаа байхгүй юу. Одоогийн байдлаар бол наадхыг чинь дэмжих ямар ч боломжгүй байна шүү.

**Ц.Даваасүрэн:** Гантөмөр сайд хариулъя 6.

**Л.Гантөмөр:** Тийм. Тэгэхээр олон нийтийн хэлэлцүүлэг хийгээд асуудлаа шийдэх нь зөв. Зүгээр худлаа мэдээлэл тараагаад тэрэнд нь хүмүүс ороогдоод байгаа нь бас үнэн. Жишээлбэл Дархан, Эрдэнэт, Дархан, Сэлэнгэд байгаа газар тариалан эрхэлж байгаа хүмүүст бол энэ ерөөсөө нөлөөлөхгүй энэ хэлэлцээр. Тэр хүмүүсийн үйлдвэрлэж байгаа бараа, бүтээгдэхүүн яг хуучин хамгаалалтаараа үлдэж байгаа, үлдэж байгаа.

Харин гурилынхаа татварыг буцаад сэргээмээр байгаа юм. Гурилынхаа татвар тавихгүй тохиолдолд улаан буудай тарихгүй байна, бага тарьж байна, тарилт ер нь буурах юм байна лээ, гурилын үйлдвэрүүд дампуурах юм байна лээ. Тийм учраас бол гурилан дээрээ Оросоос авч байгаа гурилан дээрээ татвараа тавих хэрэгтэй. Тэгэхээр энэ гурилын татвар бол жишээ нь энэ хэлэлцээрт ороогүй байгаа шүү.

Судалгаа шинжилгээ хийлгэе. Нэг айхтар яарч тэвдээд байгаа юм алга. Айхтар одоо шийдэж өг өө та нар гээд ингээд хүч түрээд байгаа ч юм алга. Тал талаасаа ярья, асуудлаа өргөн дэлгэр харъя. Гол нь зүгээр зах зээлээ олж авахгүйгээр бид нар урагшаа тэмүүлээд явахгүй л дээ. Эдийн засаг солонгорох ойлголт ерөөсөө байхгүй.

Японы тухайд бол үнэхээр Японд очиж бараа, бүтээгдэхүүнээ нийлүүлээд тэр зах зээл дээр өрсөлдөхөд Монголын үйлдвэрлэгчид хүнд байгаа, хүнд байгаа. Би яарч тэвдээгүй гэж байгаа болохоос чамайг буцаагаад өгөөч гэж хэлээгүй шүү. Та бүхэн дэмжиж өгөх хэрэгтэй. Яарч тэвдэх юм алга. Завсарлага аваад, ярилцаад, олон талаасаа мэдээллээ нэгтгээд ингээд шийдвэр гаргаад явах нь зөв байх.

**Ц.Даваасүрэн:** Тодруулъя Дамдинням гишүүн.

**Г.Дамдинням:** Тэр намынхаа байран дээр очиж загнаарай Гантөмөр даргаа. Би Монгол Улсын Их Хурлын гишүүн, ард түмний төлөөлөл Засгийн газрын гишүүнтэй яриад сууж байгаа шүү энд. Аятайхан ингээд ажил ярьчих гэхээр бас даналзаад байх хэрэггүй шүү. Би бол Даваасүрэн дарга юу яачихвал яасан юм Засгийн газрыг төлөөлөөд орж ирж байгаа энэ Тэргүүн Шадар сайд нь өө яараад байгаа юм алга гэж байгаа бол тэгээд санал гаргаад буцаачихвал яадаг юм. Судалгаа шинжилгээний байгууллагуудаар дахиад оруулъя, олон нийтийн хэлэлцүүлгийг дахиж хий гээд буцаах санал гаргаж байна шүү дээ. Би тийм горимын санал гаргаж байна. Тийм.

**Ц.Даваасүрэн:** Хариулах уу нэмж? 8 номер. Ер нь дахиад хар 300 гаруй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг компаниудыг бид нар энд авчирч чадахгүй. Компанийн төлөөллийг энд суулгана гэж байхгүй. Тийм учраас төлөөлж байгаа энэ танхимыг нь сонсохоос өөр арга байхгүй шүү дээ. 8-ыг нь ахиад сонсчихъё. Тэгээд дараа нь Энхбаяр сайд. Битгий ганц.

**Л.Төр-Од:** Эрхэм гишүүдэд маш товчхон би бас энэ ажлын хэсэгт 30 жил гаруй яг энэ экспорт импортыг хариуцсан, ажиллаж байсан бас мэргэжлийн эксперт Адьяасүрэн гээд энэ манай ялангуяа үндэсний үйлдвэрлэгч экспортод хүлээн зөвшөөрөгдсөн ийм бас мэргэжилтэн экспертийг бас авчирчихсан байгаа.

Гуравхан зүйлтэй. Нэгдүгээрт судалгаан дээр бол эрхэм гишүүдтэй яг санал нэг байгаа. Тийм учраас би МУИС-ийн Бизнесийн сургууль, Эдийн засгийн сургууль, Монголбанкны судалгааны хүрээлэн эд нартай бусад бас эрдэм шинжилгээ ялангуяа энэ гадаад худалдаа чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг байгууллагуудтай хамтарч ажиллаж нэгдсэн юу гэдэг юм тинк танк, судалгаа, шинжилгээ хийдэг ийм бүтэц бий болгохоор бол ажиллаж байна.

Хоёрдугаарт реэкспорт дээр энийг бас танхим бүрэн дэмжиж байгаа. Тэгээд урьдчилсан байдлаар сая зөвхөн нөгөө Оросын холбооны.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Энхбаяр сайд товчхон хариулах юм уу? Хөдөө аж ахуйн салбарт нөлөөлж байна уу?

**Ж.Энхбаяр:** Төсвийн байнгын хороо Монгол Улсын төсөвт эерэг, сөрөг ямар нөлөө үзүүлэх талаасаа гол төвлөрч яривал зүйтэй байх гэж бодож байна. Манай уламжлалт аж үйлдвэрлэлийн салбарын гол зах зээл байсан сэрүүн бүсийн орнууд түүний 200 сая худалдан авагч энэ гэрээгээр бид нар гарах бололцоо байгаа. Энийг сайн бүгдээрээ боломж болгож ашиглаж чадвал манай хөнгөн үйлдвэрийн салбарт арьс шир, ноос, ноолуур гол энэ Цагаан алт бодлогын хүрээнд дэмжиж байгаа салбарт маш сайн дэмжлэг болно. Хүнсний гол гол хийж байгаа зорилтод мэдээж сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Гэхдээ Төсвийн байнгын хороо дотоод тарифын бус арга хэмжээнүүд энэ үйлдвэрүүдээ хөнгөлөлттэй зээл НӨАТ, орлогын албан татварын тодорхой хэмжээний бууралтуудыг энэ дагасан хуулийн өөрчлөлтөөр хийгээд өгчихвөл дотоодын үйлдвэрүүдээ бид нар өнөөдрийн хүрсэн амжилтаа хамгаалаад гарчихна. Энэ 2-ыг л зэрэг авч яв.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Аубакир гишүүн асууя.

**Т.Аубакир:** Баярлалаа. Тэгээд манайд яг хэд хэр хожоотой гэрээ юм бэ дээ Гантөмөр сайдаа? Энэ хэдэн гишүүд чинь тэрийг л тойроод асуугаад яваад байгаа шүү дээ. Зөвхөн гишүүд биш энэ дөнгөж хөл дээрээ босож ирж байгаа үйлдвэр байгуулсан үйлдвэрлэгчид одоо л нэг жоохон нар үзэх нь үү дээ гэж байтал энэ том хэлэлцээр рүү аваачаад оруулчихдаг. Бид нар тэр том улсуудтай өрсөлдөх хэмжээний потенциалтай ийм үйлдвэрлэгчид биш шүү дээ. Хэр хожоотой гэрээ юм тэрийг л та хэлээд өгчих.

Бусад энд нэгдчихсэн явж байгаа 5 орон. Оросоос бусад нөгөө 4 орон маань энэ гэрээ, хэлэлцээрт нэгдээд бид нар ийм ашигтай байгаа юм гэдгийг та нарт зөвлөөд байгаа юм уу? Сая манай юуны Ерөнхийлөгч билээ Үйлдвэр худалдаа юу билээ дээ би эксперт юм л гээд. Тэгээд бусад энэ нэгдээд энэ чинь 14 оноос хойш нэгдээд явж байгаа улсууд эхлээд Таможенный союз гэж байсан, дараа нь энэ яст нэгдээд манай улсууд ингээд хожоод байна гэж байгаа юм. Армен, Беларус энэ тэртэй харьцуулахад манай улс төдий хэмжээний бас том үйлдвэрлэгч бас биш. Одоо л дөнгөж хөл дээрээ босож байгаа энэ талх, нарийн боов, элдэв бусад үйлдвэрлэгч нар маань. Энэ выставка болж байсан юм. Тэгэхэд би яг өөрөө тэр үзэсгэлэнг үзээд явж байсан Казахстаны Хубилай гээд нэртэй консерв үйлдвэрлэдэг үйлдвэрийнхэн тэнд бүтиктэй байж байхад нь байж байгаад Хубилай гээд нэртэй консерв байдаг юм уу танай ажил сайн юу энэ тэр гэсэн ямар юм сайн байх вэ дээ бид нар энэ дот одоо энэ консервыг 100 төгрөгөөр үйлдвэрлэж байгаа

юм. Оросоос 80 рублиэр оруулж ирж зараад байгаа юм бид нарт ямар юм сайн байх вэ дээ энэ хэлэлцээр гэж байсан. Яг иймэрхүү судалгаануудаа та бүхэн маань сая Дамдинням гишүүн тэр хэлээд байна. Энэ үйлдвэрлэгч энэ тэртэйгээ ер нь том хэмжээний хэлэлцүүлэг энэ тэр өрнүүлсэн юм уу? Мэдээж хэрэг гурил, будаа энэ тэр нь бол алдаатай байсан нь сая харагдлаа. Яах вэ 50 мянган тонн улаан буудай гээд л оруулчихсан л явж байна. Тэр 50 мянган тонн улаан буудай чинь л үндсэндээ энэ энэ Монголын тариаланчдын улаан үнийг тодорхойлчихдог л юм л даа.

Тийм учраас судалгаа юмнуудаа хийгээд яах вэ 5 сарын 9-нд бас үйл явдал болох гэж байгаа юм байна. Тэрийг ойлгож байна. Энэ ард түмний төлөөлөл энэ Их Хурал чинь өөрөө бүрэн эрхийнхээ хүрээнд энэ асуудлыг хүлээж авах боломжгүй, одоохондоо дэмжих боломжгүй юм байна гэж үзээд байгаа юм биш үү Гантөмөр даргаа? Таныг ажил хийх гээд байгааг ойлгож байна. Би ажил хийж байгаа нь энэ гээд өмнөх засаг үргэлжлүүлж байсан ажлыг би үргэлжлүүлэх ёстой юм гээд муйхраар дайраад энэ хэдэн үйлдвэрлэгчдээ хамраар нь газар шаалгах гээд байгаа юм уу даа. Таныг ингээд буруутгаад байгаа юм ерөөсөө байхгүй. Энэ гэрээ, хэлэлцээр Монгол Улсад хожоотой юм уу л гэдгийг л асуугаад байгаа юм. Бид нар ингэж ингэж хожих юм гээд та тодорхой хэл. Бид нар 10 жилийн дараа гэхэд энэ үйлдвэрлэгч нар маань том зах зээлд гараад сэв хийтэл ингээд босоод ирэх юм гэдгийг та хэлээд өгөөч. Энд нэг нэгийгээ чичлэх гээд та ч ухаантай царайлаад л бусад нь ч ухаантай царайлаад байгаа ч юм шиг энэнд мэтгэлцээд байх юм. Энэ чинь зүгээр гүйгээд орчихдог хэлэлцээр бас биш байх. Бусад энэ хэлэлцээрт нэгдчихсэн явж байгаа олон жил болсон улсууд чинь үнэхээр хожоотой гэрээ бай.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Хариулъя. 6 номер тодорхой хариулт хүсэж байна.

**Л.Гантөмөр:** Тийм, ер нь бол Евразийн холбоон дотор эдийн засгаар нь харахаар хамгийн их хожиж байгаа нь Казакстан юм билээ. Бид бол Эдийн засгийн холбоонд элсэхгүй. Гишүүд минь бид түр хэлэлцээр хийж байгаа, 3 жилийн хугацаатай, магадгүй хэрэгжиж эхлэх нь бол ирэх оноос хэрэгжих байлгүй дээ. Одоогоос зурж дараа нь энэ чинь парламентаар орно, батлагдах эсэх нь яригдана. Хожоотойн хувьд хожоотой. Зүгээр хожоотой гэдэг нь бол тийм зүгээр хэлчихээр бас болдог юм биш байна л даа. Үйлдвэрлэгчид маань хэр ажилсаг байх вэ, худалдаачид маань хэр сэргэлэн байх вэ, хэр авхаалжтай байх вэ гэдгээс л шалтгаална. Японы жишээ тэр.

Тэгэхээр бол зах зээл гараад ирлээ. Монголчууд 5 хувийн татвар авдаг байсан нь тэглэгдлээ. Евроази 15-аас, 10-аас 50 хувийн татвар авдаг байсан нь тэглэгдлээ. Ер нь одоо байгаа татвараараа бол бид нар энэ Евроази руу юу ч зарахгүй. Яг ингээд байна. Юу ч зарахгүй зарж чаддаг хүн олдох ч үгүй. 40 хувийн татвартай үхрийн мах хэн ч зарж чадахгүй. Тийм учраас бол Евразийн энэ зах зээл рүү юм зарах боломжийг л гаргаж ирж байгаа. Ер нь 2 хөрш бол худалдааны хувьд манайд бүрэн хоригтой 30 жил явсан. Энэ 20-гоос гаргах тухайд аль аль нь бодож байгаа байлгүй дээ. Тэгээд 1 хөршийнхөө хоригийг авах тухай л би хэдүүлээ ярьж байгаа юм. Өөрснөө тэгье бид хоригтойгоо байя гэвэл тэр бид нарын л сонголт.

Тийм учраас бол хожоотойн хувьд хожоотой. Ямар ч байсан бид их өндөр тариф, өндөр тавьсан тарифыг өнөөдөр тэглэх тухай л ярьж байгаа юм. Энэ нь магадгүй хаа нэг газар таалагдахгүй л байх шиг байна л даа.

**Ц.Даваасүрэн:** Ингээд асуулт асууж дууслаа.

Үг хэлэх гишүүд байна уу?

Ганхуяг гишүүнээр тасаллаа. Ганзориг гишүүн үгээ хэлье.

**П.Ганзориг:** Хэдүүлээ хийе. энэ Монгол Улсын бас эдийн засагт, гадаад худалдааны тэнцэлд, дотоодын зах зээл, үндэсний үйлдвэрлэгчид гээд эд нарт бас маш чухал эерэг, сөрөг нөлөө үзүүлэх энэ чухал асуудлыг хэлэлцэж байгаа болохоор бас олон талаас нь сайн ярих нь зөв байх. Тэр тусмаа бас сая гишүүд асуулт асууж байхдаа энэ судалгаануудаа бас нарийвчилж хийе гэдэг саналууд гаргаж байна. Тэгэхээр энэ судалгаануудыг дахиж нарийвчилж ялангуяа эдийн засаг дахь, экспорт дахь нөлөөллүүдийг нь бас дахиж харах нь зөв. Тэгэхгүй өнгөрсөн парламентаар гээд тэгэхэд үндэсний үйлдвэрлэлүүд буюу 2 салбарт тухайлбал, цементийн үйлдвэр, гурилын үйлдвэрүүд хөл дээрээ босож ядаж байхад нь Их Хурлаас импортын татварыг нь тэглээд ингээд хүнд байдалд оруулсан.

Тэгэхээр иймэрхүү байдлаар төр засгийн шийдвэр бас гараад явдаг, эргээд зах зээл эдийн засагт хор хөнөөл учруулдаг, хариуцлага хүлээдэг этгээд байдаггүй. Ийм байгаа учраас энийг бас л дахиж хойшлуулж байгаад судалгаануудыг нь сонсож байгаад дахиж ярих нь зөв байх. Танхимын Ерөнхийлөгч ч гэсэн тэгж байна шүү дээ нарийвчилсан судалгаануудыг бас дахиж харах нь зүйтэй гэсэн саналтай байгаа гээд. Тэгэхээр олон талаас ийм байр суурь байгаа болохоор энийг дахиж сонсьё. ХҮН нам бас зөвлөл дээрээ энэ мэдээллүүдийг нарийвчилж авч байгаад тэгээд дараагийн Байнгын хороо болон чуулганаар орж ирэхээр нь саналуудаа өгөөд явах нь зөв байх. Эцэслээд.

**Ц.Даваасүрэн:** Батжаргал гишүүн үг хэлье. Үгүй хариулт байдаггүй 8 номер. Үг хэлье.

**Ж.Батжаргал:** Энэ түр хэлэлцээрийг хэдүүлээ их л сайн судлах л хэрэгтэй байна. Би энэ бидний түншлэл дээр жоохон цав гараад байдаг юм дутуу судалгаатай, таамаг мэдээлэлтэй улсуудтай баахан юм ярьчихдаг. Яг юм хийх болохоороо зэрэг нөгөө тооцоолол юмнуудаа нарийсгаад үзэхээр зэрэг асуудал үүсээд байдаг, энэнээсээ болоод хойшлуулаад байдаг, энэнээсээ болоод мөнхийн хөршүүдтэйгээ гэдэг юм уу, түншлэгч талуудтайгаа бас итгэлтэй түнш мөн үү, үгүй юү гэдэг юм яригдаад байдаг их зовлонтой л эд. Тийм учраас ер нь энэ дуугарах ёстой газраа дуугарах ёстой улсууд нь тов тодорхой тооцоо судалгаатай дуугардаг тэр соёл мораль руу л шилжих тухай л ойлголт байгаад байгаа юм. Би энэ талаасаа бодох ёстой болов уу гэж. Үнэхээрийн Монголын хөдөө аж ахуйн салбарын, энэ ноос, ноолуур, арьс шир, мах, махан бүтээгдэхүүн, энэ уул уурхайн зарим бүтээгдэхүүнүүдийг энэ том зах зээл рүү гаргах хүсэл байна. Үнэхээрийн бидэнд хэрэгтэй. Тэр том тарифыг тэглүүлж аваад гарах сонирхол байна.

Гэхдээ нөгөө тал бидэнд бас яг адилхан тооны бараа, бүтээгдэхүүнээ ижил тэнцвэртэй байх асуудлаа тавина. Тэрүүнийг нь хэлэхээр зэрэг хэдүүлээ ямар ямруудыгаа хамгаалж барих вэ гэдэг юмнуудаа илүү нарийсгаж, үзэж, харж одоо та хэдийн сүү хамгийн сүүлийн байдлаар тогтчихоод байгаа тэр 376 бараа, бүтээгдэхүүнүүд дээр нь дүн шинжилгээ хийгээд энэ дээр ер нь бидэнд юу байна, бид хэд ер нь ямар хугацаанд энэ боломжийг бүрэн ашиглах тал руу хөлөө ахиу

тавьж чадах юм бэ энэ тэр гэдэг энэ тооцоолол юмнуудаа, энэ судалгааны байгууллагууд, энэ аж ахуй, бизнес, баялаг бүтээгчидтэйгээ дахиж санал бодлоо солилцоод явах нь зөв байх. Аль нэг талдаа хойшлуулаад гэдэг юм уу, дэмжихгүйгээр орхичихсон юм гэлгүйгээр судалгаа тооцооллуудаа нарийсгах, бас харилцан ашигтай байх энэ нөхцөл юмнуудаа бүрдүүлэх энэ тэр гээд энэ талаасаа асуудал даа хандаж байгаа юм байна гэсэн ойлголт юмыг төрүүлэх нь зөв болов уу. Энэ мэдээлэл чинь энд ч яриад байгаа юм биш шүү дээ. Бүх газар оччихсон бүх юмнууд мэдээллээ сонсоод л сууж байгаа шүү дээ. Дэлхий нийтээрээ хавтгайдчихсан мэдээллийн эрин зуунд бид бас хаана юу ярих вэ энэ тэр гэдэг нэлээн тийм бодолтой л байх тухай л ойлголт л болчхоод байгаа юм.

Тэгээд энэ талаасаа асуудал юмандаа хандвал яадаг юм. Үнэхээрийн манай ахиу аваад байгаа тэр 2.9 тэрбумаас бараг 2.4 тэрбум нь гуравхан бүтээгдэхүүн дээр байгаад байгаа шүү дээ. Үүнийг энэ тэрээ авах барих юмнуудаа аль болохоор таатай болгох талын асуудал юмнуудаа зөв харах, тэгээд энэ үндэсний дотооддоо барьж байгаа том аян, бодлого хөтөлбөр, үүнийгээ хангахын тулд олон аж ахуй бизнесийн байгууллагуудыг дэмжээд нэлээн гайгүй хөл дээр нь зогсоомоор болсон энэ зүйлүүд энэ тэрээ бас үүнтэйгээ уялдуулж, сөрөг үр дагавар юмнууд юу байна, тэрнээс яаж хамгаалж барих вэ энэ тэр гэдэг юмнуудаа дахин нарийсгаж тооцох энэ тэр зүйлүүд байх шиг байна. Би энэ талаас нь харж байна. Тийм учраас тооцоо юмнуудаа нарийсгаж дахин хэдүүлээ ярилцвал яасан юм бэ гэсэн ийм саналтай байна.

**Ц.Даваасүрэн:** Ганхуяг гишүүн.

**Х.Ганхуяг:** Энэ дээр уг нь юу яачихмаар байна бид нар энэ Байнгын хорооноос магадгүй Төсөв эдийн засгийн байнгын хорооноос хамтарсан ажлын хэсэг гаргаж хэлэлцүүлэг зохион байгуулах, санал, дүгнэлт бэлдэх ийм шаардлагатай юм болов уу гэж бодож байна. Тэрнээс биш ингээд зүгээр амаараа энэ гэрээ ашигтай юм гээд ингээд суугаад байж болохгүй л дээ. Энэ чинь олон монголчуудын, манай томоохон эдийн засгийн салбарын 600 мянган хүний шууд ажил, амьдралтай шууд холбоотой хэсэг. Тэгээд энийг ингэж хуумгай хандаж болохгүй л дээ. Тэгээд дараад нь энэ гэрээ ашиггүй бол манайхан сэргэлэн биш байсан юм байна, авхаалжтай байгаагүй юм байна гэсэн ийм л ийм асуудал ярихаар байна л даа. Сая бол Японы гэрээг тэгж дүгнэж байна шүү дээ. Манайхан өөрсдөө ингээд авхаалжгүй юм байна, манай бизнес маань өөрсдөө сэргэлэн биш юм байна гэдэг ийм байдлаар л дүгнэх шиг болох юм. Тэгээд би буруу сонсоогүй бол.

Тийм учраас бид нар өмнөх хийсэн гэрээнүүдээ ч бас дүгнээд энэ гэрээг хэрэгжүүлснээр бид нар ер нь яг эдийн засгийн хувьд үнэхээрийн ашигтай юм уу, ашиггүй юм уу гэдгээ бас харчихмаар байна. Тэрнээс биш бид нар энэ чинь Оростой сайн, муу харилцаатай холбоотой ерөөсөө асуудал биш байхгүй юу. Гол нь бид нар энэ чинь амьд үлдэх үү гэдгээ хармаар байна л гэсэн үг бид нар. Манай тэр ЖДҮ-ийн салбар, манай хүнсний салбар, манай энэ хөдөө аж ахуйн салбар амьд үлдэх үү, үгүй юу гэдгээ л хармаар байна гэсэн үг.

**Ц.Даваасүрэн:** Би нэг санал хэлчихье. Тэгээд санал хураалтаар шийдье. Тэгээд энэ тарифын дээд явж байгаа үед бид нар бас энэ асуудал дээр нухацтай хэлэлцэх ёстой. Тэр талаасаа би гишүүдийн ярьж байгааг зөв гэж бодож байна. Сайн ярилцъя.

Ер нь бид юмыг ойлгох хэрэгтэй. Бид нэг эдийн засгаас хараат байгаа шүү. Өнөөдөр экспортын орлогын 98 хувь шахуу болчихсон. Нэгхэн эдийн засгаас хамааралтай. Тэр дотроо ганцхан бүтээгдэхүүн 70 хувь нь. 15 тэрбум доллар орж байгаа 9 тэрбум доллар нь ганцхан нүүрс. Нүүрсний үнэ унавал яах вэ гэдэг асуудал. Төсвөө бид нар 3 дахин нэмчихсэн. 21 онд 11 их наяд байсан бол 35 их наяд. Нүүрсний үнэ унавал яах вэ? Төсвийн орлого байхгүй болно. Юугаараа цалинжуулах вэ, юугаараа тэтгэврээ тавих вэ? Тэгэхээр нэг эдийн засгаас хамааралтай байна гэдгийн аюул энэ. Хэрвээ бид нар нүүрсний үнэ унах юм бол ангал руу орно. Өөр нөхөх юм байхгүй. Манай хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүд бүгдийг нь шахаад 1-хэн тэрбум доллар байхгүй юу. Манай яг үндсэн олж чадаж байгаа юм бол 1-хэн тэрбум доллар. Цаана нь яах вэ алт, зэс 2, 3 тэрбум доллар.

Тэгэхээр бид нар нүүрс унахад Аргентин болно. Тийм л учраас бид нар ер нь яаж нүүрс унавал амьд үлдэх юм бэ гэдгээ бодохгүй бол ангал руу явах гээд байна шүү дээ. Дан ганц 1 л хүнтэй харьцаад байна гэдэг чинь осолтой зүйл шүү дээ. Хэрэлдэх 1 өдөр гарна. Хаашаа харж үхэх вэ нөгөө нөхрийгөө гомдоогоод явуулчихсан юм чинь. Тийм учраас бид нар хараат байна гэдгийг бас жоохон бодож явахгүй бол болохгүй шүү. Тэрийгээ ерөөсөө санаа зовохгүй юм. Хараат байх ёстой юм шиг л бодоод байх юм. Бусдаас харин хараат бус болчих вий гээд л айгаад байдаг. Нэг нөхрөөсөө ерөөсөө айхгүй. Олон найз нөхөдтэй болохыг хүсэхгүй.

Тийм учраас бид нар бас энэ нүүрсний үнэ эдийн засгийн энэ нэг талын хамаарал энэ тэрээ жоохон бодож явахгүй бол болохгүй. Бид нарт ганцхан л, хоёр, гуравхан л боломж байгаа. Хөдөө аж ахуйгаа чадна, аялал жуулчлалаар хэдэн төгрөг олж чадна. Өөр юмаар олж чадахгүй. Тийм учраас энэ том зах зээл рүү хөдөө аж ахуйгаар орох боломж байгаа бол. Ер нь энэ чинь манай хөршүүд л юм шүү дээ. Хөршүүдээсээ нэгэнтэй нь найз, нөгөөдхийг нь нулимаад байж болохгүй шүү дээ.

Тийм учраас энэ хөрш орнуудтайгаа яаж байх вэ гэдгийг бид нар нэлээн сайн бодно биз. Ер нь энэ хөршүүд бид нарыг юугаар хаагаад байна вэ? Импортын татвараараа л хаачхаад байна шүү дээ. 10-аас 40 хувийн татвартай бид нар бараа, бүтээгдэхүүнээ гаргаж чадахгүй. Энийгээ тэглээ ч гэж гуйж байсан үе манайханд бий. Савхин эдлэл, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдээ гаргая, та нар тэглэж өгөөч гээд бид л гуйж байсан шүү дээ.

Тэгэхээр энэ боломж байна уу, үгүй юу гэдгийг бас сайн тооцох хэрэгтэй. Би гишүүдийн бас тэр тооцоо судалгаа чинь дутуу байна гээд байгаатай бас санал нэг байна. Та нар энэ дээрээ бүүр сайн бэлдээд энэ дээрээ ашигтай, энэ дээрээ ашиггүй гээд. 11 тэрбум доллароос авах гэж байгаа юм гэдэг чинь бүдэг бадаг зүйл байхгүй юу. Энэнээс бид нарын авч чадах 300 сая байна, 200 сая доллар байна гэвэл өөр. Манайтай ижилхэн 3 сая хүнтэй хөдөө аж ахуйн орон Уругвай. Сүүгээрээ 700 сая доллар олно. Сүүгээрээ шүү. Ноосоороо 250 сая доллар олно. Манайх энэ хоёроор юу ч олохгүй. Энийг авах газрууд хаана байна гэдгийг л бид нар бодох ёстой шүү дээ. Ноос, ноолуур энэ маань хаана шингэх вэ гэж? Хөрш орнуудаа давуулаад явуулж чадна гээд байгаа яах вэ дээ. Хөрш орнуудтайгаа хаалттай байя гэж бодоод байгаа бол.

Тийм учраас хэдүүлээ энэ дээрээ нэлээн сайн нухацтай байх нь зөв байж магадгүй. Тэр боломжуудаа сайн та хэд маань гаргаж ирээд. Төрдөө итгэхгүй өөр хэнд итгэх юм бэ? Их сургуулийн хэдэн судлаачийнх нь зөв, төрийнх буруу, энэ

Эдийн засгийн хөгжлийн яам буруу гээд байж болохгүй шүү дээ. Төрдөө итгэхээс өөр хэнд итгэх юм. Бүх компанийн төлөөллийг бид нар оруулж ирж чадахгүй. Тийм учраас Худалдаа аж үйлдвэрийн танхимд нь итгэхээс өөр хэнд итгэх юм тэр компаниудынхыг. 300 компанийг оруулж ирж чадахгүй шүү дээ.

Тэгэхээр Хөдөө аж ахуйн яам бас энэ хөдөө аж ахуйн чиглэлээр гарч байгаа боломжууд дээрээ бүүр энэ дээрээ тэдэн сая доллар, энэ дээрээ тэдэн сая доллар, ийм боломжууд байна, энэ тэр гээд энгийн хэдүүлээ бүүр тодорхой байдлаар яривал яасан юм? Зүгээр лобби байх шиг байна. Өндөг энэ тэр гээд янз бүрийн юм байх шиг байна. Будаа, тариа энэ тэр гээд.

Тэгэхдээ хэдүүлээ улс орныхоо эрх ашгийг бодъё. Нэг эдийн засгийн хараат байж болохгүй шүү. Энийг та нар маш сайн бодож байх хэрэгтэй. Өнөөдөр нэг хэсэг нь ингээд хэдүүлээ энэ хамтарчихъя гэж байхад нь хөөж явуулчихаад дараа нь ганцхан найзтай суугаад байж болохгүй шүү. Тэгээд хэдүүлээ энийг нэлээн сайн яриад тэгээд хэлэлцэх эсэхээ хэдүүлээ ингээд шийдье.

Горимын санал уу? Горимын санал. Чойжилсүрэн сайдын микрофоныг өгье.

**Б.Чойжилсүрэн:** Гишүүдийнхээ өдрийн амрыг эрье. Байнгын хорооны хуралдааны хэлэлцүүлгийн явцыг хараад байхад яг өнөөдөр Даваасүрэн даргаа тийм, үгүй гэдэг шийдвэр гаргаад яах вэ. Энэ бас улс орны амьдралтай холбоотой байгаа учраас. Хойшлуулах ийм горимын санал гаргаж байгаа юм. Гишүүд байр сууриа нэгтгэх, олон нийт судалгаагаа нэгтгэе, хэлэлцүүлэгтээ бэлдэхэд бэлтгэе, шийдвэрээ гаргахад арай эрт байна гэж бодож байгаа учраас ийм горимын санал гишүүдийг дэмжиж өгөөч гэж хүсэж байна.

**Ц.Даваасүрэн:** Чойжилсүрэн гишүүний гаргасан горимын саналаар энэхүү асуудлыг хойшлуулъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

Ингээд 19 гишүүнээс 10 гишүүн дэмжээд 52.6 хувиар уг асуудлыг хойшлууллаа.

Тэгэхээр манай Эдийн засгийн яам, Хөдөө аж ахуйн яам тооцоо, судалгаануудаа гишүүдэд итгэл үнэмшил төрүүлж орж ир. Тэр экспортын хувьд яг ямар боломжууд гарах гээд. Экспортын хувьд боломжууд гарахгүй бол гишүүдийн хэлээд байгаа зөв шүү. Ер нь бид нар экспортоо бас жоохон олон талын болгох шаардлага бий шүү. Баярлалаа Дараагийнхаа асуудалд оръё.

12.28 цаг

**Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл.**

Хэлэлцүүлгийг эхэлье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Туваан сайд, Ерөнхийлөгчийн зөвлөх Г.Өлзийбүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Далай, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар нар оролцож байна.

Монгол Улсын агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Туваан танилцуулна. Туваан сайд танилцуулгаа хийе.

**Ц.Туваан:** Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга болон эрхэм гишүүдээ,

Өргөн уудам нутаг дэвсгэртэй, хүн амын суурьшил сийрэг, далайд гарцгүй манай орны хувьд агаарын тээврийн салбар нь гадаад ертөнцтэй холбогдох гол гарц болон үндэсний аюулгүй байдлын тулгуур хүчин зүйл болдгоо.

Иймээс Засгийн газраас агаарын харилцааг эдийн засгийн тэргүүлэх чиглэлд тооцон төрийн бодлогоор дэмжин ажиллаж байна. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан Шинэ сэргэлтийн бодлогын 1 дүгээр зүйл, Боомтын сэргэлт хэсгийн 1.3-д Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлахыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа, тээврийн зангилаа төвийг бий болгож, аялал жуулчлалын салбарыг дэмжинэ гэж тусгайлан заасан.

Түүнчлэн Шинэч сэргэлтийн бодлогын хүрээнд зам тээврийн салбарын болон боомтын дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр үндсэн 5 зорилт дэвшүүлж, Монгол Улсыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шатаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, агаарын зайн ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх нислэгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлалыг үе шаттай хэрэгжүүлж, ачаа, тээврийн зангилаа төвийг бий болгож, аялал жуулчлалыг дэмжих зорилтыг тавьсан.

Монгол Улсад агаарын хөлгийн үйлчилгээ эрхэлж буй дотоодын 20, гадаадын 7 буюу нийт 27 авиа компани байгаагаас 2024 оны байдлаар нийт нислэгийн тоо 91781 болж, мөн өмнөх оны мөн үеэс 44.6 хувиар, олон улсын хөөрөлт, буултын тоо 12990 болж 34.5 хувиар, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 10967 болж, өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар тус тус өссөн бөгөөд нийт 2 сая 167 мянган зорчигч тээвэрлэснээс олон улсад сая 750, орон нутагт 420 мянган зорчигч тус тус зорчсон байгаа нь 23 онтой харьцуулахад олон улсын чиглэл 25 хувь буюу 435 мянган зорчигчоор, орон нутгийн чиглэл 0.25 буюу 1000 гаруй зорчигчоор тус тус өссөн үзүүлэлттэй байна. Ачаа, тээврийн хувьд 24 оны байдлаар 10365 тонн ачаа тээвэрлэсэн нь 23 онтой харьцуулахад 21 хувиар тус тус өсжээ.

Аялал жуулчлалд эдийн засгийн идэвх нэмэгдэж байгаа нь 2028 он хүртэл зорчигч, ачаа тээвэрлэлт тогтвортой өсөлттэй байх төлөвтэй бөгөөд агаарын тээврийн зорчигч тээврийн тоо 2024 онд 2.2 саяд хүрсэн бол 2028 онд 2.55 саяд хүрэх төлөвтэй байна.

Өнөөгийн байдлаар манай улс агаарын хөлгийн түлшийг 100 хувь Оросын Холбооны Улсаас импортолж байгаа бөгөөд сүүлийн 5 жилд ТС-1 агаарын хөлгийн түлшний хэрэглээ тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал, 2021 онд 27000, 22 онд 38000, 23 онд 61000, 24 онд 70000 тонн хүрч тогтмол өссөн дүн гарчээ.

Энэхүү өсөн нэмэгдэх хандлагатай агаарын хөлгийн түлшний хэрэглээг зах зээлийн боломжит доод үнээр нийлүүлснээр хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хадгалахаас гадна иргэдэд хүрэх нислэгийн тийзийн үнэ буурахад тодорхой хувиар нөлөөлөл үзүүлэх боломжтой.

Агаар хөлгийн тээврийн үйлчилгээ авч буй иргэдэд хүрч буй тийзийн үнийн 36 хувь нь агаарын хөлгийн түлшний үнээс, харин агаарын хөлгийн шатахууны үнийн 86 орчим хувь нь хил үнээс тус тус шууд хамаарч байна.

Манай орон хөрш хоёр улстай хуурай боомтоор хиллэдэг. Далайд гарцгүй орны хувьд агаарын тээвэр нь чухал ач холбогдолтой бөгөөд агаарын хөлгийн түлшийг Оросын Холбооны Улсаас төмөр замаар их хэмжээгээр Улаанбаатар хот хүртэл тээвэрлэх боломжтой.

Харин БНХАУ-аас онгоц түлш худалдан авахад төмөр замын царигийн зөрүүтэй байдлаас шалтгаалан Замын-Үүд боомтоор шилжүүлэн ачих байгууламжаар дамжуулан авахад одоогоор онгоцны түлшийг хадгалах зориулалтын сав, насос станц, дотоодын тусгай вагон, цистерн дээр нь байхгүй байна.

Мөн БНХАУ-аас нийлүүлэгдэх онгоцны түлшний стандартын хувьд Жет-А түлш бөгөөд өнөөдөр ашиглалтад ороод байгаа шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн байгууллага ТС1- агаарын хөлгийн түлштэй хамтад нь ашиглах технологийн шийдэл төлөвлөгдөөгүй байна.

Цаашид дэлхийн зах зээл дэх газрын тосны үнэ болон Оросын Холбооны Улсын газрын тосны бүтээгдэхүүний дотоод зах зээлийн нөхцөлтэй холбогдуулан Оросын Холбооны Улсын Засгийн газраас экспортын хязгаарлалт хийх, татвар нэмэгдүүлэх шийдвэр гарч болзошгүй бөгөөд энэ нь манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт, тэр дундаа агаарын хөлгийн түлшний нийлүүлэлтэд нөлөөлж хомсдол үүсэж болзошгүй юм.

Иймд Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулснаар агаарын хөлгийн түлшний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, Чингис Хаан олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийг тасралтгүй үргэлжлүүлэх, агаарын тээврийн хэрэгслээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүд олон улсын стандартын шаардлагад нийцсэн шатахууныг тогтвортой нийлүүлэх болом бүрдэх юм.

Манай улсын газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч Оросын Холбооны Улсын зүгээс агаарын тээврийн салбарт хамтран ажиллах талаар өмнө нь удаа дараа хүсэлтээ илэрхийлсээр ирсэн бөгөөд Монгол Улсад Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Путины албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг байгуулж, Монгол Улсын олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд болон Оросын Холбооны Улсын Эрчим хүчний сайд нар урьдчилсан байдлаар гарын үсэг зураад байна.

Энэхүү хэлэлцээр нь Монголын тал хуульд заасан дотоодын процедурыг хангаж зохих шийдвэр гарсны дараа үйлчилж эхлэх бөгөөд тус хэлэлцээрт агаарын хөлгийн түлшний хангамж, нийлүүлэлт, татварын тогтвортой байдалтай холбоотой заалтууд орсон байх тул Улсын Их Хурлын бүрэн эрхийн хүрээнд хэлэлцүүлэн шийдвэрлүүлж холбогдох шийдвэр гаргуулах шаардлагатай юм.

Оросын Холбооны зүгээс энэхүү хоёр хэлэлцээр хамтдаа хүчин төгөлдөр үйлчлэх талаар мэдэгдсэн бөгөөд газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангахын тулд Монгол Улсад Агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг танилцуулж байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

**Ц.Даваасүрэн:** Туваан сайдад баярлалаа. Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүн байна уу?

Батжаргал гишүүн. Ганбаатар гишүүнээр тасалъя. Батжаргал гишүүн асуултаа асууя.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. 2, 3 тодорхой асуулт байна. Ер нь үндсэндээ энэ агаарын хөлгийн түлшний хангалт, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, үнэ өртгийг бууруулах чиглэлээр 2022 оны төгсгөл, 2023 оны эхэн дээр билүү Их Хурал ярьсан юм. Эрдэс ойл-ыг төрийн өмчтэй компани байгуулаад, Роснефттэй хамтарсан компани бий болгоод тэгээд түлшнийхээ хангалт, үнийг бууруулах замаар эндээс цэнэглэлтийг нэмэгдүүлэх тухай асуудлыг нь агаарын тээврийн асуудалд нэлээн том үр дүн өгнө гэсэн. Судалгаа юмнуудыг харахаар 23 оноос эрс нэмэгдсэн байдаг юм. Тэгэхээр би энэ тодорхой үр дүнгүй өгөөд явж байгаа ажил гэж ингэж ойлгоод байгаа юм. Дахиж Засгийн газрын хэлцэл орж ирээд байгаагийн утга учир нь юунд байгаа юм бэ гэдэг нэг асуудал.

Хэлэлцээрийн чинь 4.3 дээр Оросын талын итгэмжлэгдсэн тэр аж ахуй нь энэ агаарын хөлгийн түлшний нийлүүлэлтийг бүрэн хариуцахаар оржээ. Бид аж үйлдвэр юу, газрын тос боловсруулах үйлдвэрийг 1.7 тэрбум төгрөгийн юу, долларын зээлээр бариад 28 оны 2 дугаар улиралд гэхэд ашиглалтад оруулна. Тэр үйлдвэрийн чинь гол 1 бүтээгдэхүүн нь агаарын хөлгийн түлш ээ. Би одоо буруу санаагүй бол 95 мянган тонныг жилд үйлдвэрлэхээр ТЭЗҮ-тэй шиг санаад байх юм. Биднийнх 70 орчим мянган тонны жилийн юутай байна одоогийн байдлаар. Тэгэхээр зэрэг 28 оноос 20 жилийн одоо энийгээ ханган нийлүүлнэ гэх юм бол 10 хэдэн жил бид өөрийнхөө үйлдвэрлэсэн агаарын хөлгийн түлшээ хааш нь борлуулах юм?

Дараа нь тэр үйлдвэр ашиглалтад орохоор бүтээгдэхүүнээ яах аргагүй шинэ тэр нисэх буудлын чинь түлшний агуулахад хийнэ. Тэр бүх боломжуудаа бид хамтарсан компанийнхаа эзэмшилд өгөөд, дээр нь Оросын талын итгэмжлэгдсэн компанийн хөрөнгө оруулалтыг хийлгэхээр энэ дотор гэрээн дотор орчихжээ. Хэлцэл дотор. Дан ганц ханган нийлүүлэлт биш юм байна шүү дээ. Энэ чинь яг нарийндаа хөрөнгө оруулалтыг дэмжсэн хэлцэл орчхоод байгаа юм байна. Тэгэхээр бид өөрийн мэдлийн савгүй болж хувирах гэж байна. Үүнийг юу гэж ойлгох юм бэ? Ийм хэдэн зүйл дээр тодорхой хариу авмаар байх юм.

**Ц.Даваасүрэн:** Тодорхой хариулаарай Туваан сайдаа. 5 номерын микрофон өгье.

**Ц.Туваан:** Батжаргал гишүүний асуултад хариулъя. Эрдэс ойл компани 2020 оны 1 сарын 8-нд байгуулагдсан. Энэ цагаас хойш үйл ажиллагаа явуулж байгаа. 100 хувь хуучнаар Уул уурхай, хүн д үйлдвэрийн өнөөдрийн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдэлд хувьцаа эзэмшигч буюу төрийн өмчийн компани байгаа. Үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа. Саяхан Засгийн газар дээр шийдвэр гараад төрийн өмчийн хорооны бас шийдвэр давхар гараад энэ Чингис хаан нисэх онгоцны буудлын онгоц цэнэглэх энэ дэд бүтцийг “Эрчис ойл” компанийн мэдэлд шилжүүлэн авсан байгаа гэдгийг хэлье.

Дахиад яагаад Улсын Их Хурлаар оруулж ирж байгаа гэхлээр энэ 2 хэлэлцээр байгуулагдсан. Өмнө нь Путин Ерөнхийлөгч айлчлалын үеэр миний бие Оросын Холбооны Улсын Эрчим хүчний сайд Цивилёвтой байгуулсан. Хоёр дахь хэлэлцээр дотор нь заалт байгаа нь энэ хэлэлцээр Их Хурлаар батлагдсанаас хойш гарах янз бүрийн татварын нэмэгдэлтэй холбоотой асуудлууд энэ тэрийг ярихгүйг. Энэ асуудал тогтвортой байна гэдэг зүйл байгаа учраас, Их Хурлын бүрэн эрхэд байгаа асуудал учраас Их Хурлаар батлагдсанаас хойш хүчин төгөлдөр болох ийм хэлэлцээр байгаа гэдгийг хэлье.

Оросын Холбооны Улсаас энэ хамтарсан компанийг Монголын 60, Оросын Холбооны Улсын 40 хувийн “Роснефть Аэро” гэдэг компанийн 40 хувийн хамтарсан компани “Эрчис ойл” компанийн доор байгуулагдана. Тэгээд энэ дээр ямар нэгэн тэр манай ашиглаж байгаа “Эрчис ойл” компанийн дэд бүтэц үндсэн хөрөнгөөс ямар нэгэн байдлаар тэр энэ хамтарсан компанийн эрх мэдэлд шилжих асуудал байхгүй. Эндээс компани түрээсийн журмаар энэ бүтцийг ашиглаж борлуулалтаа хийгээд явна гэдгийг хэлье.

Газрын тос боловсруулах үйлдвэр маань 28 оны эхний улиралд ашиглалтад ороод ойролцоогоор 80 орчим мянган тонн агаарын хөлгийн түлшийг үйлдвэрлэхээр ийм төлөвлөгөөтэй байгаа. Энэ өмнө нь 2022 онд Ёндон сайдын үед 2 улсын дээд хэмжээний уулзалтын үеэр санамж бичиг энэнтэй холбоот байгуулсан дотор өнөөдрийн байдлаар 75 орчим хувийг энэ хамтарсан компани, бусад 25 хувийг нь бусад компаниуд ханган нийлүүлэх байдлаар, мөн дотоодын газрын тосны боловсруулах үйлдвэр ашиглалтад орж бүтээгдэхүүнээ нийлүүлсэн тохиолдолд дотоодын компани давуу эрхтэйгээр нийлүүлэх ийм байдлаар энэ санамж бичигт орж зурсан байгаа гэдгийг хэлье.

Савны хувьд энэ сав болон тэр цэнэглэх дэд бүтцүүд өөрөөр хэлбэл, тэр хоолой, шахуур, газар доорх гидрант энэ тэр гээд бүх байгууллага “Эрдэс ойл”-ынхоо мэдэлд хэвээрээ байна. Хамтарсан компанид ямар нэгэн байдлаар эндээс 60 хувьдаа оруулж, үл хөдлөх хөрөнгө гаргах асуудал байхгүй гэдгийг хэлье.

**Ц.Даваасүрэн:** Батжаргал гишүүн тодруулъя.

**Ж.Батжаргал:** Тийм ингээд хэдүүлээ энэ гадаад харилцааны гол асуудал, бидний хийж чадахгүй байгаа бүх хэрэглээгээ хангуулж байгаа улс оронтойгоо хийж байгаа Засгийн газрын хэлэлцээр. Үүн дотроо нарийн юмнуудаа бүгдийг оруулж хийхгүй бол болохгүй. 28 оны 1 дүгээр улиралд үйлдвэр чинь ашиглалтад орчихно. Тэрний чинь гол бүтээгдэхүүн агаарын хөлгийн түлш.

Гэтэл бид энэ Засгийн газар хоорондын хэлэлцээрийнхээ 4.3 дээр хамтарсан компанид агаарын хөлгийн түлш нийлүүлэх ажлыг Оросын талын итгэмжлэгдсэн байгууллага хэрэгжүүлнэ гээд хэлчихсэн. Энэ хэлэлцээрийг 20 жил тогтвортой мөрдөнө өө гээд 12 дугаар зүйл дээрээ хэлчихсэн. Үгүй тэгээд одоо энэ чинь бид яах юм? Орос нефтэд өөрийнхөө үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг өгч байж буцаагаад энэ өөрийнхөө агаарын хөлгийн түлш рүү татаж авах юм уу, хаашаа юм? Энэ чинь улам ойлгомжгүй байдал, хүндрэлийг бий болгох гэж байгаа байхгүй юу. Энэ асуудлаа.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Энэ нэлээн чухал асуудал шүү. 5 номерын микрофон энэ дээр нэлээн тодорхой хариулаарай.

**Ц.Туваан:** Тийм энэ асуудлуудыг одоо бас яг энэ хэлэлцээр соёрхон батлагдсаны дараа “Роснефть Аэро” компанитай Эрдэс ойл компани хэлэлцээрт ороод дахиж гэрээ байгуулна. Энэ гэрээн дотроо яг таны Батжаргал гишүүний хэлсэнтэй холбоотой асуудлыг бас нэлээн нарийн тусгаж өгнө.

Дотоодын газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад ороод энэ 80 мянган тонн. Өнөөдөр ингээд сүүлийн жилүүдээс нь ингээд харахаар саяын танилцуулгатай холбоотой ингээд харахаар сүүлийн онуудад энэ агаарын хөлгийн түлшний хэрэглээ огцом өсөж байгаа. Маш их нислэгтэй болоод ирж байгаа. Тэгэхээр бид нарт энэ дотоодын 80 мянгаа үйлдвэрлээд, дээр нь хэрэглээд цаана нь дахиад импортлох ийм асуудал гарч ирнэ. Энд агаарын хөлгийг түлшээр цэнэглэх энэ байгууламжийн газар доорх болон бас агуулахын хүчин чадал нийтдээ 140 мянган

**Ц.Даваасүрэн:** Нэмэх юм уу, болчихсон уу? Тодруулъя Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Тийм үүн дээр их тодорхой оруулмаар байна. Тэгвэл бас тийм боломж байна уу? 4.3 дээрээ манай үндэсний үйлдвэр ашиглалтад оронгуут бүтээгдэхүүнийг нь яг энэ юу руугаа татаж авна гэдэг юмаа тодорхой оруулахгүй бол энэ 2 заалтаар чинь бид үнэхээрийн өөрийнхөө үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг ашиглах боломжгүй болчихоод байгаа юм.

Хоёр дахь асуудал. Тэр оросын талын итгэмжлэгдсэн компаниар ямар хөрөнгө оруулалт хийлгэх гээд байгаа юм бэ? Энэ чинь ханган нийлүүлэлтийн хэлэлцээр гэхээсээ илүүтэйгээр хөрөнгө оруулалтын хэлэлцээр байна лээ шүү яг нарийндаа. Тэр битгий хэл тэр хийгдсэн хөрөнгө оруулалтуудыг нь хамтарсан компани дээрээ биш Монголын хуулийн этгээдтэй хамтраад хөрөнгө оруулалт хийж болохоор хэлцэл дотор чинь үг орчхоод яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр би бас хардаж байгаа ний нуугүй үнэнийг хэлэхэд. Энэ баахан аймгийн төвүүдийн нисэх буудлууд дээр хамтарсан компанийн хөрөнгө оруулалттай бас ийм цэнэглэлтийн юмнууд зарим бүсүүд дээр хийгдэх нь дээ энэ янз нь.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Нөгөө нефтийн үйлдвэр ашиглалтад ороод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ өөрсдөө ашиглаж чадахгүй болчих вий дээ энэ гэрээнээс гээд байна шүү дээ. 5 номер.

**Ц.Туваан:** Энэ асуудлыг бид хэд бас онцгой анхаарч байгаа. Энэ 2 компанийн хооронд хийх гэрээний драфт дээр энэ тусгагдсан байгаа гэдгийг бас гишүүнд хэлье. Дээрээс нь.

**Ц.Даваасүрэн:** Наадах чинь ингээд зурагдаад ингээд батлагдчихаар дараагийн гэрээнд чинь өөрчлөлт, ийм асуудал орж чадахгүй болчих вий гэж болгоомжлоод байна шүү дээ. Тэгэхээр одоогийнхоо гэрээн дээр наадхаа нээлттэй болгож авахгүй бол дараагийн гэрээ гэдэг юм байхгүй шүү дээ.

**Ц.Туваан:** Тийм, Засгийн газар хоорондын байгуулах хэлэлцээр, 2 хэлэлцээр зурагдсан байгаа. Энэ өнгөрсөн оны 9 сард. Нэгдүгээрх нь мэдээж бүтээгдэхүүнээр тасралтгүй ханган нийлүүлэгдэх гэрээ. Монгол Улсын өнөөдрийн хэрэглэж байгаа нийт нефть бүтээгдэхүүний 97 хувь нь 92 дизель, 80 байгаа. Агаарын хөлөг бол нийт бүтээгдэхүүний 2.6 хувийг эзэлж байгаа. Оросын Холбооны Улсын талаас энэ 2-ыг гэрээг зурсан боловч 2 дахь нь Их Хурлаар хэлэлцэгдэн батал, соёрхон бат.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Алтанхуяг гишүүн асуултаа асууя.

**Н.Алтанхуяг:** Энэ саяын Батжаргал гишүүний хэлээд байгааг анхаараад засчихгүй бол одоо бид хэд ингээд энийгээ баталчихаар чинь дараа нь 2 компани юугаа ярих вэ дээ. Тэн дээр энэ тэгж ойлгож байгаа юм уу, ойлгохгүй байгаа юм уу? Одоо гэрээ байгуулаад ингээд Их Хурлаар ороод баталчихаар чинь тэрийг чинь өөрчлөх боломжгүй болчихно шүү дээ. Тэгээд л манай үйлдвэр шиг юм нь тэгээд босох юм бол жаахан Орос бензин үйлдвэрлэхээр нь тэрийгээ хэрэглэж чадахаа больчих юм биш байгаа юм гээд болгоомжлоод байгаа нь зөв л дөө.

Тэгэхээр энийг Оросын тал нь ч ойлгож байгаа байлгүй дээ. Та нар наад хийж байгаа гэрээгээ ингэж ойлголцоод засах барих юмаа засаад оруулж ирж болдоггүй юм уу? Тэр 40 хувь гэдгийг нь би ойлгохгүй. 40 хувьдаа юу оруулах гэж байгаа юм? Түүнээс биш бензин чинь бол зүгээр л урсгал шүү дээ тийм? Тэгээд 40 хувьдаа юу оруулах гэж байгаа юм? Яах юм, яадаг компани юм тээ? Ер нь ашгийнхаа 40 хувийг авна гэсэн үг биз дээ бас? Тэгээд татвараа тогтворжуул гээд тэгж байна. Тэгвэл нөгөө талд нь тэр үнэн дээр нь бас ингээд харьцангуй савлагаа багатай байхаар юм яригддаг юм уу тэр гэрээ дээр чинь. Тэн дээр хариулт өгөөдхөөч.

**Ц.Даваасүрэн:** 5 номер Туваан сайд хариулъя.

**Ц.Туваан:** Тийм, энэ саяын Батжаргал гишүүн, Алтанхуяг гишүүн нарын санаа зовж байгаа асуудлуудыг ойлгож байгаа. Бид бүхэн энийг бас гэрээндээ тусгаад явна. Энэ өөрөө бас багцаараа 2018 онд Монгол Улсын, 2 улсын төрийн дээд айлчлалын үеэр анхны санамж бичгийг 18 онд Оросын Холбооны Улс Владивостокт байгуулаад, тэрнээс хойш төрийн бүх дээд хэмжээний уулзалтууд дээр энэ асуудал яригдаад, 22 онд мөн дээд хэмжээний айлчлалын үеэр 2 улсын сайд нар Монголын талаас Ёндон сайд бас санамж бичиг гарын үсэг зурсан. Энэ хүрээнд энэ энэ зүйл дотор бол дангаараа энэ компани 100 хувь нийлүүлэхгүй, 75 хүртэлх хувийг энэ хамтарсан компани нийлүүлэхээр, 25 хувийг бусад компани нийлүүлж болохоор заалт энэ санамж бичиг дотор орсон.

Дээрээс нь газрын тос боловсруулах үйлдвэр дотоодын үйлдвэр ашиглалтад орсон тохиолдолд давуу эрхтэйгээр тэндээс авахаар ийм заалтууд тусгагдсан байгаа. Бид бүхэн энийг бас анхаараад цааш нь гэрээндээ тодорхой тусгаад яв явъя.

40 хувь дээр нийтдээ энд жишээлэх юм бол бүтнээрээ гэж бодоход чинь 70 мянган тонн. Энэ бол ингээд өдрөөс өдөрт нэмэгдээд явж байгаа энэ түлшийг энэ 40 хувьдаа оруулж, Оросын талаас гаргах хөрөнгөндөө тооцож оруулна гэж ингэж ойлгож болно. Монголын талаас 60 хувьтай, компанийн засаглал 60 хувь нь Монголын талд байна гэж ингэж ойлгож болно.

Мэдээж дотор нь энэ Оросын Холбооны Улсаас авах энэ түгээх системийн засвар үйлчилгээтэй холбоотой, засвар, сэлбэг хэрэгсэлтэй холбоотой зүйлүүдийг бас 40 хувь дотор оруулаад авна гэж ойлгож болно.

**Ц.Даваасүрэн:** Алтанхуяг гишүүн тодруулъя.

**Ц.Туваан:** Туваан сайд минь их л архаг урт үргэлжилсэн сонин сонин гэрээнүүд ярилаа даа. Одоо наадах дээрээ бүгдээрээ бүдэрч унах вий дээ. Тэгээд нэгэнт ажлаа хариуцаад хийж байгаа юм чинь тэгээд юмаа зөв хийгээрэй л гэж би хэлье.

Хоёрдугаарт нь 40 хувьд нь бензинээ оруулна гэж байхгүй л дээ. Компани байгуулагдахад бензин юу гэж тэр 40 хувьд нь явах вэ дээ. Тийм компани гэж би ер нь өнөөдрийг хүртэл амьдралдаа ойлгохгүй л юм байна. Худалдаж авах гэж байгаа бараагаа 40 хувьдаа оруулаад тооцно гэж тийм юм байж болдог юм уу? Ийм иймэрхүү юмнуудаа та нар энэ Засгийн газрын гишүүд байж гайхаад л байх юм. Түрүүн тэр Гантөмөр орж ирээд ярьж байгаа энэ тэрийг сонсоход. Хүний юм үргэлжлүүлээд явж байгаа царайтай. Тэгэхдээ тэр нь тэгээд үргэлжлүүлэхдээ аль ч Засгийн газар өмнө нь жижиг сажиг алдаа, зөрүүнүүд гарсан бол нөгөө талтайгаа аятайхан яриад тэнийгээ засаж, залруулж явах нь дараачийн хариуцсан хүмүүсийн ажил л даа. Тэгээд та нар.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Энэ тийм тийм төрийн уламжлал юм чинь хэн нь ч бай, аль ч намын ч хүн бай тэр чинь явдгаараа л явах ёстой шүү дээ. Тэгэхээр тэрэнд урьдахыгаа тэнд хийх юм байхгүй. Ер нь байна шүү дээ тэр Алтанхуяг гишүүний болгоомжлоод байгаа юман дээр та нар тодорхой хариулчихмаар байгаа юм. ..., яг тэгээд дараа нь манайх бүтээгдэхүүнээ үйлдвэрлэлчхээд өөрөө хэрэглэж чадахгүй болчих асуудал байна уу, үгүй юу? Наад гэрээ чинь хаагаад хаячих гээд байна уу, үгүй юу гээд байна шүү дээ.

5 номерын микрофон Туваан сайд хариулъя.

**Ц.Туваан:** Энэ асуудлыг бид нар мэдээж Монгол Улсын эрх ашгийн үүднээс нэлээн хугацаанд судалж, үзэж, бас өмнө нь хэлж байсан Путины айлчлалын үеэр зурагдсанаас хойш өнөөдрийг хүртэл хугацаанд нэлээдгүй судалж үзсэн. Дээрээс нь энэ компани бол Улаанбаатар төмөр зам шиг 50:50 биш, 60 хувийн Монголын эзэмшилтэй, 40 хувь нь Оросын Холбооны Улсын эзэмшилтэй компани байгаа. Хамтарсан компани дээр хөрөнгө тэдэн долларын, тэдэн хэмжээний хөрөнгөтэй компани гэж орж ирлээ гэж бодоход тэрэнд оруулах хөрөнгийнхөө хувьд нь энэ нийлүүлэх түлшний асуудлаа оруулна гэсэн ийм тооцоололтой. Мэдээж бас бус засвар үйлчилгээ, техник тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэлтэй асуудлууд бас ороод яв явж байгаа. Тэгээд гишүүдийн хэлж байгаа зүйлийг гэрээ байгуулахдаа онцгой анхаарч ажиллая.

**Ц.Даваасүрэн:** Дамдинням гишүүн асуулт асууя.

**Г.Дамдинням:** Бид нар ч тэгээд энэ түлш шатахуунаараа л тэгээд ингээд байж байгаа л улсууд л даа. Тэгээд энэ гишүүдийн хэлж байгаатай санал нэг байгаад байдаг. Өөрийн дотоодын үйлдвэр маань ойрын хэдэн жилдээ ийм ашиглалтад орчих юм байна лээ. Тэгээд тэрний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тодорхой яг оруулчихаач л гээд гишүүд хэлээд байна л даа. Тэгэхгүй бол бид нар ингээд бүрэн хараат болоод өөрийнхөө юмыг ч хэрэглэж чадахгүй байдал руу орчих вий дээ гэдэг саналыг хэлээд байгаа. Битгий бөөрөнхийлөөрэй Туваан сайдаа.

2022 онд шүү дээ ийм бас л яг энэ онгоцны түлштэй холбоотой асуудал орж ирсэн байхгүй юу. “Мэргэ ван” гээд хувийн компани хийдэг байсныг тикет/ticket/ үнэтэй болгож байна гээд тэр нь ч бас үнэн байсан. Ингээд төрийн өмчийн Эрчис гэдэг компани хийе. Ингэх юм бол болох гээд байна үзүүлээд өгнө өө л гэсэн. Яах вэ болсон байх. Тэгээд 100 хувь төрийн өмчийн компаниар нийлүүлдэг болонгуутаа араас нь ингээд 20 жилийн гэрээгээр ингээд л түгжиж авах л юм ороод ирлээ л дээ.

Тэгээд тэр үед бид нар ярьж байсан юм бол юу ярьж байсан бэ гэхээр өмнөд хөршөөс бензин тос энэ юмнуудаа импортлох бэлтгэл ажлаа хангаарай, нэг газраас хамааралтай байдлаа бууруулаарай, хөрөнгө оруулалтаа хийгээрэй. Тэр үед бол хүлээж авах зам нь ч байхгүй, сав суулга нь ч байхгүй, дамжуулан ачих төв нь ч байгаагүй юм. Хийгээд өгнө өө л гээд. явсан л даа. Хууль тэгж өөрчлөгдсөн юм тэр үед 22 онд. Тэгээд энэ ажил ер нь ямар явж байгаа юм бэ? 20 жилийн гэрээ байна уу, 10 жил байна уу, 5 жил байна уу ямар ч байсан бид нар хойд хөршөөсөө авахаас өөр гарцгүй. Тэгэхдээ урд хөршөөс авахад үүд хаалгаа бид нар нээхэд бэлэн байгаа юу? Та нар ингээд гэрээ хийгээд л аргалаад л өөрийнхөө цаг үеийг өнгөрөөгөөд дуусгачих вий дээ нэгдүгээр асуудал. Энэ бэлтгэл ажил хэд байгаа юм?

Хоёрдугаарт ийм гэрээ олон нийтийн өргөн хэрэглээнд байдаг 92 дизель түлшнүүд рүү ороод ирэхгүй биш биз дээ? Одоо энэ гэрээн дээрээ энэ юм руу орж ирэхгүй шүү гэдэг юмыг нь хийж болохгүй юу? Дизель түлшний хэрэглээ, иргэдийн хэрэглээний бензинүүд, бензин тосонд ийм хатуу гэрээ тулгахгүй гэдэг квотыг нь юу гэдэг юм хязгаарлалтыг нь энэ гэрээндээ та нар тусгаж өгч болох уу? Ийм боломж байна уу? Тэгэхгүй энэ чинь тэгээд жижиглэн худалдаа руу өөрсдөө орж ирээд, дизель рүү өөрсдөө орж ирээд ингээд явчихвал бид нар дийлэхээ байчихна шүү дээ. Тэгээд энэ хамгийн чухал нь 2 нэмэлт эх үүсвэр байна шүү дээ. Дотоодын эх үүсвэр, урд хөршөөс худалдаж авах эх үүсвэр гээд. Энийг бас балансжуулах талаас нь та нар бодож байгаа, хийж байгаа юм уу байна?

**Ц.Даваасүрэн:** Туваан сайд энэ чинь нөгөө Ерөнхийлөгчийн айлчлал дээр зурагдах гээд байгаа гэрээ юу? Цаг цаг хугацааны хувьд та нар шахагдаад ингээд байна уу? Ер нь жоохон тодорхой л хариулмаар байгаа юм шүү. Засаж чадахгүй болчих гээд байна шүү дээ. Ингээд хэрвээ наадах чинь зурагдчихвал бид нар бүтээгдэхүүнээ өөрөө авч хэрэглэж чадахгүй болчих гээд байна гээд гишүүдийн болгоомжлоод байгаад л та тодорхой хариулмаар байгаа юм л даа.

**Ц.Туваан:** Дамдинням гишүүн энэ асуултад тодорхой хариулъя. Бид нар сумаар 2 туулай буудах гэж байгаа. 2 гэрээ байгаа. Өмнө нь бид нар нефть бүтээгдэхүүн ханган нийлүүлэх ийм тогтвортой нийлүүлэх Засгийн газар хоорондын хэлэлцээр байхгүй байсан. Тэгэхээр Оросын Холбооны Улс дээр ямар нэгэн экспортын хориг юм уу, эс үгүй бол нефтийн байгууламжууд халдлагад

өртсөн үе болгон дээр бид нар Оросын Холбооны Улсын элчин сайд руу юм уу, Орост суугаа Элчин сайд руугаа ярьж энэ манайд хамаагүй биз дээ энэ тэр гэж ингэж ярьдаг байсан. Энэ хэлэлцээр байгуулагдсанаар энэ асуудал бас өөрөөр хэлбэл 97 хувиа хангаж байгаа асуудал нэгдүгээр хэлэлцээрээр ингээд батлагдаж байгаа.

Тэгээд Оросын талаас энэ 2 хэлэлцээрийг пакетна буюу хамтаар нь явуулъя гэдэг ийм саналаа хэлчихсэн явж байгаа. Тэгэхээр энэ асуудал бол дам ашиг нь гэдэг юм уу, давхар ийм зорилготой байгаа гэдгийг бас энэ ташрамд хэлье.

Өмнө нь “Мэргэ ван” гэдэг компани энийг хийж байсан. Тэгээд энэ дээр бас шүүмжлэлүүд гараад энэ “Эрчис ойл” компани руу шилжсэн. Энэ дээр үнийн зөрүүтэй асуудлууд яригдаж байсан. Өнөөдөр ч гэсэн энэ онгоцны түлшний 10 гаруй хувийг хувийн хэвшлийнхэн хийж байгаа. 10 гаруй мянган тонныг оруулж ирж борлуулж байгаа. Үнийн хувьд тонн тутамдаа 800 мянгаас 1 сая төгрөгийн илүү үнэтэйгээр ингээд бас борлуулаад явж байгаа гэдгийг хэлье.

Энэ манай дээр Засгийн газар дээр батлагдсан нэг бодлого энэ үндэсний аюулгүй байдалтай холбоотой, өөрөөр хэлбэл нефть бүтээгдэхүүний энэ агуулах савтай холбоотой энэ бас тодорхой хэмжээний үүрэг чиглэлийг манай яаманд өгөөд явж байгаа. Тэгэхээр энэ агуулахыг байгуулах, дээрээс нь олон эх үүсвэрээс энэ нефть бүтээгдэхүүнээ авах гэдэг энэ бодлого явж байгаа. Энэ хүрээнд бид нар “Эрчис ойл” компани дээрээс бас энэ урд хөршөөс орж ирэх дээр манай урд талд байгаа ганцхан томоохон агуулах буюу Замын-Үүдийн шилжүүлэн ачих байгууламжийг шилжүүлж аваад явж байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар урд хөршөөс ганцхан онгоцных биш, бусад түлшээ оруулж ирээд энэ дээр менеж хийгээд буулгаж аваад дотоод руугаа, ялангуяа говийн бүс дээр манай уул уурхайн дизель түлшний хэрэглээний 70 хувь явж байгаа үед урдаасаа оруулж ирээд тэндээ хэрэгжүүлэх вэ гэдэг энэ бодлого нэлээн эрчимтэй яригдаад ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа гэдгийг бас танд хэлье.

Энэ бусад энэ өөрөө хэлэлцээрийн нэр нь агаарын хөлгийн түлш. Тийм учраас бусад түлшинд энэ хэлэлцээрийнхээ нэрээс өсүүлээд энэ асуудал руу орохгүй гэдэг баталгааг хэлье.

Дээрээс нь энэ жижиглэн дээр манай дээр хууль дээр компани дотоодын хангалтын 30-аас дээш хувийг хангаж байгаа тохиолдолд жижиглэнгийн худалдаа руу орохгүй гэдэг ийм тов тодорхой заалт байгаа. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн байдлаар том компани оруулж ирээд жижиглэн худалдааг аваад өмнө нь нөгөө яригдаж байсан 100 станц гэдэг шиг асуудал дахиж гарахгүй гэдгийг бас энэ дээр хэлье.

**Ц.Даваасүрэн:** Дамдинням гишүүн тодруулъя.

**Г.Дамдинням:** Яах вэ манай хууль дээр ч яах вэ байгаа л даа. Тэгээд гэрээ хэлэлцээрээрээ баталгаажуулаад авчихвал уг нь амар байгаад байгаа юм. Тэр агаарын хөлгийн хэлэлцээрийг та пакетны гэрээ л гээд танилцуулаад байгаа. Пакетны гэрээн дотроо 92, дизель хоёроо хамгаалах тухай бас юм оруулчих талаар ярилцвал зүгээр юм биш үү гэдэг саналыг хэлж байгаа юм. Нэг.

Хоёрдугаарт бас энэ дэлхий дахин чинь ингээд бас геополитикийн бужигнасан бие биеийгээ тарифаар ч, тэгээд бас хоригоор ч ингээд чангалсан

нөхцөл байдалтай байгаа байхгүй юу. Тэгэхээр хойд хөршөөс маань орж ирж байгаа энэ агаарын хөлгийн шатахуунаар гуравдагч хөршийн онгоцнуудыг үгүй ядаж л манай энхийг сахиулагчдыг тээвэрлэх онгоцыг цэнэглэх дээр хориг саад гэх юм байхгүй биз дээ тээ? Тэгээд энэ чинь бас юм болгоноос болгоомжтой хэдүүлээ тал талаас нь бодож хандахгүй бол бас хязгаарлалт ороод ирвэл бусад компаниудад бусад улсын агаарын тээвэрлэгчдийг цэнэглэхэд хориглох юм гарахгүй биз дээ гэдгийг тодруулаад өгчих.

**Ц.Даваасүрэн:** Тодруулъя, 5 номер Туваан сайд.

**Ц.Туваан:** Нэмж хариулъя. Энэ дээр энэ тийм энэ 2 ялгаатай 2 хэлэлцээр байгаа. Бусад нефть, тунгалаг Нефть бүтээгдэхүүний нийлүүлэлт ингээд эхний хэлэлцээрээр ингээд батлагдаад явна. Тэгэхээр одоо Оросын Холбооны Улсад ямар ч нөхцөл байдал үүссэн Монголын асуудал энд хамаарахгүй гэж ойлгож болно.

Манай зүгээс энэ дээр энэ Оросын талаас бас энийг байгуулж байгаагийн бас нэг асуудал дотор нь энэ одоо дэлхий дээр геополитикийн асуудал, дайн байлдаантай холбоотой асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар угаасаа манай импортлогч компаниуд баталгаа гаргаад явж байгаа. Өөрөөр хэлбэл, гуравдагч орны ямар нэгэн байдлаар цэргийн зориулалттай техникийг цэнэглэхгүй байх ийм баталгаагаа гаргаж өгөөд явж байгаа. Энэ дээр бас юу гэдэг юм байлдааны зориулалттай онгоц цэнэглээд явчихвал гэдэг ийм болгоомжлол байгаа. Тийм учраас энэ тал дээр хориг байгаа

**Ц.Даваасүрэн:** Г.Ганбаатар гишүүн асуултаа асууя.

**Г.Ганбаатар:** Би уг нь энэ аливаа ТӨК-ийг байгуулахыг, олноор байгуулахын ер нь эсрэг хүн. Ялангуяа төр хувийн хэвшилтэй өрсөлдөхийг ерөөсөө дэмждэггүй хүн л дээ. Гэхдээ ингээд мэдээлэл аваад хуучин Орос Монголын хамтарсан компани агаарын түлш нийлүүлдэг байсан юм шиг байна. Одоо ингээд шинэ компани орж ирлээ гэхэд агаарын түлш нийлүүлэх компани хуучин тэр хамтарч байсан компанийн сав суулга, байгууламж, хөрөнгө оруулалтаараа үлдэх үү? Тэр бай сав суулга байгууламж нь эсвэл хувийн хэвшилдээ үлдэх үү гэдэг нэг сонирхож байгаа асуулт байна.

Хоёр дахь зүйл нь саяхан бид нар бас түрүү долоо хоногт юм даа Говийн бүсээс сонгогдсон гишүүд газрын тосны үйлдвэр дээр ажиллаад ирсэн. Газрын тосны үйлдвэрийн үйл ажиллагаа бас харьцангуй гайгүй явж байна. Яах вэ тэнд цаашдаа тогтвортой нийлүүлэх түүхий эдийн асуудал байх шиг байна. Тэр “Доншен” компанийн баталгаат нөөц, Петровичайна компанийн баталгаат нөөцийн асуудал бас хэр удаан хугацаанд олборлолт, түүхий эдийн баталгаат нөөц нь хэр баталгаатай байх вэ гэдэг асуудал байгаа юм билээ.

Харин тэр талаасаа бодох юм бол та нөхдүүдийг агаарын түлш, ялангуяа энэ сүүлийн үед нь огцом өсөж байгаа хэрэглээг тогтвортой байнгын хэрэглэгчидтэй, байнгын нийлүүлэгч харилцагчтай байх гэдэг талаас нь би ойлгож байна. Хамгийн гол зүйл агаарын түлшний хэрэглээ огцом мөхсөн гэдэг ярьж байгаа болохоос яг хэдэн хувиар өссөн юм? Надад их тодорхой тоо хэрэгтэй.

Хоёрдугаарт энэ гэрээн дээр давуу эрхтэйгээр гэдэг нь яг юугаа тодотгож хэлж байгаа юм? Давуу эрхтэйгээр гээд. Дээрээс нь борлуулах бүтээгдэхүүнийхээ

арай 40 хувьдаа энэ борлуулах бүтээгдэхүүнээр арай компанийн хувьд нээрээ эзэмшихсэн юм биш биз дээ? Энэ чинь сая би Алтанхуяг даргын ярианаас тэгж ойлголоо. Энэ чинь тэгж болохгүй шүү дээ. Тэгээд энэ дээр эхлээд тодорхой асуултууд хариулт аваадахъя даа.

**Ц.Даваасүрэн:** 5 номер Туваан сайд хариулъя.

**Ц.Туваан:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Газрын тос боловсруулах үйлдвэр 28 оны эхний улиралд гээд ингээд явж байгаа. Сая бас манай Улсын Их Хурлын 12 гишүүн очиж газар дээр нь нөхцөл байдалтай танилцсан. Түүхий тосны нийлүүлэлтээс бусад асуудал дээр нэлээн гайгүй явж байна гэсэн ийм мэдээлэлтэй байгаа. Түүхий тосны нийлүүлэлт тал дээр бид нар яг өнөөдрийн байдлаар “Петро чайна дачин тамсаг” компанийн ашиглалтын баталгаат нөөц 31 сая тонн, “Доншен” компанийн ашиглалтын баталгаат нөөц 26 сая тонн байгаа.

Тэгээд бид нар эндээс дотоодынхоо 1.5 сая тонн жилийн хэрэгцээгээ хангачихна гэсэн ийм зүйл дээр ажиллаад явж байгаа. Яагаад бас энийг хэлэх нэг баталгаа нь 2013-аас 14 оны үед манай олборлож байгаа энэ “Петро чайна дачин тамсаг” гэхэд 1.1 сая тонн түүхий тосыг олборлож байсан. Тэгэхээр бид нар үлдсэн хугацаандаа хуучин түвшиндээ хүрэх гэдэг ийм зорилго тавиад, дээрээс нь нэмэгдэж орж ирсэн “Доншен” мэтийн компаниуд бас ингээд нэмэлт олборлолтоо нэмэгдээд ирэхээр 1.5 саядаа хүрнэ гэсэн ийм зорилттой явж байгаа.

Агаарын хөлгийн түлшний хэрэглээ огцом өсөж байгаа. Энэ дээр 2021 онд 27879 тонн, 22 онд 38492 тонн, 23 онд 61719 тонн, 24 онд 69984 тонн гээд яг 21 оноос энэ 24 оны хугацаанд 3 дахин нэмэгдчихсэн явж байгаа. Цаашдаа ч энэ нэмэгдэлт нэлээн огцом байдлаар нэмэгдэнэ. Энэ дээр түрүүний гишүүдийн асуусан асуулт дээр түрүүний нөгөө байгуулсан санамж бичгийн хүрээнд Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орж, агаарын хөлгийн түлш үйлдвэрлэж эхэлсний дараа нисэх буудалд нэн тэргүүнд боловсруулах үйлдвэрээс нийлүүлэлт хийгдэх бөгөөд хамтарсан компанийн үлдсэн хэрэгцээний 75 хувийг хамтарсан компаниас байгуулна гэсэн ийм тодорхой бас санамж бичгийн заалттай явж байгаа гэдгийг хэлье.

**Ц.Даваасүрэн:** Тодруулах юм уу Ганбаатар гишүүн, болчихсон уу? Ингээд гишүүд асуулт асууж дууслаа.

Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүн байна уу?

2 гишүүн байна, 3 гишүүн байна. Ганбаатар гишүүнээр тасалъя. Батжаргал гишүүн үгээ хэлье.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Санамж, Засгийн газрын хэлэлцээр хоёрынхоо заалтуудын агуулгыг нэг болгочихмоор байна. Яах аргагүй сая тэр 4.3 дээр Оросын талын итгэмжлэгдсэн компани нь 100 хувь хангах гээд байгаа энэ зүйлээ тэр үйлдвэр ашиглалтад орон оронгуут тэрнийхээ бүтээгдэхүүнээр хангана гэдэг үгээ оруулчих. Энэ бидэнд нэн хэрэгтэй байна.

Хоёр дахь зүйл бид энэ 4.1 дээр тэр дэд бүтэц бүх юмыг хамтарсан компани ашиглахаар орсон юм. Тэгэнгүүт ард нь аваачаад энэ цогцолбор буюу дэд бүтцийг ашиглах тусгай зөвшөөрөл баримт бичгүүдийг итгэмжлэгдсэн компанид өгөхөөр

орчхоод байгаа байхгүй юу. Тэр болохгүй. Хамтарсан компани дээрээ л гарна. Энэ лиценз бүх юмнууд. Тийм учраас энийг засах ёстой. Бид яалаа гэж хамтарсан компани байгуулж үйл ажиллагаа явуулж байж Оросын талын итгэмжлэгдсэн компанид нь бүх зөвшөөрөл юмаа өгөх юм бэ? Ингэж энэ болохгүй. Үүнийг энэ Засгийн газрын хэлцлээс арилгах ёстой гэж.

Дараагийн нэг зүйл тэр Оросын талын итгэмжлэгдсэн компанийн хийгдэх гээд байгаа 40 хувийн хөрөнгө оруулалтыг их тодорхой болгож заагаарай. Энэ болохгүй шүү. Би бол нэлээн тийм асуудал энд л байгаад байгаа юм байна. Энэ чинь нийлүүлэлтийн хэлэлцээр гэхээсээ илүүтэйгээр магад ч үгүй хөрөнгө оруулалтын Засгийн газар хоорондын хэлэлцээр шиг юм болчхоод байгаа байхгүй юу яг агуулга талаас нь уншиж үзэх юм бол. Тэгээд үүнийгээ анхаараадхаач гэж ийм саналыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо руу, Төсвийн байнгын хорооноос явуулах дүгнэлтдээ оруулж өгөөч гэж би Байнгын хорооны даргаас хүсэж байна. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Алтанхуяг гишүүн үг хэлье.

**Н.Алтанхуяг:** Би саналаа өгч чадахаа больчхоод л үг хэлье гэсэн л дээ. Саяын сая зөрчилт байдлууд нэг тийшээгээ шийдэгдээд зөв болоод явна гэвэл дэмжиж өгмөөр байдаг. Бантан бол эсэргүүцмээр байдаг. Юу гэж өгөх вэ би? Энэ Туваан сайдын хэлж байгааг харахаар л ийм өөх ч биш булчирхай ч биш юм яриад л хойноосоо Эм Өү Юу яриад унах юм. Эм Өү Юу гэдэг чинь бол гэрээний хажууд хамаагүй тийм сул хүч, хүч муутай эд байхгүй юу. Тэгэхээр та нар жаахан юмаа сайн үзмээр л юм шиг санагдах юм. Тэр нь одоо ч нохой долоож. Би энэ саналаа өгч чадахаа больчхоод ингэж хэлж байгаа юм. Яах ёстой юм бэ та нар? Энэ бид нар ингээд л ийм та нар юмаа дутуу оруулж ирээд л бид нар энд нэг нэгнээ харж жаахан гайхаж байснаа жоохон шүүмжилж байгаад л тэгээд л кнопдоод л ийм байдалтай яваад баймааргүй л надад санагдаад.

Ялангуяа энэ асуудал дээр. Уг нь энэ ОХУ-тайгаа тодорхой хугацаанд тэр компаниудтай нь хамтраад найдвартай хангалт хийчихдэг бол окэй. Би бол дэмжмээр байна. Тэгтэл нөгөө газрын тосны чинь үйлдвэрээс гарсан юм нь яах гэж байгаа юм бүү мэд болоод, үйлчлэх хугацаа нь урт болоод л, тэгээд 40 хувь нь нөгөө компанийн мэдэл, нөгөө талын мэдэл гээд л ингээд л ойлгомжгүй байна шүү дээ. Саналаа өгч чаддаггүй. Тувааны микрофонгүй надад хэлээрэй ямар санал өгөхийг?

**Ц.Даваасүрэн:** Ганбаатар гишүүн үг хэлье.

**Г.Ганбаатар:** Миний хэлэх гэж байгаа зүйл бол аливаа хэлцэл ч бай, гэрээ ч бай 2 талын хүсэл зориг байдаг. Тийм учраас бид бас энэ тэр гэрээ, хэлцэл дээрээ ялангуяа энэ агаарын түлшний энэ чинь зөвхөн агаарын түлш нийлүүлэх л гэрээ шүү дээ. Санал бодлоо сайн тусгаарай. Ялангуяа энэ Төсвийн байнгын хороон дээр гарч байгаа. Би хэлэх гэж байсан саналыг манай Батжаргал гишүүн сая их тодорхой хэлчхэж байгаа байхгүй юу. Яг тэр дүгнэлтэд тэгж орох ёстой, бид ийм маягаар явахгүй бол аль нэг байдлаар урт удаан хугацаанд тогтвортой түлш нийлүүлнэ гэдэг нь сайн боловч нөгөө талдаа бид бас энэ улс орныхоо, ялангуяа асар их хөрөнгө оруулалтаар байгуулж байгаа тэр газрын тосныхоо үйлдвэрийн эрх ашгийг, дээрээс нь энэ бас улс орны эрх ашиг гэж юм байна биз дээ тэгээд тэрийгээ сайн тусгаарай л гэж хэлэх байна даа.

**Ц.Даваасүрэн:** Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Санал хураана. Туваан сайд энэ гишүүдийн хэлээд байгаа саналыг би хурлын протокол, Аюулгүй байдал, байнгын хороо руу явах дүгнэлтэд бүгдийг нь тусгаад явуулна. Тэгээд та нар хэлэлцээр байгуулахдаа энэ гишүүдийн саналын гол тэр юмнуудыг тусгах хэрэгтэй. Энэ Ерөнхийлөгчийн айлчлалын үед зурагдах гээд байгаа би тэгж ойлгоод байна тийм үү энэ гэрээ? Тэгэхээр энэ гэрээний асуудал дээр бид нар бас тэр хэлсэн гишүүдийн яриад байгаа санал, дүгнэлтийг анхаараарай гэдгийг бас дүгнэлтдээ оруулна шүү.

Ингээд Монгол Улс болон Евразийн засгийн биш өөр юм унших гэж байна. Аль нь вэ? Буцаагаад явуулах гэж байна шүү.

Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг зөвшилцөхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Би дэмжсэн. 19 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 52.6 хувиар дэмжигдлээ.

Би дэмжсэн. Чойжилсүрэн гишүүн дэмжсэн. Алтанхуяг гишүүн дэмжсэн. Ганбаатар гишүүн дэмжсэнээр протоколд авъя. Г.Ганбаатар шүү.

Ингээд хоёр дахь асуудлыг Гадаад байдал, аюулгүй байдлын байнгын хороонд санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн танилцуулна.

Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газрын хорооны хэлэлцээрийн зөвшилцөх асуудлыг хэлэлцэж дууслаа.

13.09 цаг

**Гурав дахь асуудал. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж эхэлье.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115.2.18-д хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийн талаарх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланг Төсвийн байнгын хороо жил бүр хэлэлцэнэ гэж ингэж зохицуулагдсан байгаа.

Чуулганы дэгийн тухай хуулийн энэ заалтын дагуу 24 оны Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааны тайланд хийсэн дүн шинжилгээг та бүхэнд тараасан байгаа.

Ажлын хэсэгт Тогтвортой байдлын зөвлөлийнхөн орж ирсэн байгаа. Би Тогтвортой байдлын зөвлөлийнхнийг та бүхэнд танилцуулаадахъя. Тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, Тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Р.Рэнцэнбазар Тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, тус зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар гэсэн хүмүүс оролцож байна.

Тогтвортой байдлын зөвлөлийн 24 оны үйл ажиллагааны тайланг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Намжилдоржийн Энхбаяр товч танилцуулна.

Энхбаяр 5 номерын микрофон.

**Н.Энхбаяр:** Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг та бүхэнд урьдчилан хүргүүлсэн учраас би товчхон танилцуулъя гэж бодож байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл орон тооны 7 гишүүнтэйгээр 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн Улсын Их Хурлын 4 дүгээр тогтоолоор томилогдон ажиллаж байна.

Төсвийн тогтвортой байдлын хууль болон Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулахад ашиглах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, нөхцөл байдлын таамаглалыг боловсруулах, Улсын Их Хурал, Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл, Төсвийн тодотголын төсөл, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл, Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн тайлан, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан хуульд нийцсэн эсэх, төсөв санхүүгийн тогтвортой байдлыг хангасан эсэх талаар болон улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, ачааллын талаар судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах гэсэн ийм үүргүүдийг хүлээсэн байгаа.

Төсвийн тухай хуульд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ дагуу өнгөрсөн онд хийж гүйцэтгэсэн ажлууд тэдгээрийн үр дүнг нэгтгэн гаргаж тайлангаа Улсын Их Хуралд хүргүүлсэн.

Тайлангийн үндсэн үйл ажиллагаа гэсэн хэсэгт Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь хууль тогтоомжоор хүлээсэн үндсэн чиг үүрэг, зөвлөлийн дүрэм, гүйцэтгэсэн ажлын тайлан, төсвийн баримт бичгүүд, хуулийн төслүүдэд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн талаар товч тусгасан. Улсын Их Хурлын цахим хуудсанд эдгээр тайлангуудыг байршуулж, холбоосыг оруулсан байгаа.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн эдгээр дүгнэлтүүддээ Монгол Улсад төсвийн төлөвлөлт мөчлөг дагасан эрсдэлийг нэмэгдүүлэх бодлого хэвээр хадгалагдсаар байгаа нь эдийн засгийн хөгжлийг дэмжих, төсвийн тогтвортой байдлыг хангах эрсдэлийг бууруулах бодлогын зорилт хэрэгжихгүй байгаа, хүрэх магадлалтай.

Түүнчлэн макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг хэт өөдрөг төсөөлж, мөн төсвийн орлого, зарлага, алдагдлыг өсгөн төлөвлөх боломжийг бүрдүүлж байна. Эдийн засаг дахь төрийн оролцоо нэмэгдэж байгаа нь хувийн хэвшлийн орон зай эдийн засгийн суурийг тэлэх боломжийг хязгаарлахын зэрэгцээ төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиггүй бодлого үргэлжлэх хандлагатай байгааг анхааруулсан.

Зөвлөл нь эдийн засгийн гадаад, дотоод эрсдэл, бодит нөхцөл байдлыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд харгалзан үзэх шаардлагатай. Төсвийн орлого нэмэгдэж байгаа үед хуримтлал үүсгэх, эрсдэлийг бууруулах бодлого баримтлах шаардлагатай. Төсвийн орлогын өөдрөг төсөөлөлд найдаж

төсвийг хэт тэлэх бодлогыг үргэлжлүүлж байгаад эргэн харах шаардлагатай. Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах орлого өндөр байгаа жилүүдэд хуримтлал үүсгэх, мөчлөг сөрсөн бодлого баримтлах шаардлагатай гэж үзэж, ДНБ төсвийн зарлагын эзлэхүүн өнөөгийн байгаа 25-аас бууруулаад 25-аас 28 хувьд хүргэх, эрдсийн түүхий эдийн экспортод хэт дулдуйдсан бодлогыг хэрэгжүүлэх нь цаашдаа эдийн засгийн төрөлжилт бий болгохыг хязгаарлаж байгаа төдийгүй эдийн засагт учрах эрсдэлийг нэмэгдүүлж байгааг анхааруулсан.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийг алдагдалгүй байхаар баталсан ч энэ оны байдлаар төсвийн тэнцвэржүүлсэн орлого төлөвлөж байснаас төвлөрөхгүй тохиолдолд нийт тэнцлийн алдагдал бий болох магадлалтай эдийн засгийн мөчлөг дагасан бодлого хэвээр хадгалагдаж байгаа тул цаашид мөчлөг сөрсөн бодлогыг бодитой суурийг тавих шаардлагатай гэж үзсэн.

Өнөөдөр Үндэсний статистикийн хороо энэ 2025 оны 1 дүгээр улирлын тоо мэдээллийг танилцуулж байна. Эндээс харахад энэ оны 1 дүгээр улиралд Монгол Улсын төсвийн орлого 6 их наяд 432 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн. Төсвийн орлогын төлөвлөгөө 1.2 их наяд төгрөгөөр тасарсан, 16.2 хувиар тасарсан ийм гүйцэтгэлтэй гарч байна.

Үүний улмаас төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн 353 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байгаа. Эдгээр тоон мэдээлэл нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өнгөрсөн жилийн хугацаанд өгч байсан дүгнэлт, зөвлөмжүүд илүү бодитой байсныг илтгэн харуулж байна

Улсын Их Хурал, Засгийн газар, бусад төрийн захиргааны төв байгууллага, олон улсын байгууллагуудтай хэрхэн хамтарсан талаар товчхон танилцуулъя.

Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Удирдлагын академийн холбогдох албан тушаалтнууд Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банк, НҮБ, Жайка зэрэг эдгээр бүх байгууллагуудтай бид өнгөрсөн хугацаанд уулзаж үйл ажиллагаагаа уялдуулах талаар хамтран ажиллаж байна.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас зохион байгуулсан Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, хэлэлцүүлэгт бид оролцож, бас тодорхой байр сууриа илэрхийлсэн. Улсын Их Хурлын дарга Төсвийн байнгын хорооны дарга Улсын Их Хурлын зарим гишүүдтэй бас уулзалт хийж энэ зөвлөхийн үйл ажиллагааны талаар бид танилцуулсан. 25 оны төсөлд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн талаар бас мөн танилцуулсан.

Өнгөрсөн онд Улсын Их Хурлаас зохион байгуулагдсан Төсөв, төсвийн хүрээний мэдэгдлийн хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын чуулган, Байнгын хороо, Зарлагын дэд хорооны хуралдаанд оролцож бид санал, дүгнэлтээ танилцуулсан.

Үүнээс гадна бид хэвлэл мэдээлэл хууль дээр хүлээсэн үүргийн дагуу хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцан ажиллаж байгаа. Зөвлөлөөс 2024 онд нийт 4 удаа хэвлэлийн бага хурал зарлаж, хурал тус бүрд хэвлэл мэдээллийн дунд сая 10-14 байгууллага оролцсон. Ингээд зөвлөлийн гишүүд давхардсан тоогоор хэвлэл мэдээллийн хэрэгсэл 34 удаа ярилцлага өгч, мэдээлсэн байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Нээлттэй нийгэм форумтай хамтран 25 онд энэ талаар бас олон нийтийн хэлэлцэн зохион байгуулсан. Мөн Үндэсний аудитын газартай хамтраад 25 оны төсвийн төсөлд хийсэн дүгнэлтийнхээ талаар хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн дүгнэлт, зөвлөмжөө парламентын веб хуудсанд байршуулсан байгаа учраас энэ веб хуудсанд минь нийтэлсэн мэдээллийг нийт давхардсан тоогоор 20.4 мянган хүн үзэж танилцсан байна.

Судалгаа, шинжилгээний ажлын тухайд хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд зөвлөлийн гишүүд эдийн засгийн гадаад, дотоод орчны нөхцөл байдалд үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох зорилгоор нийтдээ 11 судалгааны ажлыг бид дотооддоо хийж гүйцэтгээд байна.

Мөн зөвлөлийн гишүүдийн эрдэм шинжилгээний хуралд 3 удаа илтгэл тавьж, нийт 8 илтгэл танилцуулсан.

Зөвлөлийн дотоод ажлын хүрээнд Улсын Их Хурлын бэлгэ тэмдгийн загвар, 24 оны ажлын төлөвлөгөөг боловсруулж хурлаар хэлэлцэн баталсан.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь ирэх 24-28 онд баримтлан ажиллах стратегийн бичиг баримтаа боловсруулаад Зөвлөлийн дотоод хурлаараа батлаад хэрэгжүүлээд ажиллаж байна.

Зөвлөл нь 24 оны 1 сараас хойш байнгын орон тооны 7 гишүүнтэйгээр ажиллаж байгаа. Тэгээд хуулиар хуулиас нь чиг үүргээ хэрэгжүүлээд дараах үр дүнд хүрсэн гэж үзэж байна. Үүнд:

Төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн эрсдэлээс сэргийлэх, төсвийн ил тод байдлыг сайжруулах чиглэлд идэвхтэй ажиллаж нийт 12 удаагийн тайлангаар 96 дүгнэлт гаргаж, 35 зөвлөмж өгч, холбогдох дээд Их Хурал, Засгийн газрын холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаан, Төсвийн байнгын хороо, Зарлагын хяналтын дэд хороо, холбогдох ажлын хэсгүүд, намын бүлгийн хурлаар энэ дүгнэлт, зөвлөмжийг хэлэлцүүлэх явцад гишүүдийн асуултад хариулж, танилцуулга хийсэн.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тусгагдсан төсвийн тусгай шаардлагад Засгийн газрын саналын дагуу Улсын Их Хурал зарим өөрчлөлтийг оруулсан хэдий ч Засгийн газар Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс төсөвт бүхэлд нь хориг тавьсны дараа өнгөрсөн оны 12 сард Улсын Их Хурлаас төсвийг алдагдалгүй байхаар өргөн барьж баталсан нь чухал бололтой гэж бид үзэж байна.

Төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахад ашиглахдаа бид макро эдийн засгийн олон талын загвар ашиглаж байна. Одоогоор бид Дигнар/Dignare/ болон Кайм/KEIM/ гэсэн загваруудыг ашиглаад дунд хугацааны төсөөллийг боловсруулж байгаа. Зөвлөлөөс 24 оны 3 дугаар сард ирэх 3 жилд баримтлах макро эдийн засгийн төсөөллийг боловсруулж гаргасан. Үүнд 24 оны эдийн засгийн өсөлтийн, бодит өсөлтийн дээд болон доод түвшнээр тод тодорхойлсон ийм төсөөллийн дундаж үзүүлэлтийг танилцуулсан. 24 оны гүйцэтгэлтэй нэлээн ойролцоо гарсан байна. Зүйлээс макро эдийн засгийн таамаглал боловсруулах чадавхыг

бэхжүүлэхэд олон улсын байгууллагуудаас ихээхэн дэмжлэг туслалцаа үзүүлж байгаад талархаж байгаа.

Ингээд 25 онд бид дэвшүүлэн ажиллаж байгаа зорилтоо товчхон танилцуулъя.

Хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл болон Засгийн газраас боловсруулсан жилийн төлөвлөгөө, төслийн төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэл нь төсвийн тусгай шаардлагыг хангасан эсэхэд бид дүн шинжилгээ хийнэ. Дүгнэлт өгөх шаардлага гарч байгаа. Энийгээ илүү сайн оновчтой боловсруулах чиглэлд илүү анхааран ажиллаж байна.

Зөвлөл нь одоогоор орон тооны томилогдсон 7 гишүүнтэй, Улсын Их Хурлын тамгын газраас 2 ажилтантай туслах ажилтантай ингээд ажиллаж байгаа. Хуулийн дагуу бид цаашдаа 7 судлаач ажилтан авах ёстой. Эдгээр судлаач ажилтнаа энэ онд авч, судалгаа шинжилгээндээ илүү түлхүү, бүрэн бүрэлдэхүүнээр ажиллах ийм зорилготой ажиллаж байна.

Төсвийн тогтвортой байдлын зүйлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, төсвийн сахилга бат, ил тод, үр нөлөөтэй байдлыг хангах үүднээс хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд танин мэдүүлэх ажиллагаагаа цаашид үргэлжлүүлнэ. Өөрийн гэсэн домэйн веб хуудастай байх ажлаа эхлээд тодорхой зөвшөөрлүүдийг аваад явж байгаа. Мөн нийгмийн сошиал сүлжээгээр дамжуулаад олон нийт...

**Ц.Даваасүрэн:** Гол гол юмаа л.

**Н.Энхбаяр:** ..мэдээлэл түгээж байгаа. Засгийн газраас байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг тухай бүрд нь бид цуглуулан авах талаар мэдээллийн сан бүрдүүлэхэд илүү анхаарах ийм зорилготой ажиллаж байна.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Энхбаяр даргад баярлалаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 24 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулгатай холбогдуулаад асуулт асуух гишүүн байна уу?

Батжаргал гишүүнээр тасалъя. Батсүмбэрэл гишүүн, Батжаргал гишүүн асуултаа асууя.

**Ж.Батжаргал:** Төсвийн тогтвортой байдлын тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулаад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөө орон тооны байхаар бас ажиллах чиг юмнуудыг нь их тодорхой болгоод хуульчилж өгсөн. Энэ дагуу манай зөвлөл байгуулагдсан. Би зөвлөлийг харьцангуй боломжтой ажиллаж байна гэж ингэж харж байгаа. Бид илүү сайн ажиллах ёстой.

Төсвийн орлогын төвлөрөлт ахиу байгааг дагаад төсвийн зардлын тэлэлт яваад байгаа тухай хэдүүлээ их олон жил ярьж байгаа улсууд. Нэг.

Хоёрдугаарт том төр үрэлгэн төсвийн тухай их ярьж байгаа улсууд, одоо бидний гол анхаарал хандуулах ёстой зүйл энд байгаа л гэж би хараад байгаа. Энэ том төрийг ер нь яаж зохистой төр болгох вэ? Бүтцийн ямар өөрчлөлтүүд хийх

ёстой вэ? Тэгж байж тэнд дан дамаа урсгал төсөв талаа бид онцгой анхаарах ёстой юм. Урсгал төсвөө бид тодорхой түвшинд нь, зохистой түвшинд нь барьж хязгаарлаж чадах юм бол хөгжлийнхөө зүйл рүү жоохон хөрөнгө ахиу гаргах бололцоо бүрдэнэ, орон зай гарах ёстой. Энэ тал руу манай Тогтвортой байдлын зөвлөл ямархуу судалгаа, шинжилгээнүүд хийж байна вэ? Энэ талаар би тодорхой мэдээлэл авчихмаар байна. Нэг.

Хоёр дахь зүйл. Энэ төсвийн тусгай шаардлагууд, тусгай шаардлагуудыг тогтвортой мөрдөх замаар эдийн засаг, нийгэм, төсвийн үндсэн үзүүлэлтүүдээ хангаж явах тухай асуудал гол байгаад байгаа л даа бидний. Тэгэхээр эндээс харахаар зэрэг хөгжил рүүгээ чиглэсэн хөрөнгө оруулалтаа бас тодорхой түвшинд хязгаарлаад байгаа энэ эрх зүйн зохицуулалтууд байна уу гэж би хараад байгаа юм. Үүнийг ер нь яаж зохистой болговол зөв байх вэ гэдэг нэг зүйл.

Дараагийн нэг зүйл чөлөөт үлдэгдлүүд байна. Жишээ нь би НДШ-ийн 2 хувийг мөнгөжүүлж байгаа, хэдийгээр хүн болгоны нэр дээр нэрийн дансанд харагдах боловч нэгдсэн дүнгээрээ энэ сан дээрээ төвлөрч явж байгаа. Дээр нь энэ Баялгийн сангийн тэр хуримтлалын сан эд нар чинь яг ийм байдлаар тодорхой хэмжээний эх үүсвэрийн чөлөөт үлдэгдэл харагдаад байгаа. Үүнийг яаж энэ эдийн засгийн идэвхжил рүү татаж оруулах вэ? Үүнд биднүүс ер нь ямархуу байдлаар хандсан эрх зүйн орчин бүрдүүлэх ёстой вэ? Одоо бид болохоор зэрэг л учиргүй менежментийн компаниар дамжуулаад л баталгаат өгөөж хүртдэг болгоно л гэж яриад байгаа болохоос биш тэгж чадалгүй 3 жил явчихлаа бараг. Одоо үүнийгээ анхаарах энэ бололцоо, боломжоо энэ рүүгээ дайчлах талын юмыг би.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Энхбаяр дарга 5 номерын микрофон.

**Н.Энхбаяр:** Батжаргал гишүүний асуултад хариулъя. Хариулт маань хугацаатай байх, хугацаатай учраас би болохоор асуултад товч хариулахыг хичээе.

Үнэхээр Монгол Улсын 20 онд баталсан Алсын хараа-2050 болон дунд хугацааны бичиг баримтуудад төсвийн илүү оновчтой бодлого төлөвлөх, эдийн засгаа төрөлжүүлэх, төсвийн хэт тэлэлтгүй байх, мөчлөг дагасан сэргэсэн бодлоготой байх гэсэн ийм зорилтууд байгаа. Харамсалтай нь бид нөгөө 20 оны хавар баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай илүү сайн эргэж харж байх ёстой юм шиг байгаа юм. Энэ хуулиар бид Монгол Улс 5 жилийн төлөвлөгөөтэй болсон. 20 оны хавар Улсын Их Хурлаас 5 жилийн төлөвлөгөө баталсан. Тэгэхээр бусад баталж байгаа Улсын Их Хурлаас баталж байгаа бичиг баримттай бид яг энэ нөгөө Алсын хараа болон дунд хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримтуудтай нягт уялдуулах ёстой юм болов уу гэж үзэж байгаа.

Өнгөрсөн онд Улсын Их Хуралд сонгуульд оролцсон улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрт ч гэсэн бүгдээрээ төсвийн зарлагын тэлэлтийг багасгана, төсвийн алдагдлыг бууруулна гэсэн эдгээр зорилтууд байсан. Тэгэхээр энэ төсвийн тухай хууль болон Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан бодлогын бичиг баримтуудын хоорондын уялдааг хангах гэдэг асуудалд их чухал анхаарах ёстой юм болов уу гэж бодож байгаа. Энэ тал дээр Хууль тогтоомжийн тухай хуулийн тодорхой заалтаар ч гэсэн манай Их Хурлын гишүүд сайн анхаарч үзэх ёстой юм болов уу гэж бодож байгаа.

Тухайлбал, Төсвийн тухай хууль бүхэлдээ бүхий л хуулиуд маань төсвийн хүрээний мэдэгдэл, бүх хуулиуд маань Хууль тогтоомжийн тухай хуульд хамрахгүйгээр орж ирж байгаа учраас бас энэ бичиг баримтуудын бодлогын хуйвалдааны тал дээр сул тал байна уу гэж үзэж байна.

Гишүүний асуусан нөгөө хөрөнгө оруулалтын чухал төслүүдээ хэрхэн сонгох вэ? Энийг яаж оновчтой зөв хөрөнгө оруулалтаар яах вэ гэдэг дээр цаг бага байгаа учраас би ганцхан зүйл хэлье. Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлээр бид улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төлөвлөлтийг зохицуулж байна 28 дугаар зүйлд. 28 дугаар зүйлийн 3-д төслөө бид нар хэрхэн сонгох вэ, юуг харгалзаж үзэх вэ гээд ингээд 12 зүйлийг заасан байна. Энэ дотор төслийг сонгохдоо эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцож үзнэ гээд ингээд 2 заалт хэлчихсэн байгаа юм. Энэ нь яг эдийн засгийн агуулгаар нөгөө ретрион оф инвестмент/return of investment/ нөгөөдөх нь кост бенефит анализ/cost benefit analysis/ гэсэн үг. Тэгэхээр хоёрхон аргачлалаар төслийн ач холбогдлыг сонгоно гэдэг хангалтгүй.

Тэгэхээр чухам яаж сонгох вэ гэдэг дээр цаашдаа илүү нарийн анхаарах ёстой байх. Энэ дээр Сангийн яаман дээр боловсруулагдаж байгаа Улсын хөрөнгө оруулалтын хуулиар анхан шатаас нь эхлээд төслийг сонгохдоо яг чухам аль төсөл хөтөлбөр маань аль илүү улс орны эдийн засагт илүү үр өгөөжтэй байх вэ гэдгийг сонгох энэ аргачлалуудаа бас маш тодорхой болгох ёстой юм болов уу гэж бодож байгаа юм. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Батжаргал гишүүн тодруулъя тодруулъя.

**Ж.Батжаргал:** Үгүй үгүй хэдүүлээ одоо юу яамаар байна л даа. Зохистой бүтцийн тухай, тэрийг дагасан зардлын тухай ойлголт байхгүй юу. Түүн дээр та хэд маань ямархуу байдлаар тэмтрэх юм бэ? Энэ юмаа тодорхой болгож ажиллаач. Ингэвэл бид хэдэд жоохон боломж гарах юм л гэж би энэ талаас нь хараад байгаа юм гэж.

Та хэдийн маань дараагийн том чиг үүрэг бол энэ төсвийн хүрээний мэдэгдлээс өмнө улс орны эдийн засаг, нийгмийн төсөөллийг гаргаж танилцуулах ёстой. Тэгэхээр би юу гэж хэлэх гэж байна гэхээр энэ намар, хаврын чуулганы хугацаанд дан дамаа энэ мэргэжлийн Байнгын хороо гээд байгаа Төсвийн байнгын хорооныхоо гишүүдэд 2 удаа ч юм уу мэдээллээр хангадаг, мэдлэг олгодог чиглэлийн юм хийхгүй бол та хэдийн бодоод байгаа юм энд орж ирээд анзаарагдахгүй гэдэг юм уу, авагдахгүй өнгөрчхөөд болж өгөхгүй юм. Хамтарч энэ улс орны эдийн засаг, нийгмийг урагш нь явуулъя, төсвийн зохистой.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Хариулъя 5 номер, Энхбаяр дарга. 4 хариулах юм уу?

**Н.Энхбаяр:** Гишүүний саяын хэлсэн саналтай санал нэг байна. Бид цаашдаа энэ ажлаа зохион байгуулъя гэж бодож байна.

**Ц.Даваасүрэн:** 4 номер нэмчихье.

**Ж.Дэлгэрсайхан:** Гишүүний асуултад зарим тодруулгыг өгье. Түрүүн хэлсэн яг энэ төсвийн урсгал зардлын хүсэлт...

**Ц.Даваасүрэн:** Нэрээ хэлээрэй.

**Ж.Дэлгэрсайхан:** ....Дэлгэрсайхан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн уучлаарай. Бид нар яг түрүүний даргын хэлсэн, Энхбаяр даргын хэлсэн дотор бид нар яг энэ төсвийн тэлэлтийн хувьд урсгал зардлыг тодорхой хувиар бууруулах, төсвийн нийт зардлыг 30-аас доош хувьд хүргэх чиглэлийг барих нь зүйтэй гэж үзэж байгаа.

Хоёрдугаарт нь төсвийн тогтвортой байдлын тусгай шаардлагуудыг бид нар өөрчлөхийн эсрэг байр суурьтай байсан бөгөөд өмнөх тусгай шаардлагыг нь хэрэгжүүлээд явах нь зүйтэй гэж үзэж байгаа. Үүнээс гадна бид нарын хувьд энэ Баялгийн сан дээр гол өгөөд байгаа бид нарын тайландаа өгсөн зөвлөмж бол яг өнөөдрийн байдлаар 3 санг хуваагаад, дээрээс нь тэр яамнууд тэр Баялгийн санг удирдах, одоогийн Баялгийн сангийн хуулийн зохицуулалт нь хараахан дутагдалтай зохицуулалт юм байна. Тийм учраас энэхүү Баялгийн сангийн.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Алтанхуяг гишүүн асуултаа асууя.

**Н.Алтанхуяг:** Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг ингээд орон тооны болгоод ажиллуулаад тэгээд манай энэ хэд маань бас их бид нар анхаараад, Засгийн газар нь анхаараад, Улсын Их Хурлын гишүүд нь анхаараад бас харилцан ярилцаад шийдэж чаддаг бол их чухал чухал ийм саналууд гаргасан л даа. Тэгэхээр би бол баярлаад байгаа юм. Одоо ганцхан юманд гомдоод байгаа юм.

Тэр нь эд нарын гаргасан саналыг нохой хуцсанд ч тооцохгүй болчихсон. Тэгэхээр харин би ганцхан асуулт асууна. Тэнд товчхон хариулчих. Хуулиараа Засгийн газар чинь та нарын төсөөлөл, Засгийн газрын гаргасан төсвийн төсөөллийн хоорондын том зөрүү гарсан тохиолдолд Засгийн газар ямар нэгэн тайлбарлах, дагана ч гэж байхгүй л дээ. Тэр хэцүү байх. Тайлбарлах, бичгээр тайлбарлах, эсвэл ямар нэгэн тийм харилцаа байна уу хууль дээр та нарын хийх ёстой? Тэрийг надад хариулаад өгчих.

Ер нь юу гэж бодож байгаа вэ гэхээр гишүүд ээ энэ маш их чухал. Энд бас мэргэжлийн хүмүүс цуглачихсан. Одоо уг нь Ерөнхий сайд бол бараг албан бусаар та нарыг аваад сонсвол гэлээ Монгол Улсад их хэрэгтэй юм гарна. Төсвийг та нарын хэлснээр бүтэн өөрчилдөггүй юм гэхэд зөвхөн дураараа дургидаг ганц Сангийн сайдын тэр алдаа оноог бол засах, залруулах асар их боломжууд харагдаад байгаа юм л даа. Тэгээд энийг Энхбаяр дарга та нар ингээд эрх зүйн хувьд бас сая хэлчихлээ шүү дээ Хууль тогтоомжийн хуультай яана, Төсвийн хуульд тустай болчихоод болдоггүй ч гэнэ үү энэ дээр та нар бас санал боловсруулаад манай юу билээ энэ чинь манай Төсвийн байнгын хорооны гишүүдэд хуудас цаас өгвөл бид нар чинь бас яахаа мэдэхээ байчихаад байна л даа. Харин Ерөнхийлөгчийн хориг тавихаар арга байхгүй хуулийн хүрээндээ хүлээж аваад тэгээд сая та нарын хэлсний дагуу үндсэндээ Ерөнхийлөгчийн хоригийн дагуу хориг гэдэг юм чинь яаж засахыг нь эд нар хэлчихсэн байхгүй юу. Тэр дагуу ингээд засагдсан учраас саяын төсөв арай гайгүй.

Орлого чинь биелэх юм уу гээд л та нарыг орилж байх хооронд чинь орлого чинь тасраад л явчихсан байхгүй юу. Тэгэхээр энэ дээр Засгийн газар л жаахан тийм лидершип манлайлал хийх л ёстой юм шиг байна гэж би харсан. Би уг нь

Ерөнхий сайдад ч хэлсэн юм. Та нарыг хүлээж авч уулзаад сонсчхож болдоггүй юм уу гээд. Энийг ганц Сангийн сайдын дураар дургидаг явдлыг явдлыг зогсоохгүй бол манайх арваад жил үндсэндээ 1 Сангийн сайдын дураараа дургиснаас болж асар том алдагдалд Монгол Улс орж байна. Өнөөдөр юмны үнэ нэмэгдээд л тэгээд л инфляц нь ихсээд л. Яг л ямар ч ийм эдийн засгийн мэдлэг, чадвар, боловсрол байхгүйгээр ингээд Засгийг түлхэж яваад би харамсаж байгаа юм. Та нарт бол баярлаж байгаа шүү.

**Ц.Даваасүрэн:** Хэн хариулах юм? 4 номер Дэлгэрсайхан.

**Ж.Дэлгэрсайхан:** Алтанхуяг гишүүний асуултад хариулъя. Зөвлөлийн гишүүн Дэлгэрсайхан байна.

Таны хэлсэн бидний яг макро эдийн засгийн таамаглалыг хүргүүлж байгаа бөгөөд түүнийг баримтлах шаардлагатай гэсэн хуулийн заалт байдаг. Хэрвээ баримтлаагүй бол тодорхой тайлбар өгүүлэх ёстой тухай бас хуульд заачихсан заалт байгаа. Харамсалтай нь түрүү жил бидний өгсөн тэр зүйлийг баримтлаагүй. Мөн дээрээс нь тайлбар бидэнд ирүүлээгүй бөгөөд яг энэ тал дээр хуулийн хэрэгжилт хангалттай түвшинд биш байна гэж харж байгаа. Тийм учраас бид таны хэлсэнчлэн энийг цаашид нь яаж илүү бодитойгоор хэрэгжүүлэх ийм боломж байна гэсэн саналыг ойрын хугацаанд боловсруулж танд хүргүүлье гэж бодож байна.

Тэгэхгүй бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргасан энэ дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах механизм одоогоор хуульд хангалттай биш байгаа гэж үзэж байгаа. Үүнээс болоод Улсын Их Хурал дээр харьцангуй тийм сайн биш, шаардлага хангаагүй макро эдийн засгийн нөхцөл байдалд нийцээгүй тийм төсөв орж ирэх, энэ нь саяын намрын төсвийн хэлэлцүүлэг шиг тийм томоохон эрсдэлийг үүсгэх ийм тохиолдлууд гарч байгаа гэж үзэж байгаа. Тийм учраас бидний зүгээс баримталж байгаа байр суурь бол төсвийн тусгай шаардлагуудыг хангах, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл буюу Улсын Их Хурлын байгууллагын гаргасан энэ зөвлөмж, дүгнэлтүүдийг, мөн макро эдийн засгийн дүгнэлтүүдийг баримтлах энэ боломж, хууль, эрх зүйн орон зайг илүү сайжруулах ёстой гэж үзэж байгаа. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Ер нь энэ ийм шүү. Үндсэн хуулийн цэц байгууллага биш шүү. Энэ байгууллага зүгээр л Их Хуралд зөвлөгөө өгөх байгууллага. Тэрнээс биш энэ энэ байгууллага шийдвэр гаргахаар тэрийг дагана гэдэг юм байхгүй. Төсвийн онцгой эрх зөвхөн бол Их Хуралд хадгалагдана. Биднийг төсөв батлахад л зөвлөгөө өгөх ёстой. Бусад улс орон чинь яг тийм байгаа. Бас яг ийм макро эдийн засгийн төсвийн дүгнэлтүүд гаргаж байгаа. Бид нар сая Япон, Солонгосоор би гишүүдээ явуулж үзүүлсэн шүү дээ. Заавал тэрийг дагана гэж алба байхгүй. Тэрийг бид нар харж, баримталж Улсын Их Хурлын гишүүн төсвөө яах вэ гэдгээ шийдэх л ёстой ийм л байгууллага байхгүй юу. Тэгж л ойлгож болно. Тэрнээс биш эднийх туйлын зөв гэдэг юм байхгүй.

Мөнхсоёл гишүүн асуултаа асууя. Алтанхуяг гишүүн. Алтанхуяг гишүүн.

**Н.Алтанхуяг:** Та бас тэгж доошоо унтрааж болохгүй л дээ. Энэ Төсвийн тогтвортой байдал гэж зөвлөл гэдэг бол зөвлөмж өгөх ёстой байгууллага мөн. Тэгэхдээ тэр зөвлөмжийг чинь эд нар чинь мэргэжлийн түвшинд гаргаад ирж байгаа энэ төсөөлөл Засгийн газрын хийчхээд байгаа улс төржсөн, эсвэл мэдлэг,

боловсрол нь дутсан, эсвэл сайдын нөлөө орсон энэ төсвүүд чинь ингэж балрах гээд байна гээд зөвлөмж өгөөд байхад бүүр таг чиг. Тэгээд яг өөрсдийнхөө бахь байдгаар зүтгүүлээд сая өнгөрсөн чуулган дээр нурж уналаа шүү дээ. Ерөнхийлөгч хориг тавиад, Их хурлын гишүүд ч зөндөө ярьсан.

Тэгэхээр эд нарын өгснийг дагах албагүй хуулиараа. Тэгэхдээ тэгвэл яагаад бид нар та нарын энэ өгсөн зөвлөмжийг огт тоохгүй байгаа юм бэ гэдгээ заавал бичгээр тайлбар өгөх ёстой. Тэрийг өгөөгүй л юм байна шүү дээ. Тэгж ойлгож байгаа зөв үү?

**Ц.Даваасүрэн:** Үгүй үгүй Их Хурал эд нарынхыг л хэрэгжүүлэх ёстой нь Их Хурал л байхгүй юу даа. Энэ чинь ингээд байгаа юм. Ингээд Засгийн газрын аманд битгий орооч л гэж л бид нарт эд нар тусалж өгч байна шүү дээ. Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг нь бидэнд гаргаад өгч байна. Тийм учраас тэр Засгийн газрын амаар явахгүй байх нь Их Хурлын ажил байхгүй юу.

Алтанхуяг гишүүнд 1 минут.

**Н.Алтанхуяг:** Үгүй ерөөсөө энэ толгой тархигүй, боловсролгүй, мэдлэггүй, чадваргүй энэ улсыг сөнөөдгийг харуулж байгаа байхгүй юу. Тэгээд энэ санхүү, эдийн засгийн хувьд, макро эдийн засгийн хувьд арай жаахан боломжийн хүмүүсээ цуглуулаад цалин өгөөд чи ажил хий гээд ингэчихсэн. Их Хуралд зөвлөх ёстой. Тэгвэл манай сая Батжаргал гишүүний хэлж байгаа шиг манай энэ 120 хэдэн хүнд зөвлөнө гэдэг өөрөө маш хэцүү ажил.

Тэгэхээр би арай хялбарчлаад энэ чинь бас Засгийн газар дээр очих ёстой байхгүй юу. Тэгээд энэ хоёрын зөрүү хэтэрхий их болсон тохиолдолд Засгийн газар заавал тайлбар өгдөг тийм байлгамаар байгаа юм. Тэр өөрчлөлтийг тэгээд хийгээч л гэж би хэлж байгаа юм. Ингэхгүй бол хайран толгой, хайран энэ мэдлэг боловсрол маань хаягдаад байгаа юм. Их Хурал чинь хэцүү та Төсвийн бодлогын байнгын хорооны дарга би таныг шоглоод яриад байгаа шүү дээ. Эхлээд та манай талд байсан төсвөө таная гээд, тун удалгүй дайсны талд орсон. Одоо ингээд тэр төсөв батлагдсан байхгүй юу. Ер нь Даваасүрэн.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Үгүй та тэгээд эсрэг талд явдаг юм тэр цөмийн хаягдал дээр тэгээд эсрэг байхад яадаг юм. Та дагаад л гараа өргөөд л дэмжчихсэн л байна лээ шүү дээ. Би харин эсрэг явсан шүү. Тэгж яривал. Битгий худлаа микрофон ашиглаж тэгээд байна. Яг бодит байдал дээр ямар байдаг гэдгийг би ч гэсэн яривал ярьж чадна шүү дээ. Байр суурин дээр байдаг байр суурин дээрээ л хүн байдаг байх хэрэгтэй шүү дээ. Та нар худлаа шүү дээ. Худлаа зүгээр тийм попрох маягаар хандаад байх юм.

Мөнхсоёл.

**Б.Мөнхсоёл:** Ажиллахгүй байх шиг байна. Өдрийн мэнд хүргэе. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн энэ хийж байгаа ажлынх нь ач холбогдол нь өндөр байгаасай гэж бас маш их хүсдэг.

Яагаад вэ гээл тэгэхээр Их Хурлын гишүүд ч хэлж байна энэ Улсын Их Хурлын Тамгын газрын гаргасан энэ дүгнэлт нь ч байгаа юм байна шүү дээ 2024 онд хийсэн ажлынх нь тайлан дээр үндэслээд ийм дүгнэлт гаргасан юм байна. Тэгээд Засгийн газарт болон Их Хуралд маш олон зөвлөмж эрсдэлээс хамгаалсан

ийм хувилбаруудыг бас санал болгосон юм байна. Хамгийн хайран нь авч хэрэгжүүлсэн нь маш бага байна. Тийм учраас яг бодит байдал дээр төсвийн хариуцлага алдагдсан байна, хяналт суларсан байна, олон алдагдсан боломж бий болгосон байна гээд дүгнэчихсэн байна шүү дээ.

Тэгэхээр та нараас асуух зүйл нь энэ бусад гишүүд бас хэлээд байна. Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хийж байгаа ажлын ач холбогдлыг сайжруулах ямар боломж, хувилбар байна гэж та нар өөрсдөө хардаг вэ? Жишээлбэл, магадгүй энэ гаргасан зөвлөмж нь хэрэгжээгүйгээс бодит байдал дээр учир авсан өртөг, зардлыг хэмжиж гаргаж ирээд энэ зөвлөлийн гаргасан дүгнэлт, зөвлөмжийг дагавал энэ байдал багасна гэдгийг бас тод яаруу ярьж хэлж байх ёстой юм болов уу. Энэ талаар та бүхэн маань юу гэж бодож байна?

Хоёрдугаарт Батжаргал гишүүний хэлж байгаачлан сургалт хийнэ гэж байгаа юм. Гэтэл сургалт дээр бас гишүүдийн оролцоо санасныг бодвол бас сайнгүй байх юм байна лээ шүү дээ. Энэ талаар дуугардаг маягийн гишүүд бас илүү оролцох шинжтэй юм байна лээ. Тэгэхээр энэ тал дээр магадгүй Төсвийн байнгын хороо Даваасүрэн дарга өөрөө ахалж байгаа юм чинь төсөв гэдэг чинь өөрийн энэ улс орны хөгжлийн бодлогыг зангидах гол хэрэгсэл нь мөн. Энэний ач холбогдол нь бүүр бусад энэ жижиг жижиг, тусад нь тусад нь ярьж байгаа төслүүдээс бүүр тэгж яривал 14 мега төслөөсөө хамгийн суурь гол асуудал нь юм гэдгийг ойлгуулж яривал бид нар бас энэ дээр ажиллавал чухал юм болов уу гэдгийг хэлмээр байна байна.

Гуравдугаарт нь энэ төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоо, иргэний нийгмийн байгууллагын оролцоо хүчтэй сайн байвал эргээд энэ шийдвэр гаргагчдаа том цохилт өгдөг, дохио өгдөг ийм байдаг. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь өөрөө эргээд иргэддээ иргэний нийгмийн байгууллагатайгаа хэр ойр хамтарч ажиллаж байна, тэднийхээ дэмжлэгийг хэр авах авах зорилготой байна. Энэ тал аар юу хийж байна гээд энэ талаар асууя. Уг нь бол энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг зөвхөн зөвлөмж өгөөд, судалгаа хийгээд орхих биш. Энэ гарч байгаа төсвийн сахилгагүй байдал, хяналтгүй байдлаас л мултрахын тулд л энэ бусад олон улсын жишээн дээр суурилж үүсгэсэн бүтэц шүү дээ тээ? Тэгээд яг ажлаа чанартай хийхэд дутагдаж байгаа зүйл байвал тэр.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Мөнхсоёл гишүүний асуултад 5 номер Энхбаяр дарга хариулъя.

**Н.Энхбаяр:** Гишүүний асуултад хариулъя. Бид өнгөрсөн хугацаанд бас мэдээж олон улсын байгууллагуудын бас өгч байгаа зөвлөмж, жишгүүдийг харсан. Өнгөрсөн сард Казакстанд төвтэй Олон улсын валютын сангийн сургалтын төвд манай гишүүн очоод бас яг энэ чиглэлээр болсон хурал зөвлөгөөнд оролцоод ирсэн. Тэр дээр бусад улс орнуудад үйл ажиллагаа явуулж байгаа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлүүдийн жишээг ярьж байна лээ. Тэр илтгэлийг нь би сонссон.

Тэгэхээр Европт жишээлбэл Испани, Словак гээд яг сайн жишээтэй үйл ажиллагаа нь жигдэрчихсэн ийм зүйлүүд байна. Сайн жишээнүүд бид суралцаж байгаа. Манай улсын тухайд бусад улсын сайн жишээг харсан ч гэсэн төсвийн тогтвортой байдлыг хангах гэдэг маань яг 1 байгууллагын үүрэг биш юм байна. Энэ бүхэл бүтэн тогтолцоо байх ёстой юм байна. Төсвийн тогтвортой байдлын

тухай хуулийн 3 дугаар бүлгийн 9 дүгээрт Улсын Их Хурлын бүрэн эрх байна, 10 дугаар зүйлд Засгийн газрын бүрэн эрх байна, 11 дүгээр зүйлд Засгийн газрын бусад байгууллагын бүрэн эрх байна. Эдгээр байгууллагууд шат шатандаа төсвийн тогтвортой байдлыг хангах үүрэг бас эрхтэй. Энэ болгон иж бүрэн цогцоороо байж байж энэ систем нь бидний хүсээд байгаа үр дүнд хүрэх юм байна.

Тэгэхээр бид өөрөөсөө хамаарах зүйлээ бид Улсын Их Хурлын дэргэд ажиллаад, шаардлагатай дүгнэлт, зөвлөмжөө өгөх чиглэлээр цаашдаа ч гэсэн түлхүү ажиллана. Дутагдаж байгаа зүйл бол хуульд заасны дагуу бид байнгын судалгаа хийх ёстой. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг гаргана гэдэг зөвхөн бэлэн болчихсон бичиг цаасан дээр гаргаж байгаа дүгнэлт биш. Өөрсдөө өргөн хүрээтэй судалгаа хийж, ирэх 3 жилийн таамаглалыг боловсруулах ёстой учраас энэ судалгааны ажлыг цаашид байнгын мэргэшсэн тогтвортой боловсон хүчин хийх ёстой. Энэ ажлаа эхний ээлжид хиймээр байна.

Хоёрдугаарт ажлын байрны хувьд ч гэсэн бид байгуулагдсанаасаа хойш 1 жил гаруй хугацаанд бусад байгууллагын түрээсийн 1 өрөөнд л сууж байна. Ажлын цагийн хувьд хязгаарлалттай. Өглөө 8:30-аас 18:30 хүртэл ажиллах боломжтой. 18:30-аас хойш бол тухайн байгууллагын шаардлагаар бид ажлын байраа орхиж явах шаардлагатай. Ийм байдлаар яг үйл ажиллагааг жигд явуулахад бас зарим талын бэрхшээлүүд байна. Бид өөрөөсөө хамаарах мэдээж судалгааны ажил, гишүүдийн сая хэлсэн, гишүүдэд хандсан, мэдээлэл өгөх, харилцан ярилцах энэ ажлаа цаашдаа өргөн хүрээтэй зохион байгуулна гэж бодож байна. Олон нийттэй ч гэсэн бид аль болохоор өргөн хүрээтэй харилцан ажиллая гэж бодож байгаа. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Мөнхсоёл гишүүн 1 минут тодруулъя.

**Б.Мөнхсоёл:** Ээлжит бус чуулганы үеэр хөгжлийн төлөвлөгөөтэй хамт орж ирэх ёстой байсан төсвийн тооцоо, судалгаа хийгдээгүй байсан. Одоо энэ байдал ямар явцтай байгаа вэ? Төсвийн ерөнхийлөн захирагчид буюу сайд нар өөрсдийнхөө ирэх 3 жилийн Төсвийн хүрээний мэдэгдэлд орох ёстой тооцоололдоо хүргүүлсэн болов уу төсвийн төсөөллөө?

**Ц.Даваасүрэн:** 5 номер Энхбаяр дарга хариулна.

**Н.Энхбаяр:** Одоо энэ 4 сарын 30-нд Засгийн газраас ирэх 3 жилийн төсвийн хүрээний мэдэгдлийг тооцоолоод өргөн барина. Бид энэ дээр дүгнэлтээ гаргах ёстой тэр хугацаанд өргөн барьсны дараа. Энэ ажлыг хийхийн тулд юу юу шаардлагатай вэ гэхлээр Засгийн газрын хийх ажлын зорилт маань маш тодорхой байх ёстой. Тэр зорилтод ямар хэмжээний хөрөнгийн эх үүсвэр шаардлагатай байх ёстой вэ гэсэн тооцоо байж байж энэ ирэх 3 жилийн хөрөнгийн хуваарилалт үр дүнтэй, ач холбогдолтой болно.

Тэр бодлого нь тусдаа, мөнгөний хуваарилалт нь ингээд 2 тэс хөндлөн зүйл хийвэл энэний ач холбогдол байхгүй болно. Нөгөө 14 мега төсөл гэж бид ярьж байгаа ч гэсэн энэ 14 мега төслийг хэзээ, ямар хугацаанд, аль нь түрүүлж ач холбогдлын хувьд түрүүлж явах вэ гэдэг байдлаар эрэмбэлэхгүй бол санхүүгийн хувьд энэ хөрөнгийн эх үүсвэрээ бид нар зөв хуваарилж чадахгүй болно.

Ийм учраас өнгөрсөн оны 8 сарын 27-нд Улсын Их Хурлаас баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах ёстой Улсын Их Хурлаас Засгийн газарт өгсөн үүрэг даалгавар ба Засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийн өртөг, зардлын тооцооллыг хийж танилцуул гэсэн үүрэг бичсэн байгаа. Одоо Төсвийн хүрээний мэдэгдлийг өргөн барихад энэ ажил хийгдэхгүй бол Төсвийн хүрээний мэдэгдэл маань.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Асуулт асууж дууслаа.

Үг хэлэх гишүүн байна уу?

Алга байна.

Манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бас харьцангуй бүрэлдэхүүний хувьд ч гэлээ гэсэн би боломжийн байгуулагдсан гэж ингэж бодож байгаа. Өнгөрсөн хугацаанд бас төсвийн талаар Улсын Их Хуралд туслалцаа үзүүлж ажиллах чиглэлд бас сайн ажилласан, гишүүд ч бас тэгж дүгнэж байгаа. Бие даасан байдлаар ажиллахыг эрмэлзсэн. Гэхдээ цаашдаа бас анхаарах зүйлүүд бол байна гэж. Төсвийн шинжилгээний алба гээд яг эднийтэй ижилхэн ийм юу бүтцийг бид нар уг нь байгуулсан юм. Төсвийн байнгын хорооны дэргэд байгуулсан. Одоо тэгсэн чинь нөгөөдхийг нь хуульд өөрчлөлт оруулаад Тамгын газрын дэргэд болгочихсон юм байна лээ. Төсвийн Тамгын газар бол төсвийн бас нэг л эрх захирагч. Төсвийн нэг эрх захирагч нөгөө эрх захирагчдаа дүгнэлт гаргадаг байж болохгүй. Тийм учраас энэ хуулийн энэ өөрчлөлтийг өөрчлөх шаардлагатай.

Ер нь энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Төсвийн алба хоёрыг нэгтгэх ийм зайлшгүй шаардлага байгаа юм бүтцийн хувьд. Эрх зүйн хувьд бас сайжруулах юмнууд байна. Тийм учраас би энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, энэ Төсвийн шинжилгээний алба энэ тэрийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бүтэц бүрэлдэхүүнийг ч бас бүтэц, цаашдын үйл ажиллагааны чиглэлийн ч гэлээ гэсэн бас сайжруулах чиглэлээр ажлын хэсэг байгуулаад хуулийн өөрчлөлтүүдийг хийе гэж ингэж бодож байгаа. Тийм учраас дараагийн хуралдаан дээр бол энэ чиглэлээр байгуулах ажлын хэсгийн саналыг оруулж ирнэ.

Өнөөдөр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг сонслоо. Хэлэлцэж дууслаа та бүгдийн цаашдын ажилд амжилт хүсье.

13.45 цаг

**Дөрөв дэх асуудал. Үндэсний аудитын газрын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэж эхэлье.**

Ажлын хэсгийг оруулаарай. Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудитын орлогч Я.Самбууням, Үндэсний Аудитын газрын Эрсдэлийн удирдлагын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Отгонбаяр, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Байгальмаа, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор, менежер Д.Нэргүйбаатар гэсэн хүмүүс оролцож байна.

Үндэсний аудитын газрын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн талаар Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав танилцуулна. 5 номерын микрофоныг өгье.

**Д.Загджав:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд өргөн дэвшүүлье.

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 8 дугаар тогтоолыг үндэслэн Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө сэдэвт аудитыг гүйцэтгэлээ.

Аудитад Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, 21 аймаг, нийслэлийн, Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, хяналт, тайлагналттай холбоотой үйл ажиллагааг хамруулж тайланг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн болно.

1.Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсөв, орлого бүрдүүлэлт, гүйцэтгэлийн талаар

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, улсын төсвөөс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 298 тэрбум 478.6 сая төгрөгөөр баталсан бөгөөд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого өссөнтэй уялдуулан хуульд 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 71 тэрбум 460.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 369 тэрбум 939.3 сая төгрөгөөр тодотгон баталжээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-аар Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т заасны дагуу 174 тэрбум 450.7 сая төгрөгийг нэмж, нийт 544 тэрбум 330 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр төлөвлөн баталснаас гүйцэтгэлээр 513 тэрбум 270.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж хэрэгжилт 94.3 хувьтай байна.

Тайлант онд Орон нутгийн хөгжлийн сангаас 10340 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 8672 төсөл, арга хэмжээнд 408 тэрбум 507.6 сая төгрөгийн санхүүжилт олгон жилийн эцсийн зарцуулаагүй үлдэгдэл 105 тэрбум 238.2 сая төгрөг байна.

Нийт олгосон санхүүжилтийн 69.9 хувийг барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засвар, бусад хөрөнгө худалдан авахад, 30.1 хувийг урсгал зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан байна. Аудитын аудит дээр нийт 162 тэрбум 768.3 сая төгрөгийн зөрчил илэрсэнд аймаг, нийслэл дэх төрийн аудитын газруудаас 550.8 сая төгрөгийн 62 төлбөрийн акт тогтоож, 76 тэрбум 245 сая төгрөгийн зөрчилд 384 албан шаардлага, 85 тэрбум 908.7 сая төгрөгийн зөрчилд 523 зөвлөмж өгч, 63.9 сая төгрөгийн зөрчлийг шалгуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах нэгдсэн дүгнэлтийг өгсөн. Үүнд,

Газрын тосны нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг 2023 онд бүрэн төвлөрүүлээгүйгээс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг дутуу санхүүжүүлсэн.

2.Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг эх үүсвэр тус бүрээр бүрэн төлөвлөх талаар санаачилгатай ажиллаагүй. Төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд иргэд олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааг хангалтгүй зохион байгуулсан.

3.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг хэт жижиглэснээр тендер оролцогчгүй болох, ажил он дамжих, хугацаа алдах сөрөг нөлөөлөл үүсгэсэн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд төсөл, арга хэмжээний үр дүн, үр өгөөжийг урьдчилан тооцолгүйгээр урсгал шинжтэй зардал төлөвлөн зарцуулж байгаа нь сангийн хөрөнгийн үр дүн, үр өгөөжийг бууруулсан.

Захиалагч талаас төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлага хүргэх хүртэх үр өгөөж, холбогдох тооцоо, судалгааг бодитой хийгээгүйгээс зарим аймагт чанаргүй, ашиглалтгүй хөрөнгө бий болж, тухайн орон нутагт ажлын байр нэмэх, иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, тэдний орлого нэмэгдэх боломж зарим талаар алдагдсан.

Эд бизнесийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцаж байгаа байгууллагын хяналт сулаас хөрөнгө эзэнгүйдэж, эвдэрч гэмтэн, ашиглалтгүй болж, хөрөнгийг дахин засаж сэлбэх, урсгал засвар хийх шаардлага үүсэж, төсвийн зардлыг нэмэгдүүлсэн.

Удирдлагын мэдээллийн системд төсөл, арга хэмжээний мэдээллийг дутуу болон огт оруулаагүй байхад сангаас санхүүжилт олгох зөрчил давтагдсаар байгааг таслан зогсох.

Шилэн данс дансны нэгдсэн цахим системд мэдээллийг дутуу, зөрүүтэй байршуулдаг, огт мэдээлэлгүй зөрчил нийтлэг байгаад иргэд, олон нийтийг үнэн зөв, бодитой мэдээллээр хангах боломжийг үгүйсгэж байна гэсэн дүгнэлтүүдийг тус тус хийсэн байна.

Аудитын дүнд үндэстэн дараах арга хэмжээг авч ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж, Улсын Их Хуралд толилуулж байна.

Монгол Улсын Их Хуралд толилуулах нь малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг бүсчлэн нэгдсэн байдлаар тогтоож, Төсвийн тухай хууль болон Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг авч хэлэлцэх.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийг батлахдаа иргэдийн саналыг авдаггүй. Өргөн мэдүүлсэн төсөл, арга хэмжээг өөрчлөн баталж байгаад дүгнэлт хийж, хууль дээдлэх ёсыг баримтлан холбогдох арга хэмжээ авч ажиллах.

## Сангийн яам

1.Ашигт малтмалын нөөц ашигласны ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос Орон нутгийн хөгжлийн санд олгох, шилжүүлэх, тооцох аргачлалыг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолд нийцүүлэн шинэчлэн батлуулах.

2.Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлага, мэдээллийн системийн гар утасны аппликэйшнээр иргэний оруулсан саналыг ил тод бүртгэх, нээлттэй мэдээлэл...

**Ц.Даваасүрэн:** Наадуул чинь энэ тайлан дээр байгаад дөө.

**Д.Загджав:** ...хөгжүүлэлт хийх.

**Ц.Даваасүрэн:** Бид нар уншчихсан шүү дээ.

**Д.Загджав:** Одоо дууслаа. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах холбогдох эрх зүйн баримт бичигт үүргийн хэрэгжилт хангуулах, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх зохицуулалтыг тодорхой тусгаж өгөх.

4.Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжилт олгохдоо Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 10.3.3 дахь заалтын дагуу тухайн зөрчлийг бүрэн арилах хүртэл санхүүжилт олгохгүй байх арга хэмжээг авч ажиллах, бүх шатны ИТХ-д 1, Засаг дарга дарга нарт 2 зөвлөмжийг тус тус өгч ажиллалаа.

Анхаарал тавьсанд баярлалаа. Танилцуулж дууслаа.

**Ц.Даваасүрэн:** Загджав даргад баярлалаа. Үндэсний аудитын газрын Орон нутгийн хөгжлийн сангийн 23 оны үйл ажиллагаанд хийсэн тайлангаас асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

Аудитын тайлантай холбогдуулж, Ганбаатар гишүүн байгаа юм уу? Ганбаатар гишүүн асуултаа асууя.

**Г.Ганбаатар:** Орон нутгийн хөгжлийн санд хийсэн гүйцэтгэлийн тайлантай танилцлаа. Гүйцэтгэлийн аудит. Газрын тосны нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлого 23 онд төвлөрөөгүйгээс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд ч орлого шилжүүлэх, дутуу шилжүүлсэн гэж байна тээ? Энэ яг аль аль аймгуудаар хэдий хэмжээний мөнгө дутуу шилжүүлчхэв?

**Ц.Даваасүрэн:** Ганбаатар гишүүний асуултад 5 номер Загджав дарга. 4 номер юм уу? 4 номер хэн билээ?

**Я.Самбууням:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Ерөнхий аудитын орлогч Самбууням байна.

Манай тайлангийн 10 дугаар хуудсан дээр байгаа Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны эх үүсвэрийн бүрдүүлэлтэд сая асуусан энэ газрын тосны салбараас олох орлого тасалдсаны улмаас гэж энэ дээр бол аймаг тус бүрээр нь бид гаргасан байгаа. Нийтдээ нийт дүнгээрээ бол 7 тэрбум 247.8 сая төгрөгөөр буюу 98 хувийн хэрэгжилттэй, 2 хувийн хангагдаагүй байгаа юм.

Тэгээд энэ аймгуудаар нь хэлэх юм бол энэ бол хамгийн бага хувьтай хэрэгжсэн нь Дорнод аймаг 94.8 хувьтай, хамгийн өндөр хэрэгжсэн нь 98.9 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнагдсан байгаа. Тайлангийн 10 дугаар хуудсанд аймаг бүрээрээ судалгаа гаргасан байгаа.

**Ц.Даваасүрэн:** Үг хэлэх гишүүн байна уу? Мөнхтулга гишүүн үг хэлье.

**П.Мөнхтулга:** Манай Аудитын газар энийг зүгээр анхаарчихвал энэ ийм дунд шатны удирдлагууд дээр хийдлүүд яваад байна лээ. Аймгийн төлөөлөгч нар орон нутгийнхаа төсвийг баталдаг тэгэнгүүтээ тэр баталсан төсвөөсөө өөрсдийнхөө компаниар орж тендер авдаг. Бүүр яг энэ аймгийн төлөөлөгчийн нэр дээр байгаа компани байгаа. Тэр компаниараа өөрийнхөө баталсан төсвөө өөрөө орж тендерээ гүйцэтгэдэг. Тэгээд энэ ер нь аудитын хуульд байдаг юм уу, байдаггүй юм уу? Ер нь энэ нэлээн том ашиг сонирхлын зөрчил яваад байгаа.

Тэгэхээр энэ дээр би нөгөө дүгнэлттэй нь танилцаж амжаагүй байгаа учраас энэ дээр гарсан дүгнэлт байгаа юу, үгүй юү? Асуултын хугацаа өнгөрчихсөн. Тэгэхдээ манайхан ер нь дунд шатанд ийм маш их завхралууд явж байгаа. Үүний тод жишээнүүд байгаа, бүүр жишээгээрээ байгаа. Энэ дээр манай аудитынхан анхаарч байгаарай л гэж хэлэх гэсэн юм.

**Ц.Даваасүрэн:** Гишүүд үг хэлж дууслаа.

Энэ бас гишүүд нэлээн анхааралтай хандах ёстой тайлангуудын нэг байгаа юм. Энэ удаа бас хөнгөхөндүү л хэлэлцүүлэг явчихлаа даа. Орон нутгийн хөгжлийн сан дээр ялангуяа орон нутагт ингээд тэр тайланд орчихсон байна лээ энэ хөрөнгө оруулалтын чиглэлийн арга хэмжээнүүдийг санхүүжүүлчихсэн иргэдээс санал авах тухай Төсвийн тухай хуулийн заалтыг огт хэрэгжүүлэхгүй.

Ер нь тэгээд л удирдлагын хүрээнд шийдээд яваад байгаа юмнууд байна. Төсвийнхөө хуулийн дагуу зарцуулахгүй байх гэсэн юмнууд ер нь нэлээн түгээмэл гарч байгаа. Гол хэсэг энэ Орон нутгийн хөгжлийн сан дээр байгаа учраас Орон нутгийн хөгжлийн сангийн энэ тайланг би Төсвийн тогтвортой байдлын зөвлөл рүү бас өгүүлчихье гэж байгаа юм. Энэ чиглэлтэй холбогдолтой энэ төсвийн хэтрэлт, төсвийн хууль бус зарцуулалттай холбогдолтойгоор бид нар бас цаашдаа авах арга хэмжээнүүдийг үргэлжлүүлээд яриад явах хэрэгтэй юм билээ Орон нутгийн хөгжлийн сан дээр. Энэ дээр нэлээн томоохон зөрчлүүд байгаа. Зогсоохгүй бол болохгүй. Бас анхаармаар юмыг нь энэ Аудитын дарга нар чинь яг тухайн нутгийнхаа хүн байгаад байгаа байхгүй юу.

Тэгээд нутгийн хүн нь тэгээд тэндээ аудитын шалгалт хийж байна гэж тийм олигтой юм болж өгөхгүй. Уг нь болдог сон бол хуучин тогтолцооны үеийнх шиг яг тухайн чиглэлээр нэлээн сайн мэргэшсэн өөр нутгийн хүмүүс байж байж л энэ дээр хяналт тавигдана уу гэхээс биш гол гол юмнуудыг бол бас дарагдуулаад л, хуйвалдаад л орон нутгийн удирдлагуудтай явчхаад байгаа юм.

Ер нь шалгалт хийсэн юм чинь мэдээж иймэрхүү зөрчлүүд гарна шүү дээ. Тийм хэмжээнд л өнөөдөр Орон нутгийн хөгжлийн сангийн хяналт шалгалт явагдаад байгаа юм. Энийг нэлээн сайн хийж, ухаж үзэх юм бол өчнөөн олон асуудлууд энэ Орон нутгийн хөгжлийн сан дээр бий.

Тийм учраас Орон нутгийн хөгжлийн сангийн дараа жилийн юм уу, дараагийн энэ хяналт шалгалтуудыг хийхэд бас нэлээн анхааралтай хандах, энэ бий болчихсон байгаа энэ зөрчил, дутагдлуудыг арилгахад анхаарахгүй бол орон нутаг дээр энэ дээр бол асар том дутагдлууд бий. Энийг бид нар бас цэгцлэхэд анхаарах ёстой.

Ингээд аудитын тайлантай холбогдуулаад гишүүд үг хэлж, асуулт асууж дууслаа.

Үндэсний Аудитын газрын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэж дууслаа.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх өнөөдрийн асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Баярлалаа гишүүд ээ.

14.00 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР